ББСБ-ын салбар арилжааны банкны салбараас илүү хурдтай өсч хөгжиж байгаа бол "Инвескор ББСБ" ХК нь салбартаа хамгийн өндөр өсөлттэй байгаа нь тогтвортой санхүүжилт, мэргэжлийн үйл ажиллагаа, технологид суурилсан шийдэл, автоматжуулалт, түргэн шуурхай үйлчилгээний үр дүн юм.

Компанийн засаглал

Зураг 1.7-1 "Инвескор ББСБ" ХК - IPO



Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хувийн хэвшлийн түүхэн дэх хамгийн том IPO-г амжилттай хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд компанийн засаглалын үндсэн тулгуур зарчмуудыг даган мөрдөж Монгол Улсдаа төдийгүй бүс нутагтаа зөв засаглал, зөв менежмент болон ил тод байдлаар үлгэр жишээ болж байна. "Инвескор ББСБ" ХК нь дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг бөгөөд засаглалын баримт бичгүүд нь хууль тогтоомж болон СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн тухай Хуулийн дүгнэлтийн 3 дугаар хэсэгт дурдсан байна.

Хүний нөөц

Гадаад, дотоодын банк болон санхүүгийн байгууллагуудад олон жил ажилласан туршлагатай, эерэг хандлагатай мэргэжилтнүүдээр багаа бүрдүүлдэг тул бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, мэргэжлийн байдлаараа тэргүүлж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ш.1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03

График 1.7-1 Үндсэн ажилтны тоо



Эрсдэлийн удирдлага

"Инвескор ББСБ" ХК-ийн хувьд эрсдэлийн удирдлагын бодлогыг 3 түвшинд хэрэгжүүлж, зээлийн эрсдэлийн бодлого, журам, бусад аргачлалуудын хувьд санхүүгийн салбартаа тэргүүлж байна. Үүний нотолгоо нь 2020 оны эцсийн байдлаар ББСБ болон санхүүгийн салбартаа чанаргүй зээлийн хувь хэмжээгээр хамгийн бага нь байна. Үндсэн шалтгаан нь зээлийн судалгаа, зээл олголтын үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан, мөн зээлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүний хүчин зүйлийг зохистой түвшинд барьж, олон улсын түвшний скоринг системийг ашигладагт оршино. Мөн зээлийн борлуулалт, судалгаа, олголт, хяналтын бүх түвшинд дарвалсан хяналтын систем ажиллахын зэрэгцээ зээлдэгчидтэй байнгын эргэх холбоотой ажилладаг тул асуудлуудыг түргэн шуурхай шийдвэрлэж болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлдэг.

Гадаад зах зээлд баримтлах "Санхүүгийн экспорт" стратеги

"Инвескор ББСБ" ХК нь өөрийн бизнесээ зөвхөн дотоод зах зээлээр хязгаарлахгүйгээр Монгол Улстай соёл болон бусад шинжээрээ нийтлэг, хөгжиж буй орнуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ экспортлох бодлого баримталдаг. Төв Азийн хөгжиж буй орнуудын зах зээлд өөрсдийн амжилт туршлага, финтек бүтээгдэхүүн, санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн давуу талаа ашиглан салбар компани байгуулах төлөвлөгөөний дагуу Киргиз Улсад хоёр охин компани байгуулж, үйл ажиллагааг нь амжилттай эхлүүлээд байна.

"Золотой Стандарт" МКК – "Инвескор ББСБ" ХК нь 2020 оны 1 дүгээр сард Киргиз Улсын "Золотой Стандарт" МКК-г худалдан авч 100 хувь эзэмших болсон. Хүний нөөцийг шинээр бүрдүүлж, компанийн бодлого журмуудыг шинэчлэн сайжруулж, CBS болон LOS системийг амжилттай нэвтрүүлсэн.

"Покет КГ" ХХК – 2020 оны 8 дугаар сард байгуулагдсан. Покет аппликэйшний Киргизийн зах зээлд зориулсан хувилбарыг хөгжүүлж нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр тус улсад нэвтрэх хамгийн анхны хэтэвчид суурилсан финтек, бичил зээлийн онлайн үйлчилгээ болох юм.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03

1.8. Эрсдэлийн удирдлага

"Инвескор ББСБ" ХК нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу эрсдэлийн удирдлагын цогц бодлого хэрэгжүүлдэг бөгөөд 2020 онд эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бататган сайжруулж, хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн бөгөөд, холбогдох хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн бодлого, журмуудаа шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны гол зорилго нь зохицуулагч байгууллагын хязгаарлалтын хүрээнд байгууллагын хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг удирдах эрсдэлийн төрөл тус бүрээр тодорхойлж тэдгээрийн хэрэгжилтийг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Гүйцэтгэх удирдлагын хороонд сар бүр тайлагнан ажиллаж байна.

Эрсдэлийн соёл

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо амжилттай суурилуулж, холбогдох бодлого журмуудаа шинэчилсэнтэй зэрэгцэн Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд болон холбоотой компаниудын бүхий л ажилтнуудыг хамруулсан "Эрсдэлийн соёл"-ыг түгээх шат дараалсан сургалтуудыг амжилттай зохион байгуулж ажилтан бүр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг эрсдэлийн менежер байх соёлыг түгээн ажиллаж байна.

Эрсдэлийн төрөл

"Инвескор ББСБ" ХК нь учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангилж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч ажилладаг. Үүнд:

Зээлийн эрсдэл: Үнэт цаас гаргагч нь зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлого болон холбогдох үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлуулж, байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь эрсдэлд суурилсан аргачлалаар харилцагчийг үнэлэх, зээл олгох шалгуурыг эрсдэлд суурилсан байдлаар тогтоох, харилцагчийг зээлийн эрсдэлд орохоос хамгаалах зэрэг хариуцлагатай, зөв зээлийн үйл ажиллагааг харилцагчдадаа хүргэх давуу талыг бий болгож байна. Үнэт цаас гаргагч нь хүлээн зөвшөөрөх зээлдэгчийн стандарт шаардлага болон зээлийн төрөл, бүтээгдэхүүн бүрээр эрсдэлийн хязгаарлалт, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг ялгаатай тогтоон хяналтыг хэрэгжүүлэх замаар зээлийн эрсдэлийг оновчтой удирдан ажиллаж байна.

Зээлийн төвлөрлийн эрсдэл: Үнэт цаас гаргагч нь зохицуулагч байгууллагын тогтоосон үйл ажиллагааны хязгаарыг ханган ажиллаж байгаа бөгөөд бизнесийн стратеги төлөвлөгөө, өөрийн үйл ажиллагааны онцлог, салбаруудын байршил, харилцагчдын сегмент зэрэгт тулгуурлан зээлийн багцын төвлөрлийг эдийн засгийн сектор болон бүтээгдэхүүний түвшинд ангилан тогтоож тэдгээрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Зах зээлийн эрсдэл: Үнэт цаас гаргагч нь санхүүгийн эрсдэлийг удирдах журмын дагуу хүүгийн болон валютын ханшийн эрсдэлийг удирдаж ажилладаг. Үүний тулд гадаад валютын актив пассивын зөрүүг үе шаттайгаар бууруулж, актив пассивын хүүгийн зохистой харьцааг хадгалах, эргэн төлөгдөх хугацааны зөрүүг бууруулах ажлуудыг гүйцэтгэж байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore CAPITAL
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore

СЭХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 31
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 02 03
БҮРТГЭВ-02

Өөрийн хөрөнгийн эрсдэл: Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн газар болон Хууль эрсдэлийн удирдлагын газар нь өөрийн хөрөнгийн эрсдэлийг удирдаж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилладаг. Уг газрууд нь өөрийн хөрөнгийн эрсдэлийг удирдах чиглэлээр Гүйцэтгэх захирал болон ТУЗ-д тухай бүр тайлагнаж үүрэг даалгавар авч ажилладаг.

Хөрвөх чадварын эрсдэл: Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн газар нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого журмыг боловсруулж батлуулах болон хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэдэг.

Үйл ажиллагааны эрсдэл: Үнэт цаас гаргагч нь хяналтад суурилсан үйл ажиллагааны эрсдэлийн тогтолцоог бий болгосноор аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын дотоод тогтолцоотой болж, ажилтнууд үүсч болзошгүй эрсдэлийн тохиолдлын талаар мэдээлдэг, эрсдэл бий болохоос өмнө сэргийлж чаддаг соёл руу шилжиж байна. Үүний тулд "Инвескор ББСБ" ХК-ийн нэгж бүр өөрийн хариуцдаг үйл ажиллагааны процессыг тодорхойлж, тухайн процесст оролцогчдын чиг үүргийг тодорхойлон байгууллагын үйл ажиллагааны эрсдэлээс амжилттай хамгаалан ажиллаж байна. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь процессын нэгдсэн тогтолцоотой болж газар нэгжүүд болон албан тушаалтнуудын чиг үүргийн давхардлыг арилгаж, үр ашигтай, үр дүнтэй хяналтын тогтолцоог бий болгож, хүнд биш процесст суурилсан бизнесийн тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Аюулгүй байдлын эрсдэл: Үнэт цаас гаргагч нь харилцагчдадаа шинэ технологид суурилсан хурдан шуурхай, сонирхол татсан өрсөлдөхүйц, хэрэглэгч төвтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож ажилладаг бөгөөд Мэдээлэл технологи, Мэдээллийн аюулгүй байдал, Цахим аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулан олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн мэдээллийн технологийн үйл ажиллагаагаа улам сайжруулж эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг илрүүлэх, тайлагнах, бууруулах, хянаж ажиллах тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Мөн харилцагчийн мэдээллийн нууцлалд онцгой анхаарах, бизнесийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор үйл ажиллагаандаа хэрэглэдэг бүхий л мэдээллийн системүүдийн нөөц бололцоог сайжруулж, шинэчлэх, дэвшилтэд технологиудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь бодит аюулгүй байдлын удирдлагыг аюулгүй байдлын заавар зөвлөмж гарган нийт ажилтнуудад мөрдүүлэх, Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөний дагуу онцгой байдлын үед ажиллах заавар зөвлөмжийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Үүний үр дүнд ажилтан бүр байгууллагад учирч болзошгүй бодит аюул занал, эрсдэлийн талаар ойлголттой болж өдөр тутмын үйл ажиллагаандаа урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэвшсэн.

Ёс зүйн эрсдэл: Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Бизнесийн болон Ажилтны баримтлах ёс зүйн дүрмийг батлуулж, ажилтан бүр дагаж мөрдөх, биелүүлж ажиллах үүргийг хүлээсэн бөгөөд ёс зүйн зөрчилтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэр гаргах процессыг тодорхой болгож улмаар Шүгэл үлээх журмыг боловсруулан гаргаж нийт ажилтнуудад таниулан, хэрэгжүүлж ажиллаж байна.

Хянан нийцүүлэлтийн эрсдэл: Үнэт цаас гаргагч нь хянан нийцүүлэлт хариуцсан ажилтныг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилон ажиллаж байгаа бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогыг толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан групп болон охин компаниудад нэгэн адил мөрдөн ажиллаж байна.

Комплаенс хариуцсан ажилтан нь Үнэт цаас гаргагч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үнэт цаас гаргагч ажилтан бүр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээлэлтэй байх зорилгоор жилд нэг удаа сургалтад заавал хамрагдсан байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргийг биелүүлэн ажиллаж байна.

"ИНВЕСКОР ХАНИТАЛ ТЦК" ХХК
InvesCore
0317389 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ☎1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 21
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

Нэр хүндийн эрсдэл: Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлага болон салбар нэгжийн удирдлагууд нь ажилтнууддаа ББСБ-ын нэр хүнд, үнэ цэнийн талаарх ойлголт мэдээллийг өгөх, нэр хүндийн эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалт мэдээллийг тогтмол өгдөг бөгөөд ажилтан бүр байгууллагын бизнес, үйл ажиллагаа, нэр хүндэд халдсан эсвэл учирч болзошгүй аюул занал байгааг илрүүлсэн, мэдсэн даруй өөрийн удирдлагад эсвэл Хууль, Эрсдэлийн удирдлагын газар болон Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх үүрэгтэй ба ингэснээр тухайн эрсдэлээс цаг алдалгүй сэргийлэх, бууруулах ач холбогдолтой.

Стратегийн эрсдэл: Гүйцэтгэх захирал нь ББСБ-ын эрхэм зорилго, үнэт зүйлсийн хүрээнд ББСБ-ын орлогын эх үүсвэрт эерэг, ашигтай байх бизнес төлөвлөгөө болон холбогдох шийдвэрийг гаргана. Гэвч эдийн засгийн, зохицуулагч байгууллагын эсвэл өрсөлдөөний зэрэг сөрөг нөлөөллүүд нь алдагдалд хүргэж болзошгүй байдаг тул стратегийн эрсдэлийг бүрэн бууруулах боломжгүй байдаг.

Стратегийн голлох шийдвэрийг хянан үзэх, сорих, батлах, Стратегийн үндсэн шийдвэрүүд болон шийдвэр гаргах үйл явцын талаар Гүйцэтгэх захирал болон удирдлагын багт санал, зөвлөмж өгөх нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг байна.

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн засаглал нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд

- Хамгаалалтын гурван бүс буюу эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.
- Засаглалын бичиг баримтууд буюу эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох эрсдэлүүдийг удирдах ерөнхий журмууд болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журам, стандарт болон заавар.
- Засаглалын хороод буюу ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих хороод.

Хамгаалалтын гурван бүс буюу эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь дараах байдлаар хуваарилагдсан байна.

Эрсдэлийн төрөл	Хамгаалалтын I бүс	Хамгаалалтын II бүс	Хамгаалалтын III бүс
Зээлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	Дотоод аудитын газар, Төлөөлөн удирдах зөвлөл
Зээлийн төвлөрлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Зах зээлийн эрсдэл	Санхүү хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Өөрийн хөрөнгийн эрсдэл	Санхүү хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Хөрвөх чадварын эрсдэл	Санхүү хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Үйл ажиллагааны эрсдэл	Бизнес/ Арын албаны нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Аюулгүй байдлын эрсдэл	Бизнес/ Арын албаны нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Ёс зүйн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Хуулийн нэгж	
Хянан нийцүүлэлтийн эрсдэл	Бизнес/ Арын албаны нэгжүүд	Хуулийн нэгж	
Нэр хүндийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Стратегийн эрсдэл	Гүйцэтгэх захирал	Төлөөлөн удирдах зөвлөл	

"ИНВЕСКОР КАПИТАЛ ТЮК" ХХК
InvesCore CAPITAL
6311119277128
ЧИНГЭТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

2021-05-27

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

Засаглалын бичиг баримтууд буюу эрсдэлийн удирдлагын бодлого, журмууд

№	Эрсдэлийн бодлого, журмууд	Хариуцах эзэн	Батлах эрх бүхий хороо
1	Эрсдэлийн удирдлагын бодлого	Хууль, эрсдэлийн удирдлагын газар	Төлөөлөн удирдах зөвлөл
2	Зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам / Зээлийн төвлөрлийн эрсдэл багтсан/	Хууль, эрсдэлийн удирдлагын газар	Удирдлагын хороо
3	Зах зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам	Санхүүгийн газар	
4	Өөрийн хөрөнгийн эрсдэлийг удирдах ерөнхий журам	Санхүүгийн газар	
5	Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах ерөнхий журам	Санхүүгийн газар	
6	Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах ерөнхий журам болон үйл ажиллагааны журам	Хууль, эрсдэлийн удирдлагын газар	
7	Аюулгүй байдлын эрсдэлтэй холбоотой журам, зааврууд	Үйл ажиллагааны газар, Мэдээлэл, технологийн газар	
8	Ёс зүйн эрсдэлтэй холбоотой журам, зааврууд	Хууль, эрсдэлийн удирдлагын газар	
9	Хянан нийцүүлэлтийн эрсдэлтэй холбоотой журам, зааврууд	Хууль, эрсдэлийн удирдлагын газар	

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
ЭВ-02

СЗХ
2021 .05. 27
БҮРТГЭВ
№ 01

1.9. Санхүүгийн тайлан

График 1.9-1 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, тэрбум төгрөг





График 1.9-2 Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа, тэрбум төгрөг





"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03

Хүснэгт 1.9-1 Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн орлогын тайлан

сая төгрөг	2016	2017	2018	2019	2020
Хүү болон түүнтэй адилтгах орлого	**665**	**4,476**	**10,794**	**19,363**	**29,148**
Хүү болон түүнтэй адилтгах зардал	**-**	**559**	**1,733**	**4,072**	**6,755**
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	**78**	**312**	**880**	**57**	**1,298**
Хүүгийн цэвэр орлого	**588**	**3,605**	**8,180**	**15,234**	**21,094**
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	23	166	324	2,600	450
Ажиллагсадтай холбогдолтой зардал	58	329	902	3,001	3,170
Үйл ажиллагааны бусад зардал	221	363	1,503	3,395	4,116
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (зардал)	112	(17)	78	159	87
Бусад олз (гарз)				(280)	(634)
Үйл ажиллагааны ашиг	**444**	**3,062**	**6,178**	**11,317**	**13,711**
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-	-	-	(110)	7
Татварын өмнөх ашиг (алдагдал)	**444**	**3,062**	**6,178**	**11,208**	**13,718**
Орлогын албан татвар	45	326	1,124	2,549	2,286
Зогсоосон үйл ажиллагааны алдагдал					28
Тайлант жилийн ашиг (алдагдал)	**399**	**2,737**	**5,054**	**8,659**	**11,460**
Эрсдлийн сангийн нөөц, гадаад валют хөрвүүлэлтийн олз (гарз)		(109)		16	(56)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)	**399**	**2,628**	**5,054**	**8,675**	**11,404**

Хүснэгт 1.9-2 Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

сая төгрөг	2016	2017	2018	2019	2020
ХӨРӨНГӨ					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	223	1,104	2,320	5,146	26,589
Хөрөнгө оруулалт	-	-	-	-	591
Харилцагчдад олгосон зээл (цэвэр)	4,162	17,164	33,627	60,645	92,548
Нийт зээл	*4,239*	*17,554*	*34,897*	*61,950*	95,291
Эрсдэлийн сан	*(78)*	*(390)*	*(1,270)*	*(1,305)*	*(2,742)*
Хүүний авлага	132	695	1,241	1,663	3,861
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	3600	1,534
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	540	418	1,056	822
Бусад санхүүгийн бус хөрөнгө	5	40	811	2,310	492
Үндсэн ба биет бус хөрөнгө	29	100	606	7,483	9,503
Нийт хөрөнгийн дүн	4,551	19,644	39,023	81,902	135,941
ӨР ТӨЛБӨР					
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,109	2,508	10,374	19,934	42,210
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	7,897	13,867	14,516	14,100
Бонд	-	-	-	-	7,879
Бусад өглөг	44	401	890	7,064	19,055
Нийт өр төлбөрийн дүн	**2,152**	**10,806**	**25,132**	**41,513**	**83,244**
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ					
Хувьцаат капитал	2,000	6,097	6,097	16,282	16,282
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	15,378	15,378
Хуримтлагдсан ашиг /(алдагдал)	399	2,741	7,794	8,729	21,037
Нийт өөрийн хөрөнгө	**2,399**	**8,837**	**13,891**	**40,389**	**52,697**
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	**4,551**	**19,644**	**39,023**	**81,902**	**135,941**

"Инвескор ББСБ" ХК нь СЗХ-ны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай" 85 дугаар тогтоолын дагуу нийт 8.2 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг биржийн бус зах зээл дээр амжилттай гаргаж арилжаалсан бөгөөд хүүгийн болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу төлж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
"ЭНЭРГО" ОЛОН ТОО
2021 -05- 03

Хүснэгт 1.9-3 Хаалттай хүрээнд гаргасан өрийн хэрэгслийн мэдээлэл

Нэрлэсэн үнэ	1,000,000 төгрөг
Нийт гаргасан	10,000 ширхэг буюу 10.0 тэрбум төгрөг
Хөрөнгө оруулагчдад худалдсан	8200 ширхэг буюу 8.2 тэрбум төгрөг (82%)
Зарагдаагүй үлдсэн буюу цуцлагдсан	2800 ширхэг буюу 2.8 тэрбум төгрөг (28%)
2020 онд төлсөн үндсэн төлбөрийн дүн	319,000,000 төгрөг
2020 онд төлсөн купоны дүн	414,176,027 төгрөг
2020.12.31 байдлаарх өрийн хэрэгслийн үлдэгдэл	7,881,000,000 төгрөг

Хүснэгт 1.9-4 Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн мөнгөн урсгалын тайлан

сая төгрөг	2016	2017	2018	2019	2020
Татварын өмнөх ашиг (алдагдал)	**444.0**	**3,062.3**	**6,177.6**	**11,207.6**	**13,718.3**
Бусад	3.3	930.0	3,904.9	4,478.3	10,732.3
Хүүгийн орлого		(4,476.5)	(10,781.1)	(19,363.0)	(29,207.3)
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг	**447.3**	**(484.2)**	**(698.8)**	**(3,677.2)**	**(4,756.7)**
Ажлын капиталын өөрчлөлт	**(4,299.2)**	**(13,883.3)**	**(18,006.8)**	**(27,662.5)**	**(30,214.0)**
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн урсгал	**(3,851.9)**	**(14,367.4)**	**(18,705.5)**	**(31,339.8)**	**(34,970.8)**
Төлсөн орлогын татвар	(4.3)		(761.0)	(1,874.2)	(2,563.9)
Хүлээн авсан хүү		3,913.4	10,247.9	13,276.3	25,209.5
Төлсөн хүү		(50.6)	(485.8)	(1,221.0)	(5,985.2)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**(3,856.2)**	**(10,504.6)**	**(9,704.4)**	**(21,158.6)**	**(18,310.5)**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**(32.3)**	**(83.0)**	**(554.8)**	**(1,345.8)**	**(4,846.3)**
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**2,095.9**	**11,476.3**	**11,475.1**	**25,246.4**	**44,672.8**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	**(1,792.5)**	**888.7**	**1,215.9**	**2,742.0**	**21,516.0**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,015.7	223.2	1,104.2	2,320.1	5,146.1
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(7.7)		84.0	(73.4)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**223.2**	**1,104.2**	**2,320.1**	**5,146.1**	**26,588.7**

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮНЭТ ЦААС" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

1.10. Санхүүгийн Тайланд Хийсэн Аудитын Дүгнэлт

"Инвескор ББСБ" ХК болон түүний охин компаниудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланд "БДО Аудит" ХХК нь аудит хийж, дүгнэлт гаргасан бөгөөд мөн Үнэт цаас гаргахтай холбоотойгоор Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд заасны дагуу дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн дагуу Үнэт цаас гаргагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь "Инвескор ББСБ" ХК-ийн 2020 оны аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэлтэй тохирч байна хэмээн дүгнэсэн байна. Аудитын компанийн дүгнэлт болон Үнэт цаас гаргагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланг танилцуулгад хавсаргасан болно.

ХУУДАС 43

1.11. Их Хэмжээний Хэлцэл, Түүний Хэрэгжилт

Хүснэгт 1.11-1: Үнэт цаас гаргагчийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэл /2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар/

№	Гэрээний тал	Утга	Гэрээний огноо	Тайлбар	Хэрэгжилтийн явц
1	Байгууллага	Зээлийн эрх нээх үндсэн гэрээ	2017.03.30	"Инвескор ББСБ" ХК нь өөрийн хувьцаа эзэмшигч болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-иас 25 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг 15 жилийн хугацаатай, бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар нээлгэсэн. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл хийх журам, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь зээлийн хүүг хуримтлуулж тооцон үндсэн төлбөртэй хамт зээлийн хугацааны эцэст төлнө.
2	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2017.11.09	Үнэт цаас гаргагч нь уг гэрээний дагуу 58 сая иений зээлийг 18 сарын хугацаатай олгосон бөгөөд 2020 оны 6 сарын 2-ны өдөр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж зээлийн хугацааг нь сунгасан. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.
3	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2018.07.27 2018.08.17	Үнэт цаас гаргагч нь уг гэрээнүүдийн дагуу нийт 43.1 сая иений зээлүүдийг тус бүр 1 жилийн хугацаатай олгосон бөгөөд 2020 оны 7 сарын 27-ны өдөр болон 2020 оны 08 сарын 18-ны өдөр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж тус зээлүүдийн хугацааг нь сунгасан. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.
4	Иргэн	Зээлийн эрх нээх гэрээ	2019.06.06	Үнэт цаас гаргагч нь уг гэрээний дагуу 1.3 сая ам.долларын зээлийг 1 жилийн хугацаатай олгосон байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.
5	Иргэн	Хөрөнгө оруулалтын удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2019.06.13	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө оруулалтын удирдах гэрээгээр харилцагчийн 900 сая төгрөгийг 2 жилийн хугацаанд оруулалтын удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт төлнө.

СЗХ
2021 05. 27
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

№	Гэрээний тал	Утга	Гэрээний огноо	Тайлбар	Хэрэгжилтийн явц
6	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2019.06.20	Үнэт цаас гаргагч нь уг гэрээний дагуу 1.5 сая ам. долларын зээлийг 1 жилийн хугацаатай олгосон бөгөөд 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж зээлийн хугацааг нь сунгасан байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.
7	Байгууллага	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2019.08.29	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр харилцагчийн 520 мянган ам долларыг 36 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.
8	Байгууллага	Биржийн бус зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ	2020.04.06	Үнэт цаас гаргагч нь биржийн бус зах зээлд 10 тэрбум төгрөг хүртэл үнийн дүнтэй өрийн бичгийг худалдах гэрээ байгуулсан. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь худалдан авагч нарын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа болно.
9	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2020.03.04	"Инвескор ББСБ" ХК нь Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан Зээлийн эрх нээх гэрээ болон Зээлийн эрх нээх нэмэлт гэрээний дагуу нийт 1.9 тэрбум төгрөгийн зээлийн эрх нээлгэсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд зээлийн төлбөрийн үлдэгдэлгүй.
10	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.04.24	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр харилцагчийн 300,000 ам.долларыг 12 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.
11	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2020.07.01	Үнэт цаас гаргагч нь уг гэрээний дагуу 4.8 тэрбум төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай олгосон байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.
12	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.07.06	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр харилцагчийн 900 сая төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
ИНВЕСКОР БББ ХК
InvesCore
6060854 1119266063
УЛААНБААТАР ХОТ

2021.05.27

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 ХУУДАС 45
БҮРТГЭВ-02

№	Гэрээний тал	Утга	Гэрээний огноо	Тайлбар	Хэрэгжилтийн явц
13	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.07.17	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 6.5 тэрбум төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.
14	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.09.03	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 2 тэрбум төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.
15	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.09.04	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 1.1 тэрбум төгрөгийг 24 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.
16	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.09.09	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 2.4 сая ам долларыг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.
17	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2020.09.21	Үнэт цаас гаргагч нь уг гэрээний дагуу харилцагч байгууллагад 2 тэрбум төгрөгийн зээлийг 24 сарын хугацаатай олгосон. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.
18	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.09.24	Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 10.0 тэрбум төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст байршуулсан итгэлцлийг өгөөжийн хамт эргүүлэн төлнө.
19	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2020.11.06	Үнэт цаас гаргагч нь уг гэрээний дагуу 491 мянган ам. долларын зээлийг 3 сарын хугацаатай олгосон байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317838 ... 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ... 1119286063
УЛААНБААТАР ХОТ

2021 .05. 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

№	Гэрээний тал	Утга	Гэрээний огноо	Тайлбар	Хэрэгжилтийн явц
20	Байгууллага	Хөренгө худалдах худалдан авах гэрээ	2020.12.25	Үнэт цаас гаргагч нь 9.95 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл бүхий Зээлийн хөренгийг худалдан авах тухай гэрээ байгуулсан. Хувь нийлүүлсэн хөренгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Худалдагч нь Үнэт цаас гаргагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа болно.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ⚓ 1119277129
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6959854 ⚓ 1119296063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ

1.12. Холбоотой Этгээдүүдийн Талаарх Мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн толгой, охин болон хараат компанийн тухай мэдээлэл болон тэдгээрийн холбоо хамаарлыг нотлох холбогдох баримтуудыг Хуулийн дүгнэлтийн 7 дугаар хэсэгт тусган оруулсан болно.

"Инвескор Хэтэвч ББСБ" ХХК /Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани/

"Покет" аппликэйшнээр харилцагчдад бичил зээлийг 24/7-ийн турш санал болгох бөгөөд мөн цахим хэтэвч болон төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. 2020 оны 3-р улирлын эцсийн байдлаар 40 мянган харилцагчийн 7.3 тэрбумын зээлийн багцтай байна.

"Покет КГ" ХХК /Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани/

Компани нь 2020 оны 8-р сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд Киргиз Улсын зах зээлд "Покет" цахим хэтэвчийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

"Золотой Стандарт" МКК /Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани/

Худалдаа, хөдөө аж ахуйн салбарын жижиг бизнес эрхлэгчдэд чиглэсэн Киргиз Улсад бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллага бөгөөд 2020 оны 3-р улирлын эцсийн байдлаар 199 харилцагчтай, 1.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн багцтай байна.

"Инвескор Лизинг" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/

2017 онд байгуулагдсан бөгөөд автомашин, үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжийн түрээс болон санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхэлдэг. Гадаадад амьдардаг Монгол иргэддээ зориулсан орон сууцны уян хатан нөхцөл бүхий лизингийн үйлчилгээг нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

"Инвескор Капитал ҮЦК" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/

2018 онд байгуулагдсан брокер, андеррайтер, зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч компани юм. 5 ажилтантай бөгөөд 2019 онд "Инвескор ББСБ" ХК-ийн IPO-г амжилттай зохион байгуулсан бөгөөд дотоодын 400, гадаадын 20 харилцагчтай.

"Инвескор Фанд" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/

2019 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгө оруулалт зуучлал, краудфандинг платформын үйл ажиллагаа эрхэлж байна. Платформын бэлтгэл ажлууд бүрэн хангагдаж зах зээлд нэвтрүүлэхэд бэлэн болсон.

"Инвескор Проперти" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/

2017 онд байгуулагдсан тус компани нь Монголын үл хөдлөх хөрөнгийн менежментийн чиглэлээр тэргүүлэгч компаниудын нэг юм. Нийт 25 ажилтантай бөгөөд дараах төслүүдийн борлуулалт, менежментийн үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

- Амбассадор Резиденс / VIP тансаг зэрэглэлийн орон сууц /
- Pro One / үйлчилгээтэй оффис /
- Хоймор /оффис /

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

2021 .05. 27
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03
БҮРТГЭВ-02

"Инвескор Жапан" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/

2019 онд байгуулагдсан бөгөөд Инвескор Санхүүгийн Группт санхүүгийн зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалт босгох үйлчилгээг үзүүлдэг. Түүнчлэн компани нь Япон Улс дахь "Инвескор ББСБ" ХК-ийн төлөөлөгчөөр ажиллаж, боломжит хөрөнгө оруулагчид, болон түншүүдтэй харилцаа тогтоож байна.

"Инвескор Эй Ай Лаб" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/

2018 онд байгуулагдсан бөгөөд хиймэл оюун ухаанд суурилсан программ хангамж боловсруулах, санхүүгийн бүх төрлийн системүүд хөгжүүлэх, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь дараах системүүд болон Финтекийн шийдлүүдийг амжилттай боловсруулсан. 2020 оны хагас жилийн байдлаар 21 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

- SMART LOS систем (зээлийн эх үүсвэр, зээлийн үнэлгээ, зээл батлах, зээлийн хяналт тавих систем)
- ПОКЕТ систем (онлайн зээлийн болон санхүүгийн үйлчилгээний бүрэн автоматжуулсан платформ)
- Японы хиймэл оюун ухааны хөгжүүлэгч Libera Inc.-тай хамтран хиймэл оюун ухаан дээр суурилсан зээлийн үнэлгээний систем
- "Инвескор Фанд" ХХК-д зориулсан краудфандинг ба P2P зээлийн платформ
- Инвескор" ББСБ ХК-ийн бусад системүүдийн интеграци

"Коло Тинкинг" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/

2020 онд байгуулагдсан бөгөөд мэргэжлийн дизайн, гэрэл зураг, маркетинг, сурталчилгааны чиглэлээр ажилладаг. Инвескор групп, Инвескор "ББСБ" ХК-н вэбсайт болон Покет аппликэйшний дизайныг хөгжүүлсэн.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 31
МОНГОЛЫН ХӨРЭНГ
MONGOLIAN STOC
2021 02 03
БҮРТГЭВ-02

1.13. Үнэт Цаас Гаргагчийн Ногдол Ашигийн Бодлого

Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулсан бөгөөд уг бодлогыг ТУЗ-ийн 2019 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн А/05-Т тоот тогтоолоор баталсан байна.

"Инвескор ББСБ" ХК-ийн ногдол ашгийн бодлогоор ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Ногдол ашиг хуваарилах нөхцөл

Үнэт цаас гаргагч нь дор дурдсан нөхцөл бүрэн хангагдаж байгаа тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа Үнэт цаас гаргагч төлбөрийн чадвартай байх, Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байх;
- Ногдол ашиг төлсний дараах Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, Үнэт цаас гаргагчийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Үнэт цаас гаргагч хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авах шаардагдах хөрөнгөтэй байх;
- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал нь Үнэт цаас гаргагчийн тогтвортой үйл ажиллагааг хангахуйц байх.

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах

Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. Хэрэв Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар өгнө.

Ногдох ашиг хуваарилах

Үнэт цаас гаргагч хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үндэслэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-өөс гаргах ба ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлийг тусгана. Үүнд:

- Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
- Ногдол ашиг олгох хэлбэр;
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- Ногдол ашиг төлөх өдөр;
- Бусад холбогдох асуудал.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ☎1119286
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 05 27 өдөр
БҮРТГЭВ
№1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 02 03
БҮРТГЭВ

Тайлагнах

Үнэт цаас гаргагч ногдол ашиг хуваарилсан талаар Нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмын дагуу санхүүгийн тайланд үнэн зөвөөр тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилалтын тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, тогтсон хугацаанд Хороо болон Биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ⁂1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore FINANCIAL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03

ХОЁР. ЗАХ ЗЭЭЛ

2.1. Макро Эдийн Засгийн Төлөв Байдал

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ИНФЛЯЦИ, ХАНШ

2020 оны эхэнд Ковид-19 цар тахал БНХАУ-д эрчимтэй тархаж байсан тул урд хил хаагдаж нүүрсний экспортыг саатуулсан бөгөөд голлох түүхий эдүүдийн үнэ дэлхийн зах зээл дээр буурсан. 2020 оны 11 сард Монгол улс нь дотооддоо вирусын халдварыг алдсанаас шалтгаалж Улаанбаатар хот болон зарим аймгуудад хөл хорио тогтоож эхэлсэн.

График 2.1-1 Бодит ДНБ: жилийн өөрчлөлт, улирлаар



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Монголбанк, Asian Development Outlook 2020 (ADB)

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол улсын эдийн засаг 2020 оны жилийн эцсийн байдлаар 5.3 хувиар агшсан байна. Харин 2021 онд 5.1 хувиар өсөх боломжтой гэж Азийн Хөгжлийн Банк таамагласан байна.

Судлаачдын таамаглаж буйгаар Монгол Улсын эдийн засгийн сэргэлт харьцангуй хурдан байх боломжтой бөгөөд гол хүчин зүйлүүд нь нүүрс, зэс, алтны экспорт, дотоодын хэрэглээ, хувийн секторын өсөлт байна.

Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны 12 дугаар сарын байдлаар жилийн 2.3 хувь, сарын -0.6 хувь байна. Жилийн инфляцийг авч үзвэл 2.1 нэгж хувийг хүнсний барааны бүлэг, 0.2 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.(Монголбанк)

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,849.99 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар суларсан үзүүлэлт байна. 2020 оны 12 сарын дундаж ханш нь 2,849.55 төгрөг байв.(Монголбанк)

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-05-03
СЭХ
2021.05.27
БҮРТГЭЛ

Мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүү

График 2.1-2 Бодлогын хүү(%)



Эх сурвалж: Монголбанк, Тев банкны үйл ажиллагааны статистик

Монголбанк 2020 оны 11 дүгээр сард бодлогын хүүг 8-аас 6 хувь хүртэл бууруулсан нь 2007 оноос энэхүү хэрэгслийг хэрэглэх болсноос хойш түүхэн доод түвшин юм. Түүнчлэн төгрөгийн заавал байлгах ёстой нөөцийн хэмжээг 2.5 хувиар бууруулж 6 хувь болгосон байна. Энэ нь цар тахлын үед банк болон санхүүгийн байгууллагын салбарт зах зээлийн мөнгөний урсгалыг сайжруулах мөн учирч болзошгүй эрсдэлийг зөөлрүүлэх зорилготой юм. 2016 оноос хойш бүтээгдэхүүний бодлогын хүү буурч байгаа бөгөөд үүнийг дагаад зээл болон хадгаламжийн хүү буурсаар байна. Хадгаламжийн хүү буурснаар иргэд болон ААН-үүдийн хувьд хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүнийг илүү сонирхож эхэлж байна. Мөн, зээлийн хүү буурснаар зах зээлийн мөнгөний эргэлт ихсэж, санхүүгийн өсөлтийг дэмжих болон тогтворжуулахад эерэг нөлөө үзүүлэх юм.

График 2.1-3 Мөнгөний нийлүүлэлт



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

2021 онд цар тахлын сөрөг нөлөөлөлтэй тэмцэх болон эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор мөнгөний тэлэх буюу зөөлөн бодлого үргэлжилнэ гэж таамаглаж байна. Мөнгөний тэлэх бодлогын үр дүнд арилжааны банкнуудын зээл, хадгаламжийн хүү буурах мөн төгрөгийн ханшид сулрах нөлөөлөл үзүүлэхээр байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
8317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesC

СЭХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
ХУУДАС 53

Монголбанк уул уурхайн бус экспортын болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжихэд зориулсан урт хугацаат санхүүжилт олгох зорилгоор 2 жилийн хугацаатай репо санхүүжилтыг 2020 оны 11 сараас олгож эхэлсэн.

Төлбөрийн тэнцэл

График 2.1-4 Нийт тэнцэл, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

2020 оны 4-р улиралд нийт төлбөрийн тэнцэл 1,259 сая ам.долларын ашигтай гарсан байна. Цаашдаа буюу 2021 онд экспортын идэвхжлээс шалтгаалж төлбөрийн тэнцэл эерэг байх боломжтой байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 4,534 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 10.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Монгол Улсын нийт гадаад өр 2020 оны жилийн эцсийн байдлаар 32.2 тэрбум ам.доллар байгаа бөгөөд 10.9 тэрбум ам.доллар, хувийн секторынх 21.3 тэрбум ам.доллар байна. 2021 онд төлөх Мазаалай бондын дийлэнх хэсгийг 2026 онд төлөгдөх жилийн 4.5% хүүтэй Номад бондоор дахин санхүүжүүлсэн тул 2021 онд өөр томоохон бондын эргэн төлөлт байхгүй байна.

Арилжааны банк

Цар тахалтай холбоотойгоор зах зээлд арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад зээлийн нөхцөл өөрчлөх, хугацааг сунгах, мөн эргэн төлөлтийг хойшлуулах шаардлага тулгарсан. Хэдийгээр харилцагчдын хүсэлтээр зээлийн гэрээний хугацааг сунгаж үндсэн төлбөрийг хойшлуулж байгаа ч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувь нэмэгдэж байна. Арилжааны банкуудын чанаргүй зээлийн хувь нь 2020 оны эцсийн байдлаар 11.7% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 нэгжээр нэмэгдсэн үзүүлэлт юм.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317039 1119277123
УПАЛХБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БРОК" ХК
УПАЛХБААТАР ХОТ

ХЭХ
2021 05 27
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
ХУУДАС 54
B-02

График 2.1-5 Шинээр олгосон зээлийн ЖДХ (сараар)



Эх сурвалж: Монголбанк

Арилжааны банкнуудын зээлийн багц 2020 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.9 хувиар буурсан буюу 18.0 их наяд төгрөгөөс 17.2 их наяд төгрөг болсон байна. 2020 онд арилжааны банкнуудын дотоод Credit standard буюу Зээлийн шалгуур индекс илүү чангарсан гэж Монголбанк үзэж байна.

График 2.1-6 Шинээр татсан хадгаламжийн ЖДХ (жилээр)



Эх сурвалж: Монголбанк

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
ББСБ-02

СЭХ
2021 оны 05 сар 27 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2.2. ББСБ-ын Салбар

Үндсэн үзүүлэлтүүд

ББСБ-ын салбар нь Монгол Улсын санхүүгийн сектор дотор хамгийн өндөр өсөлттэй яваа салбар юм. Сүүлийн 5 жилийн дотор ББСБ-ын салбарын нийт актив 3.2 дахин өссөн бол банкны салбар энэ хугацаанд 2 дахин, даатгалын салбар 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 2.2-1 ББСБ хөрөнгө, зээл /тэрбум.төг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ын салбарт "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК, "Ти Финанс ББСБ" ХХК, "Нөмөр Кредит ББСБ" ХХК, "Мобифинанс ББСБ" ХХК, "Лэндмн ББСБ" ХК, "Ашид Капитал ББСБ" ХХК, "Ард Кредит ББСБ" ХК зэрэг 15 компаниуд финтект суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчийн тоо 2018 оноос огцом өсч 2020 оны эцсийн байдлаар 2.9 саяд хүрээд байна. Өөрөөр хэлбэл өмнө нь ББСБ-аар үйлчлүүлж байгаагүй харилцагчид технологид суурилсан шинэ бүтээгдэхүүнийг хэрэглэж, банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг болж байна.

График 2.2-2 ББСБ орлогын тайлан /тэрбум.төг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 -05- 27
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХЭМЖИГДЭХ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03

Хүснэгт 2.2-1 ББСБ салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2016		2017		2018		2019		2020	
Нийт актив	787.2	26%	969.2	23%	1,285	33%	1,730	35%	2,007	16%
Зээлийн багц	436.1	22%	5а82	33%	870	49%	1,233	42%	1,327	8%
Өөрийн хөрөнгө	578.5	36%	758.2	31%	977	29%	1,261	29%	1,451	15%
ББСБ тоо	518	15%	534	3%	539	1%	538	-0.2%	532	-1.1%
Харилцагчийн тоо мян.	592	-7%	1471	148%	1,601	9%	2,855	78%	2,845	-0.3%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 532 ББСБ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 30, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 77, зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 38 ББСБ байна.

Олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байгаа бол шинэ технологи, финтект суурилсан онлайн зээлийн үйлчилгээг нийт 15 ББСБ үзүүлж байна. ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн 75.5 хувийг 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 176 ББСБ бүрдүүлж байна.

Зээлийн багц, чанар

2020 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын зээлийн багц 1,327.0 тэрбум төгрөг байгаа ба үүний 97 хувь нь төгрөгөөр, 3 хувь нь валютаар олгосон зээл байна. Тайлант хугацаанд мөн нийт 104.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулснаар 1,222.6 төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарчээ.

2020 онд ББСБ-ууд 1.6 их наяд төгрөгийн зээл олгож, 1.5 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 84.8 хувь буюу 1,125.7 тэрбум төгрөг нь хэвийн зээл, 4.9 хувь буюу 64.9 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл, 10.3 хувь буюу 136.4 тэрбум төгрөг нь чанаргүй зээл байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар ББСБ салбарын нийт зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 87.7 хувиар өсч 788,058-д хүрсэн байна. Цаг хугацаатай уралдаж үйл ажиллагаагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэл болон бизнес эрхлэгчдийн хувьд ББСБ-ууд нь зээлийн шийдвэрийг түргэн шуурхай гаргадаг учраас илүү эрэлт хэрэгцээнд нь нийцэж байна.

Нийт олгосон зээлийн 62.1% буюу 994.3 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлд, 12.0% буюу 192.9 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 62.7% буюу 951.5 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлээс, 13.2% буюу 200.9 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ. ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү нь 2016 оны 3-р улирлаас эхлэн тогтмол буурч байгаа ба 2020 оны жилийн эцсийн байдлаар сарын 2.8% байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2021 -05- 03

2.3. Бизнесийн Үйл Ажиллагааны Төсөөлөл

"Инвескор ББСБ" ХК нь 2021 онд нийт орлогын хэмжээгээ 78 хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд зээлийн хүүгийн орлогоос гадна шинээр нэвтрүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэлээс уг өсөлтийг бүрдүүлнэ.

Хүснэгт 2.3-1 Орлогын тайлангийн төлөвлөгөө (мянгаар)

Үзүүлэлт /сая төгрөг/	2021	2022	2023
Хүү болон түүнтэй адилтгах орлого	**41,471.1**	**55,655.5**	**75,181.6**
Хүү болон түүнтэй адилтгах зардал	**(13,097.2)**	**(18,976.6)**	**(23,216.7)**
Бусад хүүгийн зардал	(6,850.9)	(9,150.2)	(9,597.2)
Бондын хүүгийн зардал	(936.5)	(2,660.0)	(1,723.5)
Итгэлцлийн үйл ажиллагааны зардал	(5,309.9)	(7,166.4)	(11,896.0)
Хүүгийн цэвэр орлого	**28,373.8**	**36,678.9**	**51,964.9**
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	11,069.7	14,330.5	16,262.0
Гадаад валютын арилжааны орлого/зардал			
Нийт хүүгийн бус цэвэр орлого	**11,069.7**	**14,330.5**	**16,262.0**
Нийт үйл ажиллагааны орлого	**39,443.6**	**51,009.4**	**68,226.9**
Ажиллагсадтай холбогдолтой зардал	(5,212.1)	(5,628.4)	(6,080.0)
Үйл ажиллагааны бусад зардал	(6,620.1)	(7,108.7)	(8,020.3)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардал			
Нийт үйл ажиллагааны зардал	**(11,832.2)**	**(12,737.1)**	**(14,100.3)**
Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, алдагдал	**27,611.4**	**38,272.3**	**54,126.6**
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	(1,414.9)	(793.6)	(805.7)
Гэрэгэ Эстимэйт ХХК нь үнэт цаасны зах зээлд үнэлгээний үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг, Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй хуулийн этгээд болно. Үнэлгээчид нь ажлын даалгаварт өгсөн хөрөнгийн үнэлгээ хийх туршлагатай гэдгээ үүгээр баталж байна. Д. Гантулга Мэргэшсэн Үнэлгээчдийн Рояал Институт (RICS)-ийн гишүүн үнэлгээчин бөгөөд нь энэ үнэлгээний ажлыг удирдан ажиллаж үнэлгээний тайланг бэлтгэв. Д.Ганбаатар нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг бөгөөд хөрөнгийн үнэлгээний ажлын 10 орчим жилийн туршлагатай үнэлгээчин болно. Гантулга, Ганбаатар нар нь Монгол улсын мэргэшсэн үнэлгээчид болно. Үнэлгээчний сертификатын хуулбарыг Хавсралт 1-д үзүүлэв.

Энэхүү үнэлгээний ажил нь Инвескор Бондын эргэн төлөлтийн чадавхийг тооцоолох болон түс бондын эргэн төлөлтийн баталгаа хөрөнгийн үнэлгээ хийх зорилготой болно.

Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа ашиг сонирхлын зөрчил байхгүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг зөвхөн Инвескор Бондыг Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргах үйл ажиллагаанд Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компаниудад зориулан боловсруулсан бөгөөд үнэлгээний үр дүнг өөр зорилгоор эсхүл бусад этгээд өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараахыг хориглоно.

Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон түс компанитай холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн нэрийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг хөрөнгийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 05 26
ГЭРЭГЭ эстимэйт
БҮРТГЭВ-02

СЭХ
2021.05.27
БҮРТГЭЛ
№ 01

Ашиглалтын нөхцөл ба хязгаарлалтууд

Аливаа байгууллагын санхүүгийн ирээдүйн мөнгөн урсгалын төсөөллийн тооцоолол нь тодорхой түвшний тодорхойгүй байдлыг өөртөө агуулж байдаг. Учир нь ирээдүйн мөнгөн урсгал нь ирэх жилүүдэд болох зарим үйл явдлаас, тухайлбал зохицуулах болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэр, инфляцын өөрчлөлт, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөх боломжтой.

Түүнчлэн үнэлгээний өдрийн байдлаар дэлхий даяар тархсан КОВИД-19 цар тахлын эдийн засаг, бизнест үзүүлэх нөлөө нь мөнгөн урсгалын ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдлыг улам бүр ихэсгэж байна.

Инвескор ББСБ нь бонд гаргасны дараах үеийн өөрсдийн боловсруулсан ирээдүйн санхүүгийн төсөөллийг бидэнд танилцуулсан болно. Бид Инвескор ББСБ-ын санхүүгийн төсөөлөлд хараат бус шинжилгээ хийж гүйцэтгэсэн бөгөөд энэхүү төсөөлөл нь өнөөдрийн нөхцөл байдалд харьцангүй бодитой, биелэх боломжтой төсөөлөл гэж дүгнэсэн болно. Бидний хийсэн шинжилгээний үр дүнг энэ тайлангийн 5-р бүлэгт үзүүлэв.

Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, таамаглалууд нь үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангүй бодит тооцоолсон гэж үзэж байна.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглалууд болон бусад хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.

3. ИНВЕСКОР ББСБ ХК-ИЙН ТУХАЙ

Компанийн тухай

Инвескор ББСБ нь 2016 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар Монгол Улсад 13 салбар, Киргиз улсад 2 охин компани, нийт 155 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос зээл, хөрөнгө оруулалт ба санхүүгийн зөвлөгөө, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаа эрхлэх зэрэг тусгай зөвшөөрөлтэй, санхүүгийн зах зээл дээр 7 төрлийн зээлийн бүтээгдэхүүн, 5 төрлийн санхүүгийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Инвескор ББСБ ХК-ийн 85%-ыг Монгол улсад бүртгэлтэй "Эс Ай Би Жэй Капитал" ХХК эзэмшдэг бөгөөд 15% нь Монголын хөрөнгийн бирж дээр олон нийтийн эзэмшилд байна. Инвескор ББСБ ХК нь Инвескор Хэтэвч ХХК, Покет Киргиз, Инвескор Киргиз (Киргиз улс дээрх банк бус санхүүгийн байгууллага) компаниудыг 100% эзэмшдэг бөгөөд Инвескор Лизинг ХХК, Инвескор Капитал ҮЦК ХХК, Инвескор Эй Ай Лаб ХХК, Инвескор Фанд ХХК, Инвескор Проперти ХХК зэрэг компаниудтай зэргэлдээ компани болно.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 05 27
БҮРТГЭВ-02
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05-27
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
БҮРТГЭВ-02

Инвескор ББСБ ХК нь 24 сарын хугацаатай, жилийн 12% - 14%-ийн энгийн хүүтэй, 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000 хүртэлх, нийт 20.0 тэрбум төгрөг хүртэлх нээлттэй өрийн хэрэгсэл буюу бондыг Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргаж байна.
Бондын хүүг хагас жил тутам, үндсэн төлбөрийг хугацааны эцэст хийх ба Инвескор ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 4-р сарын 7-ны өдрийн А/09-Т дугаар тогтоолоор бондыг Санхүүгийн Зохицуулах Хороо бүртгэснээс хойш 6 сарын хугацаанд багтаан хэсэгчлэн гаргах ба бондыг хэсэгчлэн гаргах хугацаа, хэмжээг тухай бүрд нь тус компанийн Гүйцэтгэх захирал тогтоохоор шийдвэрлэсэн байна.

Инвескор Бондоор татсан эх үүсвэрийг тус компанийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаанд зориулна.

Инвескор Бондын эргэн төлөлтийн барьцаа хөрөнгө: "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй Инвескор ББСБ ХК-ийн 12,000,000 ширхэг энгийн хувьцаа.

Санхүүгийн үзүүлэлт

Санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлт болох нийт хөрөнгө, өөрийн хөрөнгө, өр төлбөр нь 2016 оноос хойш тасралтгүй өсөж 2020 оны эцсийн байдлаар нийт хөрөнгө 135.9 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 52.7 тэрбум төгрөг, өр төлбөр 83.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 1: Инвескор ББСБ-ын санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүд



Компанийн үйл ажиллагааны цар хүрээг илтгэх зээлийн үлдэгдэл, нийт орлого, цэвэр ашгийн хэмжээ мөн тасралтгүй өсөж 2020 оны эцэст нийт зээл 95.3 тэрбум төгрөг, нийт хүүний орлого 29.2 тэрбум төгрөг, цэвэр ашиг 11.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317039 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 01

2021 05 ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
БҮРТГЭВ-02

Зураг 2: Инвескор ББСБ-ын ашигт ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд



Нийт хөрөнгө хөрөнгөд эзлэх өр төлбөрийн харьцаа 2016 оноос хойш тогтмол өндөр байгаа нь үйл ажиллагааны тэлэлтэд бусдаас татсан эх үүсвэр чухал нөлөө үзүүлсэнтэй холбоотой гэж үзэж болно. Инвескор ББСБ-ын санхүү, хөрөнгө оруулалтын үндсэн харьцаа үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1: Инвескор ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаануүд

Санхүүгийн үндсэн харьцаануүд	2016	2017	2018	2019	2020
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	8.8%	13.9%	13.0%	10.6%	8.4%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	16.6%	31.0%	36.4%	21.4%	21.7%
Зээл/Нийт хөрөнгө	93.2%	89.4%	89.4%	75.6%	70.1%
Өөрийн хөрөнгө/Зээл	56.6%	50.3%	39.8%	65.2%	55.3%
Өр төлбөр/Зээл	50.8%	61.6%	72.0%	67.0%	87.4%
Өр төлбөр/Нийт хөрөнгө	47.3%	55.0%	64.4%	50.7%	61.2%
Ү.а зардал / Ү.а орлого	16.2%	14.5%	18.2%	37.2%	31.9%
Хүүгийн орлого/Зээл	31.4%	41.1%	41.2%	40.0%	30.5%
Ашиг/Зээл	9.4%	15.6%	14.5%	14.0%	12.0%
Ашиг/Хүүгийн орлого	60.0%	61.1%	46.8%	44.7%	39.1%

Инвескор ББСБ ХК-ийн зах зээлийн үнэлгээ

Инвескор ББСБ нь 2019 оны 6-р сард нийт хувьцааны 15%-ийг Монголын хөрөнгийн бирж дээр олон нийтэд санал болгон арилжиж "Инвескор ББСБ ХК" хувьцаат компани болсон. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар тус компанийн нэгж хувьцааны хаалтын ханш 2,961 төгрөг, зах зээлийн үнэлгээ 212.4 тэрбум төгрөг байна[1].

Инвескор ББСБ ХК-ийн хувьцааны үнийн хөдөлгөөнийг доорх зурагт үзүүлэв.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ☎1119256063
УЛААНБААТАР ХОТ

[1] http://mse.mn/mn/company/553

СЗХ 2021.05.27 БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ БҮРТГЭВ-02

Зураг 3: Инвескор ББСБ ХК-ийн хувьцааны үнэ, 2019.06.10-с хойш



4. ЭДИЙН ЗАСАГ, ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эдийн засаг

Өнгөрсөн арван жилд Монгол улсын ДНБ-ний бодит өсөлтийн дундаж 9% байсан ба 2011 онд хамгийн өндөр буюу 17.5%-д хүрч байсан бол 2016 онд 0.1% болтлоо буурсан байна. ДНБ-ний бодит өсөлт 2019 онд 5.1%, 2020 онд -5.3% байсан бол "Trading economics" байгууллагын судалгаагаар 2021 онд 5.1% байхаар таамаглаж байна[2].

Зураг 4: Монгол Улсын бодит ДНБ-ний жилийн өсөлт



Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн бодит болон урьдчилсан таамаглалыг дараах хүснэгтэд харуулав[3].

Хүснэгт 2: Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Бодит	2021-II	2021-III	2021-IV	2022-I	2022
ДНБ өсөлт, %	-5.3	6.5	6.5	5.1	5.1	5.1
Ажилгүйдлийн хувь, %	7.6	10	8.5	8.5	7.5	7.5
Инфляцийн хувь, %	2.6	4	4.5	4	3.6	4
Зээлийн хүү, %	6	6	6	6	6.25	7
Худалдааны тэнцэл /сая доллар/	412.3	35	31	350	350	350
ДНБ-д эзлэх засгийн газрын өр, %	55	82	82	82	82	82

Банк бус санхүүгийн зах зээл

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны мэдээллээр[4] 2008 онд 131 тусгай зөвшөөрөлтэй Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) бүртгэлтэй байсан бол 2020 онд 532 болж өсжээ. ББСБ-нь нийт 9 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх боломжтой. Үүнээс

[2] https://tradingeconomics.com/mongolia/gdp-growth-annual
[3] https://tradingeconomics.com/mongolia/forecast
[4] http://www.frc.mn/resource/frc/Document/2021/02/21/cru1ecq9vvnjwr01/negtgel%202020q4%20-%20site.pdf

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК 6317829 1119277128 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК 6000854 УЛААНБААТАР ХОТ

2021 - ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
БҮРТГЭВ-02
2021 05 27

зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 494 байгууллага, итгэлцлийн үйл ажиллагаа эрхэлж буй 43 компани байна.

Салбарын нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол өсөж 2020 оны эцсийн байдлаар нийт хөрөнгө 2.0 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө 1.5 орчим их наяд төгрөгт, нийт өр төлбөр 556.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 5: ББСБ-ын салбарын санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүд



2020 оны эцсийн байдлаар ББСБ-ын салбарын нийт зээл 1.3 их наяд төгрөг, нийт хүүгийн орлого 337.9 тэрбум төгрөг, нийт цэвэр ашиг 154.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 6: ББСБ-ын салбарын ашигт ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд



ББСБ-ын салбарын цэвэр ашгийг хүүгийн орлогод харьцуулсан харьцаа 2016 оноос хойш харьцангуй тогтвортой буюу 45.0% орчим байна. ББСБ-ын салбарын санхүү, хөрөнгө оруулалтын үндсэн харьцаа үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3: ББСБ-ын салбарын санхүүгийн үндсэн харьцаанууд

Санхүүгийн үндсэн харьцаанууд	2016	2017	2018	2019	2020
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	7.5%	6.9%	7.9%	8.1%	7.7%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	10.2%	8.8%	10.3%	11.1%	10.7%
Зээл/Нийт хөрөнгө	55.4%	60.1%	62.6%	66.6%	61.1%
Өөрийн хөрөнгө/Зээл	132.6%	130.3%	121.5%	109.5%	109.3%

"ИНВЕСКОР КАПИТАЛ ХХК"
"ИНВЕСКОР ББСБ" ХК

Өр төлбөр/Зээл	47.9%	36.3%	38.2%	40.7%	41.9%
Хүүгийн орлого/Зээл	33.9%	31.8%	31.4%	29.9%	27.3%
Өр төлбөр/Нийт хөрөнгө	26.5%	21.8%	23.9%	27.1%	27.7%
Ашиг/Зээл	13.5%	11.5%	12.6%	12.2%	11.7%
Ашиг/Хүүний орлого	43.5%	41.2%	46.5%	48.0%	45.8%

Банк бус санхүүгийн салбарыг банкны салбартай харьцуулсан байдал

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар өсөж, банкны салбарын 5.5%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин их байгаа нь ББСБ-ууд өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой.

2020 оны эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар буюу 276.8 тэрбум төгрөгөөр өсөж 2.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 46.1 хувийг мөнгөн хөрөнгийн өсөлт, 25.5 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 68.5 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 4: Банк болон ББСБ-ын салбарын харьцуулалт

Үзүүлэлтүүд	2019	2020	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1730.1	2006.9	16.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	4.8%	5.5%	0.7%
Нийт өөрийн хөрөнгө	1261.2	1450.7	15.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	41.6%	47.4%	5.8%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	927.0	1017.7	9.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	120.6%	132.2%	11.6%
Нийт зээл	1233.1	1327.0	7.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	6.9%	7.5%	0.6%
Нийт орлого	352.9	408.8	15.8%
Нийт зарлага	212.7	254.0	19.4%
Цэвэр ашиг	140.2	154.8	10.4%

Инвескор ББСБ-ын салбартаа эзлэх хувь

Инвескор ББСБ-ын салбарт эзлэх хувь санхүүгийн үндсэн үзүүлэлт бүрээр байгуулагдсанаас хойш буюу 2016 оноос хойш өсөж иржээ. 2020 оны эцсийн байдлаар цэвэр ашгийн үзүүлэлтээр салбарын нийт цэвэр ашгийн 7.4%-г эзэлж байна.

Хүснэгт 5: Инвескор ББСБ-ын нийт салбарт эзлэх хувь

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019	2020
Нийт хөрөнгө	0.6%	2.0%	3.0%	4.7%	6.8%
Өөрийн хөрөнгө	0.4%	1.2%	1.4%	3.2%	3.6%
Зээлийн хэмжээ	1.0%	3.0%	4.3%	5.4%	7.2%
Нийт орлого	0.4%	2.4%	4.5%	6.4%	7.3%
Цэвэр ашиг	0.7%	4.1%	5.0%	6.2%	7.4%

5. ҮНЭЛГЭЭ

Инвескор ББСБ-ын 2023 он хүртлэх санхүүгийн төсөөллийг доор үзүүлэв.

Санхүүгийн төсөөлөлд хийсэн шинжилгээ

Зээлийн үйл ажиллагаа

Инвескор ББСБ-ын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголтын төсөөллийн эхлээд авч үзэв. Тайлант хугацааны эцсийн байдлаарх зээлийн үлдэгдлийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа нь тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны чадамж (efficiency) илэрхийлнэ. Энэ харьцааны үзүүлэлтээр (Хүснэгт 1 болон Хүснэгт 3) өнгөрсөн жилүүдэд Инвескор ББСБ нь салбарын үзүүлэлтээс тогтмол өндөр байгаа нь тус компанийн амжилттай ажиллаж ирсэн үндсэн хүчин зүйлсийн нэг гэж дүгнэж болно. Харьцааны өнгөрсөн статистик болон ирээдүйн төсөөллийг доор үзүүлэв.

Зээл/Нийт хөрөнгө:

2017-2019 оны дундаж	2020	2021	2022	2023
84.8%	70.1%	74.4%	80.0%	82.7%

Өнгөрсөн 3 жилд Инвескор ББСБ нь дундажаар нийт хөрөнгийн 84.8%-ийг зээлийн үйл ажиллагаанд зориулж ирсэн ба 2020.III улирлын байдлаар энэ нь 67.0% хүртэл буурсан нь КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн тодорхойгүй байдал болон эрх бүхий байгууллагуудын шийдвэрүүдийн нөлөөллийг тооцоолох зорилгоор тус компанийн авч хэрэгжүүлсэн эрсдэлийн бодлоготой шууд хамааралтай байна. 2020 оны IV улиралд зээл гаргалтыг нэмэгдүүлснээр энэ харьцаа өсөж жилийн эцсийн байдлаар 70.1% болсон байна.

Төрөөс хэрэгжүүлж байгаа КОВИД-19 цар тахлын эдийн засгийн нөлөөг бууруулах бодлогын арга хэмжээний үр дүнд эдийн засгийн идэвхижил сэргэх, ингэснээр иргэд, байгууллагын зээлийн эрэлт ирэх жилүүдэд сэргэх хүлээлттэй байна. Энэ нөхцөл байдалд Инвескор ББСБ нь 2021 онд зээл олголтын үйл ажиллагааг нэмэгдүүлж энэ харьцааг 74.4%-д, харин 2022, 2023 онд ихсэж харгалзан 80.0%, 82.7%-д хүргэхээр төсөөлж байгаа нь өнгөрсөн 3 жилийн дундаж үзүүлэлт болох 84.8%-иас бага байгаа тул энэ нь харьцангуй бодит, биелэх боломжтой төсөөлөл гэж бид дүгнэж байна.

Хүүгийн орлого

ББСБ-уудын жинэлэсэн дундаж зээлийн хүү 2016 оны 3-р улирлаас эхлэн тогтмол буурч 2020 оны эцсийн байдлаар 2.8% байгаа ба банкны салбартай харьцуулахад 1.4 нэгжээр өндөр байна.

КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийг идэвхижлийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк нь бодлогын хүүг 2020 оны 3 сард 11%-с 10%, 4 сард 9%, 9 сард 8%, 11 сард 6% болгон тус тус бууруулсан нь богино хугацаандаа банкуудын хадгаламжийн хүүг бууруулах, цаашлаад зээлийн хүүг бууруулах байдлаар нөлөөлөх боломжтой. Харин ирэх жилүүдэд зээлийн хүү нь Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал, зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч тогтоно гэж үзэж болно.

Зээлийн хүүг гүйцэтгэлээр буюу жилийн хүүний орлогыг тухайн жилийн зээлийн дундаж хэмжээнд харьцуулан сараар тооцсон дүнг доор үзүүлэв.

Хүүгийн орлого/Дундаж зээлд харьцуулсан харьцаа, сараар:

2017-2019 оны дундаж	2020	2021	2022	2023
3.4%	2.7%	2.7%	2.5%	2.4%

Өнгөрсөн 3 жилд хүүгийн харьцааны дундаж сард 3.4% байсан бол 2020 оны эцсийн байдлаар 2.7% болсон байна. Инвескор ББСБ-ын ирэх 3 жилийн санхүүгийн төсөөлөлд энэ харьцаа харгалзан 2.7%, 2.5%, 2.4% байгаа нь өнгөрсөн 3 жилийн дундаж үзүүлэлт болох 3.4% болон 2020 оны эцсийн байдлаарх салбарын жинэлэсэн дундаж зээлийн хүү болох 2.8%-иас бага байгаа нь үнэлгээний өдрийн байдлаарх хүүгийн орлогын төсөөлөл нь харьцангуй бодит, биелэх боломжтой төсөөлөл гэж бид дүгнэж байна.

Үйл ажиллагааны зардал

Инвескор ББСБ-ын үйл ажиллагааны нийт зардал 2020 оны эцсийн байдлаар 7,286.1 сая төгрөг байгаа нь нийт үйл ажиллагааны орлогын 31.9%-ийг эзэлж байна. Харин 2017 – 2019 онд энэ харьцаа дундажаар 23.3% байсан байна. Инвескор ББСБ нь үйл ажиллагааны зардлын харьцааг ирэх 3 жилд харгалзан 30.0%, 25.0%, 20.7% болж буурахаар төсөөлсөн байна. Мэдээллийг доор үзүүлэв.

Сая төгрөгөөр

Хугацаа	2017-2019	2020	2021	2022	2023
Нийт үйл ажиллагааны орлого		22,842.6	39,443.6	51,009.4	68,226.9
Нийт үйл ажиллагааны зардал		(7,286.1)	(11,832.2)	(12,737.1)	(14,100.3)
Ү.а зардал / Ү.а орлого	23.3%	31.9%	30.0%	25.0%	20.7%

Инвескор ББСБ-ийн үйл ажиллагааны зардалын төсөөлөл нь үйл ажиллагааны орлоготой харьцуулахад цаашид ихээр буурахаар байгаа тул бид зардлыг 3 хувилбар дэвшүүлж зохих тооцооллыг хийж үзсэн болно.

Энэхүү ажлын хүрээнд авч үзсэн үйл ажиллагааны зардлын харьцааны хувилбаруудыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6: Үйл ажиллагааны зардлын хувилбарууд

Хувилбарууд	2017-19 дундаж	2020	2021	2022	2023	Тайлбар
Инвескор ББСБ	23.3%	31.9%	30.0%	25.0%	20.7%	Төсөөллийн харьцаа
Хувилбар 1	23.3%	31.9%	31.9%	31.9%	31.9%	2020 онтой ижил авах
Хувилбар 2	23.3%	31.9%	27.6%	27.6%	27.6%	Дундажаар авах
Хувилбар 3	23.3%	31.9%	23.3%	23.3%	23.3%	2017-19 дундажтай ижил авах

Зээлийн эргэн төлөлтийн чадавхийн тооцоолол

Энэхүү үнэлгээний ажлын зорилготой уялдуулан үнэлгээний дүгнэлт гаргахад Инвескор Бондын эргэн төлөлтийн чадавхийн шинжилгээг хийж гүйцэтгэв. Энэ ажлын хүрээнд *Хүүгийн төлбөр биелүүлэх харьцаа* (Interest coverage ratio, ICR) *болон Зээлийн төлбөр биелүүлэх харьцаа* (Debt-service coverage ratio, DSCR)-нуудыг Хүснэгт 6-д үзүүлсэн үйл ажиллагааны зардлуудын хувилбар бүрээр тооцоолж шинжилэв.

Хүүгийн төлбөр биелүүлэх харьцаа (Interest coverage ratio, ICR) нь тухайн тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааны цэвэр орлого нь нийт зээлийн болон бусад өр төлбөрүүдийн хүү, шимтгэлийн зардлыг хэр биелүүлэх төлбөрийн чадавхийг харуулна.

$$\text{Хүүгийн төлбөр биелүүлэх харьцаа } (ICR) = \frac{\text{Үйл ажиллагааны цэвэр орлого}}{\text{Хүү түүнтэй адилтгах зардал}}$$

Зээлийн төлбөр биелүүлэх харьцаа (Debt-service coverage ratio, DSCR) нь тухайн тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааны цэвэр орлого нь нийт зээлийн болон бусад өр төлбөрүүдийн үндсэн төлбөрийг хүүний хамт хэр биелүүлэх төлбөрийн чадавхийг харуулна.

$$\text{Зээлийн төлбөр биелүүлэх харьцаа } (DSCR) = \frac{\text{Үйл ажиллагааны цэвэр орлого}}{\text{Үндсэн төлбөр болон хүүний зардал}}$$

Инвескор бонд нь жилийн 12% - 14%-ийн хүүтэй бөгөөд хүүний дээд хэмжээ болох 14%-д харгалзах тооцооллын үр дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7: ICR ба DSCR харьцааны тооцооллын үр дүн, сая.төгрөгөөр

	2021	2022	2023	Нийт
Хүү болон түүнтэй адилтгах орлого	41,471.1	55,655.5	75,181.6	172,308.2
Хүүгийн бус цэвэр орлого	11,069.7	14,330.5	16,262.0	41,662.2
Нийт орлого	**52,540.8**	**69,986.0**	**91,443.6**	**213,970.4**
Нийт үйл ажиллагааны зардал				
Инвескор төсөөлөл	(11,832.2)	(12,737.1)	(14,100.3)	(38,669.6)
Хувилбар 1	(12,581.3)	(16,270.5)	(21,762.3)	(50,614.1)
Хувилбар 2	(10,882.8)	(14,073.8)	(18,824.3)	(43,780.9)
Хувилбар 3	(9,184.2)	(11,877.2)	(15,886.2)	(36,947.6)
Үйл ажиллагааны цэвэр орлого				
Инвескор төсөөлөл	40,708.6	57,248.9	77,343.3	175,300.8
Хувилбар 1	39,959.5	53,715.5	69,681.3	163,356.3
Хувилбар 2	41,658.0	55,912.2	72,619.3	170,189.5
Хувилбар 3	43,356.6	58,108.8	75,557.4	177,022.8
Бонд бусад өр төлбөрын эргэн төлөлт				
Хүү түүнтэй адилтгах зардал	13,097.2	18,976.6	23,216.7	55,290.5
Төлсөн зээл	2,670.0	3,349.9	20,375.9	26,395.8
Нийт төлбөр	**15,767.2**	**22,326.5**	**43,592.6**	**81,686.3**
Хүүгийн төлбөр биелүүлэх харьцаа (ICR)				
Инвескор төсөөлөл	3.1	3.0	3.3	3.2
Хувилбар 1	3.1	2.8	3.0	3.0
Хувилбар 2	3.2	2.9	3.1	3.1
Хувилбар 3	3.3	3.1	3.3	3.2
Зээлийн төлбөр биелүүлэх харьцаа (DSCR)				
Инвескор төсөөлөл	2.6	2.6	1.8	2.0
Хувилбар 1	2.5	2.4	1.6	2.0
Хувилбар 2	2.6	2.5	1.7	2.1
Хувилбар 3	2.7	2.6	1.7	2.2

Инвескор ББСБ-ын *Хүүгийн төлбөр биелүүлэх харьцаа* (ICR) нь Инвескор Бондын эргэн төлөлт хийж дуусах хугацаанд дундажаар 3.2, үйл ажиллагааны зардлын хувьд авч үзсэн хувилбаруудын хувьд хамгийн багадаа 2.8 байгаа нь жилийн хүүгийн төлбөрийг хийх чадавхи өндөр байгааг харуулна.

Зээлийн төлбөр биелүүлэх харьцаа (DSCR) нь Инвескор Бондын үндсэн төлбөр хийх 2023 онд Инвескор ББСБ-ын төсөөллөөр 1.8, бидний авч үзсэн хувилбарын хувьд хамгийн багадаа 1.6 болж байгаа нь Инвескор Бондын эргэн төлөлтийг гүйцэтгэх чадавхи сайн байгааг илтгэнэ.

Инвескор Бондын эргэн төлөлт хийх санхүүгийн чадавхи сайн байгаа нэг хүчин зүйл нь тус компани нь бондоос гадна итгэлцлийн гэрээгээр санхүүгийн эх үүсвэр татаж зээлийн үйл ажиллагаанд зарцуулдагтай холбоотой. Тухайлбал, 2023 онд Инвескор ББСБ-ийн итгэлцлийн үйлчилгээний өглөг 47.4 тэрбум төгрөгөөр өсөж нийт үлдэгдэл 110.3 тэрбумд хүрэхээр төлөвлөж байна.

Инвескор ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний өглөг 2023 онд 110.3 тэрбум төгрөгт хүрч тоон дүнгээр өндөр байхаар төсөөлж байгаа ч нийт хөрөнгө болон нийт өр төлбөрт эзлэх хувиар харгалзан 30% болон 51% байгаа нь 2020 оны түвшинд байгаа тул биелэх боломжтой төсөөлөл гэж үзэж байна.

Дүгнэлт

Дээрх судалгаа шинжилгээнд үндэслэн бид дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Инвескор ББСБ-ын санхүүгийн тайланд туссан хөрөнгө болон өр төлбөрүүд нь зах зээлийн бодит үнэ цэнээр тусгагдсан байна.
2. Инвескор ББСБ-ын 2023 он хүртэлх санхүүгийн төсөөлөлд туссан хөрөнгө болон өр төлбөрийн үзүүлэлтүүд нь үнэлгээний өдрийн байдлаар харьцангуй бодит, биелэх боломжтой гэж дүгнэж байна.
3. Инвескор ББСБ нь Инвескор Бондын хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг төлөвлөсөн хугацаанд хийх санхүүгийн чадавхи сайн байгаа гэж дүгнэж байна.

Зээлийн эргэн төлөлтийн барьцаа хөрөнгийн үнэлгээ

Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.6-д заасны дагуу өрийн хэрэгслийн эргэн төлөлтийн баталгаа хөрөнгийн үнэлгээг энд хийж гүйцэтгэв.

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9011739005, Регистрийн дугаар: 6057209) нь "Инвескор ББСБ" ХК-ийн нийт гаргасан 71,727,918 ширхэг энгийн хувьцааны 85 хувьтай тэнцэх 60,968,730 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг бөгөөд үлдсэн 15 хувьтай тэнцэх 10,759,188 ширхэг хувьцааг олон нийт эзэмшиж байна.

Инвескор бондын эргэн төлөлтийн барьцаа хөрөнгөөр "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй Инвескор ББСБ ХК-ийн 12,000,000 ширхэг энгийн хувьцааг тавихаар шийдвэрлэсэн байна.

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Монголын Хөрөнгийн Бирж дээрх Инвескор ББСБ ХК-ийн тус компанийн нэгж хувьцааны хаалтын ханш 2,961 төгрөг байна. Инвескор

ББСБ ХК-ийн хувьцаа 2020 онд харьцангуй тогтвортой байгаа бөгөөд хувьцааны үнийн хөдөлгөөнийг Зураг 3-д үзүүлэв.

Барьцаа хөрөнгийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар болон өнгөрсөн хугацаанд харгалзах хувьцааны дундаж ханшид харгалзах байдлаар тооцоолж үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8: Барьцаа хөрөнгийн үнэлгээ

Үзүүлэлт	Нэгж хувьцааны арилжааны хаалтын ханш	Тоо хэмжээ	Үнэ цэнэ	Бонд ба барьцаа хөрөнгийн харьцаа
	төгрөг	*ширхэг*	*төгрөг*	*%*
Үнэлгээний өдөр буюу 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар				
Хаалтын ханш	2,961.00	12,000,000	35,532,000,000	56.3%
Сүүлийн 4 долоо хоног буюу 2020 оны 12-р сарын дүнгээр				
Дундаж	2,918.19	12,000,000	35,018,285,714	57.1%
Хамгийн доод	2,850.00	12,000,000	34,200,000,000	58.5%
Хамгийн дээд	2,961.00	12,000,000	35,532,000,000	56.3%
Сүүлийн 52 долоо хоног буюу 2020 оны дундаж дүнгээр				
Дундаж	2,644.57	12,000,000	31,734,884,462	63.0%
Хамгийн доод	2,140.00	12,000,000	25,680,000,000	77.9%
Хамгийн дээд	2,961.00	12,000,000	35,532,000,000	56.3%

Инвескор Бондын барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 35 тэрбум 532 сая төгрөг байхаар тооцоолов. Энэ нь Үнэлгээний Олон Улсад Стандартад тодорхойлсон Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолттой нийцнэ гэж үзэж байна. Нийт 20.0 тэрбум төгрөгийн дүн бүхий Инвескор Бонд нь үнэлгээний өдрийн байдлаарх барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийн 56.3%-тай тэнцүү байна.

Түүнчлэн, хугацааны өөр өөр интервал дахь Инвескор ББСБ ХК-ийн хувьцааны дундаж, хамгийн доод, хамгийн дээд дүнгүүдэд харгалзах барьцаа хөрөнгийн үнэ цэнэ болон Инвескор бондын дүнг барьцаа хөрөнгийн үнэ цэнэд харьцуулсан харьцааг Хүснэгт 8-д үзүүлэв.

Үнэлгээний өдрөөс хойших үеийн нөхцөл байдал

2021 оны 3-р сард Монгол Улсын Засгийн газраас "Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-г хэрэгжүүлж эхлээд байна. Энэ төлөвлөгөөний нэг хэсэг болгон төрийн өмчит "Эрдэнэс тавантолгой" ХК нь 2021.3.30-наас 2021.4.9-ны өдрийн хооронд төгрөгийн 10%, ам.долларын 6.8%-ийн жилийн хүүтэй ЭТТ бондыг Монголын хөрөнгийн бирж дээр гаргалаа. Хөрөнгийн биржийн мэдээлснээр ЭТТ бондын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан бөгөөд нийт иргэн, аж ахуйн нэгжээс 2,755,639 ширхэг захиалга ирүүлснээр 347.7 тэрбум төгрөг, банкуудын дахин санхүүжилтийн гэрээний дагуу 330 тэрбум төгрөг буюу нийт 677.7 тэрбум төгрөгийн багцын санхүүжилтийг бүрдүүлсэн байна.[5]

[5] http://mse.mn/mn/news/8448

Засгийн газрын 10 их наядын төлөвлөгөө нь цаашид эдийн засгийн салбарын зээлийн хүүг бууруулах нөлөө үзүүлэх боломжтой. Харин тайлангийн өдрийн байдлаар банкны салбарын болон банк бус санхүүгийн байгууллагуудын бизнесийн болон хэрэглээний зээлийн хүүнд энэ хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад материаллаг өөрчлөлт хараахан гараагүй байна.

Энэхүү үнэлгээний тайланд Инвескор Бондын хүүний дээд хэмжээ болох 14%-д харгалзах тооцоолол орсон бөгөөд Инвескор Бондын эх үүсвэрийн зардал 12% хүртэл буурах (эерэг нөлөөлөл), зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Инвескор ББСБ-ын зээлийн хүү тодорхой хэмжээгээр буурах (сөрөг нөлөөлөл) тохиолдолууд нь үнэлгээний дүгнэлтийг өөрчлөх хэмжээний нөлөөлөл үзүүлэхгүй гэж бид үзэж байна.

СЗХ
2021.05.27
БҮР

MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ эстимэйт
2021-05-20
БҮРТГЭВ-02

6. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1: Үнэлгээчдийн сертификатын хуулбарууд

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 091100154

Иргэний ургийн овог: [illegible]

Иргэний овог,нэр: Донцова [illegible] Гантулга

Иргэний үнэмлэхний дугаар: [illegible]

Иргэний бүртгэлийн дугаар: [illegible]

Үнэлгээчний гэрчилгээний дугаар: [illegible]

Иргэний хаяг: [illegible] 1-р хороо 18-10 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: [illegible] 255 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ..... / Ч.УЛААН /

УЛААНБААТАР ХОТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20.15 оны 344 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.15 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.БОЛОР /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20.18 оны 284 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.18 оны 12-р сарын 19-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277120
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021.05.27
БУРТГЭВ
№01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2021-05-20
БУРТГЭВ-02

Gantulga Donorov

on

31 October 2018

WAS ELECTED A **PROFESSIONAL MEMBER** OF
THE ROYAL INSTITUTION OF CHARTERED SURVEYORS

6824290

MEMBERSHIP NUMBER

PRESIDENT OF RICS

RICS

This diploma is held from year to year subject to the provisions of the bye-laws of the Institution.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6511839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БББББ" ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ эстимэйт
2021-05-20
БҮРТГЭВ-02

СЭХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 11

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 101200188

Иргэний үргийн овог: Хошуул

Иргэний овог нэр: Доноров овогтой Ганбаатар

Иргэний үнэмлэхний дугаар:

Иргэний бүртгэлийн дугаар: ОО77112572

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо хужир булан А-111 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 7 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ..... / Б.ЧОЙЖИЛСҮРЭН /

УЛААНБААТАР ХОТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 19 оны 262 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 19 оны 12 -р сарын 17 -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

3000286

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР

BDO

Tel: +976 77404040
Fax: +976 77404041
www.bdo.mn
Zip code: 14230-0059

Room 1502, Level 15
Union Building - B, Unesco Street
Narnii Zam - 62, Khoroo - 1
Sukhbaatar District, Ulaanbaatar
Mongolia

Утас: +976 77404040
Факс: +976 77404041
www.bdo.mn
ШНК: 14230-0059

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам - 62, ЮНЕСКО-гийн
гудамж, ЮНИОН БЮЛДИНГ Б блок
15 - р давхар, 1502 тоот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-05-03

2021 оны 04-р сарын 09 № 56/21 Улаанбаатар хот

Тулган баталгаажуулсан тухай мэдэгдэл

"БДО Аудит" ХХК нь "Инвескор ББСБ" ХК болон түүний охин компаниуд болох "Инвескор хэтэвч ББСБ" ХХК, "Инвескор актив" ХХК, "Золотой Стандарт ББСБ" ХХК, "Покет Киргиз ББСБ" ХХК - уудыг хамруулсан групп (цаашид "Групп" гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн болон "Инвескор ББСБ" ХК-ийн тусдаа санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд болон Нягтлан бодох бүртгэлийн томоохон гол бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүдэд аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бидний 2021 оны 03-р сарын 17-ны өдрөөр огноолсон аудитын тайланд тусгасан Группийн нэгтгэсэн (2021 оны 03-р сарын 17-ны өдрөөр огноолсон аудитын тайланд тусгасанчлан компанийн тусдаа) санхүүгийн тайлангууд нь компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд болон Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд нь бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

"Инвескор ББСБ" ХК нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалахаар төлөвлөж буй "Инвескор бонд" нээлттэй өрийн хэрэгсэл гаргах ажиллагаатай холбогдуулан бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь "Инвескор ББСБ" ХК-ийн 2020 оны аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэлтэй тохирч байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл болон энэхүү албан бичиг нь "Инвескор ББСБ" ХК-ийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан аудиторын дүгнэлтийг орлохгүй бөгөөд СТОУС болон Монгол улсын хууль, дүрэм, журмаар шаардсан нэмэлт тодруулгыг агуулаагүй болно.

БДО Аудит ХХК

Гүйцэтгэх захирал

Д.Алтансүх

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
6317839 ☎1119277129
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6 ☎1119286963
УЛААНБААТАР ХОТ

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

09 097
96

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭВ-02

2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/СТОУС-ын дагуу илэрхийлэгдсэн/

“ИНВЕСКОР ББСБ” ХК
БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

“ИНВЕСКОР ББСБ” ХК
BDO
УЛААНБААТАР ХОТ

000097

2021 .05. 27

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭВ-02

"ИНВЕСКОР ББСБ" ХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	"Инвескор ББСБ" Хувьцаат Компани (Цаашид "Компани" гэх) нь 2016 оны 04-р сарын 21-ний өдрийн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр анх үүсгэн байгуулагдаж 2019 оны 05-р сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржид хувьцааны 15%-ийг анхдагч зах зээл дээр нээлттэй арилжаалж хувьцаат компани болсон.
Гэрчилгээ	2016 оны 03-р сарын 29-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6060854 тоот регистр бүхий 9015003118 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан. 2019 оны 06-р сарын 11-ний өдөр компанийн үйл ажиллагаанд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тусган 9010002004 тоот бүхий Улсын Бүртгэлийн Гэрчилгээг дахин шинээр авсан. 2020 оны 05-р сарын 28-ны өдөр тайлант хугацаанд шинээр нэмж үүсгэн байгуулсан салбаруудын мэдээллийг шинэчлэн бүртгүүлсэн.
Түсгай зөвшөөрөл	Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05-р сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Банк Бус Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/554 тоот гэрчилгээ авсан.
Үндсэн үйл ажиллагаа	"Инвескор ББСБ" ХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, Төлбөрийн баталгаа гаргах зэрэг болно.
Нэгтгэгдсэн охин компаниуд	"Инвескор Хэтэвч ББСБ" ХХК (Монгол улсын хуулийн этгээд)- 100%-ийг бүрэн эзэмшдэг "Золотой Стандарт ББСБ" ХХК (Киргиз улсын хуулийн этгээд)- 100%-ийг бүрэн эзэмшдэг "Покет КГ" ХХК (Киргиз улсын хуулийн этгээд)- 100%-ийг бүрэн эзэмшдэг "Инвескор Актив" ТЗК ХХК (Монгол улсын хуулийн этгээд)- 75%-ийг эзэмшдэг

Хувьцаа эзэмшигчид		**Хувьцааны тоо**	**Эзэмшлийн хувь**
	"Эс Ай Би Жэй Капитал" ХХК	60,968,730	85%
	Бусад	10,759,188	15%
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирал		Д.Баясгалан
	Дэд захирал		Х.Амгаланбаатар
	Санхүү эрхэлсэн дэд захирал		Р.Пүрэв
Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ-ийн дарга		Б.Анхболд
	ТУЗ-ийн гишүүн		Д.Баясгалан
	ТУЗ-ийн гишүүн		Р.Мөнхтөр
	ТУЗ-ийн гишүүн		Г.Уянгахишиг
	ТУЗ-ийн гишүүн		Т.Тэлмэн
	ТУЗ-ийн гишүүн		Namiki Hirohito
	ТУЗ-ийн хараат бус гишүүн		Ч.Хашчулуун
	ТУЗ-ийн хараат бус гишүүн		Д.Энхбат
	ТУЗ-ийн хараат бус гишүүн		Ч.Өнөржаргал
	ТУЗ-ийн нарийн бичиг		А.Энэрэл

Байнгын хаяг	**"Инвескор ББСБ" ХК** Твин Тауэр-1 байр ,13 давхар Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс
Аудитор	**"БДО Аудит" ХХК** Юнион Бюлдинг В блок, 15-р давхар, 1502 тоот, Юнескогийн гудамж, Нарны зам-62, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс

000098

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭВ-02

2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Энэхүү тайлангийн 3-6 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Инвескор ББСБ" Хувьцаат Компани болон түүний охин компаниудын (Цаашид "Инвескор ББСБ" ХК-ийг "Компани", "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК, "Золотой Стандарт" ХХК, "Покет КГ" ХХК, "Инвескор Актив" ХХК -иудтай хамтад нь "Групп" гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Группийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Группийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

Д.БАЯСГАЛАН
Гүйцэтгэх захирал

Р.ПҮРЭВ
Санхүү хариуцсан дэд захирал

Огноо: 2021.03.17

Улаанбаатар хот, Монгол улс

"ИНВЕСКОР КАПИТАЛ ТӨК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Tel: +976 77404040
Fax: +976 77404041
www.bdo.mn
Zip code: 14230-0059

Room 1502, Level 15
Union Building - B, Unesco Street
Narmii Zam - 62, Khoroo 1
Sukhbaatar District, Ulaanbaatar
Mongolia

Утас: +976 77404040
Факс: +976 77404041
www.bdo.mn
ШНК: 14230-0059

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам - 62, ЮНЕСКО-гийн
гудамж, ЮНИОН БҮЛДИНГ Б блок
15 - р давхар, 1502 тоот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-05-03
БҮРТГЭВ-02

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ИНВЕСКОР ББСБ" ХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Санал дүгнэлт

"Инвескор ББСБ" ХК болон түүний охин компаниудыг багтаасан групп (Цаашид "Инвескор ББСБ" ХК-ийг дангаар нь 'Компани', "Инвескор ББСБ" болон түүний охин компаниудыг хамтад нь 'Групп' гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- **2020 оны 12-р сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;**
- **Энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангууд; болон**
- **Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.**

Бидний дүгнэлтээр, хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь группийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЁЗОУСЗ')-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу группээс хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Асуудлыг онцлох нь

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 45с, Тайлангийн өдрийн дараах үйл явдал-д анхаарлаа хандуулна уу. 2020 оны 01 сараас Дэлхий нийтээр тархсан COVID 19 цар тахлын тархалтын нөлөөллөөс хамааран группийн үйл ажиллагаа болон тайлангийн өдрийн дараах санхүүгийн үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлж болзошгүй үйл явдлуудын талаар тусгасан. Бид энэхүү асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

BDO

СЭХ
2021 -05- 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭВ 02

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Аудитын хариу
1 Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт	
Группийн нийт хөрөнгийн 70.91% (2019: 76.08%) -ийг харилцагчдад олгосон зээл эзэлж байна. Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлохдоо өнгөрсөн хугацаанд тохиолдсон алдагдлын түүхэн мэдээлэл дээр үндэслэн зээлийн бүтээгдэхүүн тус бүр дэх макро эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг авч үзэн магадлалаар таамагласан ирээдүйн мөнгөн урсгалын талаарх удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцоолдог. Тайлант жилийн эцэс дэх зээлийн үнэ цэнийн бууралтын гарзыг удирдлагаас тусгайлсан болон бүлгийн үнэлгээний загвар ашиглан тодорхойлсон. Ингэхдээ СТОУС 9 -ийн дагуу зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг 3 шатлалд хуваан авч үзэн хүлээгдэж буй алдагдлын загвараар үнэ цэнийн бууралтын тооцоолол хийсэн. Дэлхий нийтээр тархаад буй "COVID 19" цар тахалтай холбоотойгоор макро эдийн засгийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж зээлийн үнэ цэнийн бууралтын тооцооллыг хийсэн. Ашигласан таамаглалууд зохисгүй байж болзошгүй учраас бид энэхүү удирдлагын тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан. Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 21-аас үзнэ үү.	Зээлийн үнэ цэнийн тооцооллыг үнэлэхдээ бид дараах горимууд гүйцэтгэсэн: • Группийн зээлийн үнэ цэнийн бууралт, хүлээн зөвшөөрөлт, хяналтуудыг бид үнэлсэн; • Үнэ цэнийн бууралтын тооцоолол нь СТОУС 9-аар шаардсан арга, аргачлалын дагуу хийгдсэн эсэх нийцлийг шалгасан; • Группийн зээлийн үнэ цэнийн бууралтын тооцоололд ашигласан зээлийн өгөгдлийн иж бүрэн байдал, ашигласан орц мэдээллийн найдвартай байдлыг шалгасан; • Зээлийн ангилал үнэн зөв хийгдэж, насжилтыг зөв гаргасан эсэхийг шалгаж зохих журмын дагуу дахин ангилсан; • Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлоход удирдлагын зүгээс ашигласан магадлалуудыг бид группийн зээлийн мэдээлэлтэй тулгасан; • Хүлээгдэж буй зээлийн алдагдалтай холбоотой нэмэлт тодруулгууд нь хангалттай эсэхийг үнэлсэн; • COVID 19 цар тахлын эдийн засагт үзүүлж буй нөлөөтэй холбоотойгоор Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлого, журмын компанид үзүүлэх нөлөөллийг авч үзсэн.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
1119277128
УЛАТАР ХОТ

"ИНВЕСКОР БЕСБ" ХК
InvesCo
УЛАТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭВ-02

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар бүрүү илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг бүрүү илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа эсвэл заль мэхнээс үүдэлтэй материаллаг бүрүү илэрхийллээс ангид нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх группийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг бүрүү илэрхийллээс Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ Нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
"ИНВЕСКОР ЕБСБ" ХК
BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the International BDO network of independent member firms.
Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

000102

BDO

СЗХ 2021.05.27 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-05-03 БҮРТГЭВ-02

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас Нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн үг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Группийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Л. БАЯРЦОГЗОЛ
"БДО Аудит" ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж, Нарны зам-62
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

БДО АУДИТ ХХК BDO УЛААНБААТАР ХОТ ТТН326 2546442 ASSURANCE VALUATION SERVICES

Огноо: 2021.03.17

"ИНВЕСКОР ББСБ" ХК

- Тусдаа хүлээн зөвшөөрөгдөх шаардлага хангадаггүй биет бус хөрөнгө оршин буй бол
- Группийг урамшуулал төлөхөд хүргэх материаллаг зардал хэмнэлт, ба
- Капиталын бага өртөг нь бие даасан хөрөнгүүдтэй бус харин худалдаж авсан нийт үйл ажиллагааны хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалтай хамаатай байх.

"Золотой Стандарт" ХХК-ийн худалдан авалтаас үүссэн гүүдвил нь татварын зорилгоор суутгагдахгүй.
Худалдан авалтын өдрөөс хойш "Золотой Стандарт" ХХК нь группийн орлогод 333,830 мянган төгрөг, ашигт 10,470 мянган төгрөгийн хувь нэмэр оруулсан. Хэрэв 2020 оны 01 сарын 01-ний өдрөөр худалдан авалтыг хийсэн бол Группийн орлого 426,902 мянган төгрөг, ашиг нь 75,679 мянган төгрөг байх байсан.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

000162

41. Сегментийн мэдээлэл

Группийн тайлагнагдах сегментийг тодорхойлоход удирдлагын хэрэглэдэг хүчин зүйлс

Группийн бүрэлдэхүүн хэсэгт багтаж нөлөө бүхий охин компаниуд нь нэгтгэгч компанитай ижил төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгодог стратегийн бизнесийн нэгжүүд юм.

Групп нь 2020 оны 9 сард Программ хангамжийн зөвлөгөө, үйлчилгээ эрхэлдэг "Инвескор Эй Ай Лаб" ХХК болон Санхүү зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг "Инвескор Жапан"ХХК-иуд дахь өөрийн эзэмшиж байсан хувьцаагаа зарж, ямар нэг хувь сонирхолгүй болсон.

Группийн удирдлага үйл ажиллагааны тайланд сегментийг тодорхойлохдоо үйл ажиллагаа явуулж буй улс тус бүрээр гол үзүүлэлтийг харгалзан үздэг.

Компани нь дараах 2 улсад үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Монгол Улс –Группийн 3 бүрэлдэхүүн хэсэг үйл ажиллагаа явуулж группийн 2020 оны орлогын 99%-ийг бүрдүүлж байна.
- Бүгд Найрамдах Киргиз Улс – Группийн 2 бүрэлдэхүүн хэсэг үйл ажиллагаа явуулж группийн 2020 оны орлогын 1%-ийг бүрдүүлж байна.

Үйл ажиллагааны сегментийн ашиг/(алдагдал), хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт

Сегмент тус бүрийн гүйцэтгэлийг үнэлэхдээ СТОУС-ын дагуу тооцсон үйл ажиллагааны үр дүн дээр суурилан тооцдог.

2020 он	Зээлийн үйл ажиллагааны орлого	
	Монгол мян.төг	Киргиз мян.төг
Орлого		
Нийт орлого	29,832,784	328,243
Хасах нь: Сегмент хоорондын орлого	(476,508)	-
Нийт гадаад зах зээлийн борлуулалт	**29,356,276**	**328,243**
Борлуулалтын өртөг	(7,228,303)	(3,328)
Хасах нь: Сегмент хоорондын	476,438	-
Нийт ашиг	**22,604,411**	**324,915**
Ерөнхий ба удирдлагын зардал	(6,951,538)	(334,531)
Үйл ажиллагааны бус орлого/(зардал)	(197,738)	-
Бусад олз/(гарз)	1,013,474	-
Бизнесийн нэгдлийн БҮЦ тохируулгын нөлөө	-	205,010
Сегментийн ашиг/(алдагдал)	**16,468,609**	**195,394**
Үнэ цэнийн бууралтын зардал	(1,291,418)	(6,529)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	**15,177,191**	**188,865**

СЗХ
ОН САР ӨДӨР
2021 05 27
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03

41. Сегментийн мэдээлэл(үргэлжлэл)

2019 он	Зээлийн үйл ажиллагааны орлого Монгол мян.төг	Зуучлалын орлого Япон мян.төг
Орлого		
Нийт орлого	20,557,403	1,933,653
Хасах нь: Сегмент хоорондын орлого	(368,760)	-
Нийт гадаад зах зээлийн борлуулалт	**20,188,643**	**1,933,653**
Борлуулалтын өртөг	(4,192,760)	-
Хасах нь: Сегмент хоорондын	-	-
Нийт ашиг	**15,995,883**	**1,933,653**
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,933,768)	(2,776,313)
Үйл ажиллагааны бус орлого/(зардал)	(116,471)	(45)
Бусад олз/(гарз)	(279,702)	-
Хасах нь: Сегмент хоорондын	441,331	-
Сегментийн ашиг/(алдагдал)	**12,107,273**	**(842,705)**
Үнэ цэнийн бууралтын зардал	(56,963)	-
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	**12,050,310**	**(842,705)**

Санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12-р сарын 31	Монгол мян.төг	Киргиз мян.төг
Тайлагнагдах сегментийн хөрөнгө		
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	25,852,518	736,156
Хөрөнгө оруулалт	591,122	-
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	94,000,280	2,409,522
Бусад санхүүгийн хөрөнгө	1,534,116	-
Бусад санхүүгийн бус хөрөнгө	463,987	28,231
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	821,892	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр	5,264,381	111,220
Хөрөнгө ашиглах эрх-цэвэр	813,044	331,484
Биет бус хөрөнгө-цэвэр	2,689,942	-
Гүүдвилл	292,627	-
Группийн нийт хөрөнгө	**132,323,909**	**3,616,613**
Тайлагнагдах сегментийн өр төлбөр		
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	42,209,511	-
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	13,967,429	132,771
Бусад эх үүсвэр	14,689,798	-
ББСБ-аас гаргасан бонд	7,878,886	-
Бусад санхүүгийн өр төлбөр	1,566,470	63,080
Бусад санхүүгийн бус өр төлбөр	922,491	335,187
Болзошгүй өр төлбөр	774,303	-
Орлогын албан татварын өглөг	703,522	280
Группийн нийт өр төлбөр	**82,712,410**	**531,318**

InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-05-03
БҮРТГЭВ-02

41. Сегментийн мэдээлэл(үргэлжлэл)

2019 оны 12-р сарын 31	Монгол мян.төг	Япон мян.төг
Тайлагнагдах сегментийн хөрөнгө		
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	4,455,035	691,110
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	62,307,875	-
Бусад санхүүгийн хөрөнгө	2,731,660	1,374,393
Бусад санхүүгийн бус хөрөнгө	711,894	974,058
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	1,055,576	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр	4,994,105	349,754
Хөрөнгө ашиглах эрх	1,494,136	-
Биет бус хөрөнгө-цэвэр	762,564	-
Группийн нийт хөрөнгө	**78,512,845**	**3,389,315**
Тайлагнагдах сегментийн өр төлбөр		
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	19,933,800	-
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	14,515,976	-
Бусад санхүүгийн өр төлбөр	1,797,651	2,723,400
Бусад санхүүгийн бус өр төлбөр	782,058	6,202
Болзошгүй өр төлбөр	774,303	-
Орлогын албан татварын өглөг	980,078	-
Группийн нийт өр төлбөр	**38,783,866**	**2,729,602**

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
ХОТ

000165

"ИНВЕСКОР ББСБ" ХК
ХОТ

42. Холбоотой талуудын ажил гүйлгээ

(i) Холбоотой талуудыг тодорхойлох

Хэрвээ тухайн групп нь негеө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн групп өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог.

Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно. Тус групп нь доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй холбоотой талууд юм:

Холбоотой талуудын нэр	Харьяалал	Харилцан хамаарал	Гол ажил гүйлгээний төрөл
Эйс Ай Би Жэй капитал ХХК	Монгол улс	Толгой компани	Зээл, хоорондын тооцоо
Б.Мөнх-Очир	Монгол улс	Толгой компанийн хувьцаа эзэмшигч	Байхгүй
Т.Kawazoe	Япон улс	Толгой компанийн хувьцаа эзэмшигч	Зээл
Б.Анхболд	Монгол улс	ТУЗ дарга	Цалин урамшуулал
Р.Мөнхтөр	Монгол улс	ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Г.Уянгахишиг	Монгол улс	ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Т.Тэлмэн	Монгол улс	ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Д.Энхбат	Монгол улс	ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Ч.Өнөржаргал	Монгол улс	ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Ч.Хашчулуун	Монгол улс	ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Хирохито Намики	Япон улс	ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Д.Баясгалан	Монгол улс	Гүйцэтгэх захирал, ТУЗ гишүүн	Цалин урамшуулал
Х.Амгаланбаатар	Монгол улс	Тэргүүн дэд захирал	Цалин урамшуулал
Инвескор Лизинг ХХК	Монгол улс	Зэргэлдээ компани	Хоорондын тооцоо
Инвескор Капитал ҮЦК ХХК	Монгол улс	Зэргэлдээ компани	Хоорондын тооцоо
Инвескор Фанд ХХК	Монгол улс	Зэргэлдээ компани	Хоорондын тооцоо
Инвескор Проперти ХХК	Монгол улс	Зэргэлдээ компани	Хоорондын тооцоо
Инвескор Жапан ХХК	Монгол улс	Зэргэлдээ компани	Хоорондын тооцоо
Инвескор Эй Ай Лаб ХХК	Монгол улс	Зэргэлдээ компани	Систем хөгжүүлэлт
Коло Тинкинг ХХК	Монгол улс	Зэргэлдээ компани	Дизайн хөгжүүлэлт

42. Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

(ii) Холбоотой талуудын ажил гүйлгээ

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилд холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ дараах байдалтай байна:

	Хувьцаа эзэмшигч		Бусад холбоотой талууд	
	2020 он мян.төг	2019 он мян.төг	2020 он мян.төг	2019 он мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	-	-	1,157,852	614,706
Зуучлалын орлого				1,221,500
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(1,819,121)	(1,846,516)	(132,478)	(47,863)
Худалдан авсан биет бус хөрөнгө	-	-	(421,977)	-
Холбоотой талаас авсан зээл	-	-	-	2,501,261
Холбоотой талд төлсөн зээл	(5,146,750)	(400,000)	-	(100,832)

Гол удирдах албан тушаалтнуудын цалин:
Гол удирдах албан тушаалтан гэдэг нь Группийн үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, хянах эрх мэдэл, үүрэг хариуцлага бүхий этгээдүүд бөгөөд Хуудас 1-д жагсаасан группийн гүйцэтгэх захирал, дэд захирал, санхүүгийн эрхэлсэн дэд захирал үйл ажиллагаа эрхэлсэн захирлуудыг хэлнэ.
Гол удирдах албан тушаалтнуудад олгосон цалин, урамшуулал, тэтгэмжийн зардлыг дараах хүснэгтэд харууллаа:

	2020 он		2019 он	
	Зардал мян.төг	Өр төлбөр мян.төг	Зардал мян.төг	Өр төлбөр мян.төг
Богино хугацаат тэтгэмж:				
- Цалин	172,562	-	144,383	145
- Богино хугацаат урамшуулал	9,993	-	30,300	-
- Бусад тэтгэмж	-	-	-	-
- Нийгмийн даатгалын шимтгэл	11,453	-	16,163	-
	194,008	**-**	**190,846**	**145**

(iii) Холбоотой талуудтай хийсэн хоорондын ажил гүйлгээний тооцооны үлдэгдэл
12 сарын 31-ний байдлаарх холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ, тооцооны үлдэгдлийн мэдээллийг дор харуулав.

	Тэм	2020 оны 12 сарын 31 мян.төг	2019 оны 12 сарын 31 мян.төг
Холбоотой талаас авах авлага			
Инвескор Эй Ай Лаб ХХК		2,480	2,252
Инвескор лизинг ХХК		7,160	1,000
Инвескор Капитал УЦК ХХК		50,000	-
Эс Ай Би Жэй Капитал ХХК		774,303	1,124,313
Нийт холбоотой талуудаас авах авлага	**22**	**833,943**	**1,127,565**

42. Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

	Тэм	2020 оны 12 сарын 31 мян.төг	2019 оны 12 сарын 31 мян.төг
Холбоотой талд төлсөн урьдчилгаа			
Р.Мөнхтөр		-	2,000
Х.Амгаланбаатар		300	500
Б.Анхболд		753	836
Д.Баясгалан		1,578	4,000
Нийт холбоотой талд төлсөн урьдчилгаа		**2,631**	**7,336**

	Тэм	2020 оны 12 сарын 31 мян.төг	2019 оны 12 сарын 31 мян.төг
Холбоотой талд өгөх өглөг			
Эс Ай Би Жэй Холдинг ХХК		-	108,810
Инвескор Холдинг ХХК		-	1,211,187
Инвескор Капитал ҮЦК ХХК		3,225	29,639
Инвескор Эй Ай Лаб ХХК		431,367	-
Нийт холбоотой талуудад өгөх өглөг	33	**434,592**	**1,349,636**

Холбоотой талд олгосон хүү бүхий авлага, өглөг

	Тэм	2020 оны 12 сарын 31		2019 оны 12 сарын 31	
		Зээлийн авлага мян.төг	Хүүгийн авлага мян.төг	Зээлийн авлага мян.төг	Хүүгийн авлага мян.төг
Ажилчид		-	-	191,564	2,649
Инвескор Холдинг ХХК		-	-	301,838	169
Эс Ай Би Жэй Холдинг ХХК		-	-	1,452,320	812
Эс Ай Би Жэй Рийл Эстэйтс ХХК		-	-	1,080,074	7,970
T.Kawazoe		3,692,773	56,478	-	-
Нийт холбоотой талын зээл болон хүүгийн авлага	20	**3,692,773**	**56,478**	**3,025,796**	**11,600**

СЭХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03

42. Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

(iii) Холбоотой талуудтай хийсэн хоорондын ажил гүйлгээний тооцооны үлдэгдэл (үргэлжлэл)

Холбоотой талд олгосон хүү бүхий авлага, өглөг (үргэлжлэл)

	Тэм	2020 оны 12 сарын 31		2019 оны 12 сарын 31	
		Итгэлцэл мян.төг	Хүүгийн өглөг мян.төг	Итгэлцэл мян.төг	Хүүгийн өглөг мян.төг
Эс Ай Би Жэй Холдингс ХХК		-	-	273,352	19,418
Инвескор Проперти Менежмент ХХК		100,000	9,419	800,000	47,863
Инвескор Капитал УЦК		640,833	14,562	-	-
Нийт холбоотой олгох итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	**24**	**740,833**	**23,981**	**1,073,352**	**67,281**
		Зээл мян.төг	**Хүүгийн өглөг мян.төг**	**Зээл мян.төг**	**Хүүгийн өглөг мян.төг**
Эс Ай Би Жи Капитал ХХК		9,574,323	654,766	9,574,323	3,982,394
Нийт холбоотой талуудад өгөх зээл болон өр төлбөр	**25**	**9,574,323**	**654,766**	**9,574,323**	**3,982,394**

43. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

Бизнесийн хэвийн явцад групп нь түүний эсрэг нэхэмжлэл хүлээн авч болно. Группийн удирдлага өөрсдийн хийсэн тооцоолол дээр үндэслэн нэхэмжлэлүүдээс үүдэлтэйгээр эдгээр санхүүгийн тайланд тусгасан өр төлбөрийн нөөцийг давах хэмжээний материаллаг алдагдал үүсэхгүй гэж дүгнэж байна.

(i) Зээл олгох үүрэг, амлалт

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд групп нь зээлийн шугамын бүтээгдэхүүн гаргадаг. Энэ нь группийн зүгээс зээлийн шугам нээх гэрээт үүргийг хүлээснийг илэрхийлдэг. Тайлант болон өмнөх жилийн олгоогүй зээлийн үүргийн доорх байдалтай байна.

	2020 оны 12 сарын 31 мян.төг	2019 оны 12 сарын 31 мян.төг
Шугамын зээлийн эрх	8,501,859	10,174,849
Тайлант жилийн олгосон зээлийн үлдэгдэл	(6,992,652)	(8,377,051)
Олгоогүй зээлийн шугамын дүн	**1,509,207**	**1,797,798**

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
"ИНВЕСКОР ББСБ" ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03

44. Засгийн газрын буцалтгүй тусламжийн орлого

Коронавирусын халдвараас сэргийлэх болон эдийн засгийн хүндрэлтэй байдлыг даван туулахын тулд Монгол Улсын Засгийн Газраас хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, компаниудыг нийгмийн даатгалын шимтгэлээс 2020 оны 4-р сарын 01-ээс 2020 оны 10-р сарын 01-ний хооронд 6 сарын хугацаатай чөлөөлсөн ба, 2020 оны 10-р сарын 01-ээс 2020 оны 12 сарын 31-ний хооронд 3 сарын хугацаанд 6.5%-иар хөнгөлсөн. Уг орлоготой холбоотой 341,439 мянган төгрөгийн хөнгөлөлтийг зардлаас хасаж тодруулсан. Засгийн газраас уг хөнгөлөлтийг авахын тулд компанид ажиллагсдын тоог бууруулахгүй байх гэсэн үндсэн шаардлага тавьсан бөгөөд тайлант хугацаанд компанийн ажиллагсдын тоо буураагүй байна. Энэ хөтөлбөртэй холбоотойгоор компанид биелүүлээгүй аливаа үүрэг байхгүй

45. Тайлагналын өдрийн дараах үйл явдал

a) 2021 оны 02-р сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн № А/01-Т, № А/02-Т тогтоолуудаар нэгтгэгч компани нь эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх болон Голомт банктай хамтран гаргах гэж байгаа шинэ бүтээгдэхүүний санхүүжилтэд зориулан нийт 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгийн зээлийн шугамын эрх нээлгэх хүсэлт гаргасан.

b) 2021 оны 02-р сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн № А/04-Т тогтоолоор группийн нэгтгэгч компани нь 2020 оны жилийн цэвэр ашгаас 1,219,374,606 (Нэг тэр бум хоёр зуун арван есөн сая гурван зуун далан дөрвөн мянга зургаан зуун зургаан) төгрөгийн мөнгөн ногдол ашиг зарлаж, хувьцаа эзэмшигчдэд олгохоор шийдвэрлэсэн. Нэгтгэгч компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох дүнг 17₮ байхаар тогтоосон.

c) 2020 оны 01-р сараас үүссэн Корона вирусийн халдвар (COVID 19) нь дэлхийн нийтээр 223 улс, бүс нутагт бүртгэгдэн улс орнуудын хүн амын эрүүл мэндээс гадна эдийн засагт томоохон цохилт болж байна. Группийн бизнест ч мөн уг онцгой дэглэмийн нөлөөллөөр борлуулалтын үйл ажиллагаа бага зэрэг буурч, авлага цуглуулалт удааширч байгаа боловч компанийн зүгээс одоогоор үйл ажиллагаанд ноцтойгоор нөлөөлөх нөхцөл байдал үүсээгүй, үнэ цэнийн бууралтын томоохон шинж тэмдэг байхгүй байна гэж үзэж байна.

Группийн удирдлагуудын зүгээс мөн үүсээд буй онцгой нөхцөл байдлын бизнест үзүүлэх нөлөөллийг хувилбар бүрээр гаргаж нөлөөллийг тооцон, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох ажлуудыг тогтмол хийж байгаа.

Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх өөр бусад үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийг хүртэлх хугацаанд гараагүй гэж үзэж байна.

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР

46. Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих тэмдэглэл

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс нь дараах зүйлсээс бүрдэнэ:

	2020 оны 12 сарын 31 мян.төг	2019 оны 12 сарын 31 мян.төг
Банк дахь харилцах, хугацаагүй хадгаламж (Тэмдэглэл 18)	17,585,673	5,146,145
Богино хугацаат хадгаламж (Тэмдэглэл 18)	9,003,000	-
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	**26,588,673**	**5,146,144**

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны томоохон мөнгөн бус гүйлгээнүүдийг доор харууллаа:

	2020 он мян.төг	2019 он мян.төг
Худалдан авсан хэдий ч хараахан төлөөгүй байгаа үндсэн хөрөнгө	-	4,408,849
Худалдан авсан хэдий ч хараахан төлөөгүй байгаа биет бус хөрөнгө	299,525	-
Нийт дүн	**299,525**	**4,408,849**

46. Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих тэмдэглэл (үргэлжлэл)

Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээнүүдийг санхүүжилтийн үйл ажиллагааны өр төлбөрийн тохируулга байдлаар дараах хүснэгтэд харууллаа:

Итгэлцлийн өглөг дансны үлдэгдэл:	2020 он мян.төг	2019 он мян.төг
01 сарын 01-нээрх	**19,933,800**	**10,374,109**
Мөнгөн гүйлгээ:		
- Нэмж авсан итгэлцэл	42,972,955	17,660,744
- Төлсөн итгэлцэл	(6,749,897)	(9,135,930)
- Төлсөн хүү	(2,393,945)	(1,079,985)
Мөнгөн бус гүйлгээ:		
- Бусад эх үүсвэр рүү ангилсан	(15,799,071)	-
- Бусад эх үүсвэр рүү ангилсан хүүгийн өглөг	(411,493)	-
- Хуримтлуулсан хүү	4,105,333	2,084,890
- Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөө	551,829	252,337
- Авлага, өглөгөөр	-	(222,365)
12 сарын 31-нээрх	**42,209,511**	**19,933,800**

Зээлийн өглөг дансны үлдэгдэл:	2020 он мян.төг	2019 он мян.төг
01 сарын 01-нээрх	**14,515,976**	**13,867,446**
Мөнгөн гүйлгээ:		
- Нэмж авсан зээл	10,561,616	2,641,585
- Төлсөн зээл	(10,720,209)	(3,740,000)
- Төлсөн хүү	(3,177,087)	(140,986)
Мөнгөн бус гүйлгээ:		
- Хуримтлуулсан хүү	2,051,118	1,987,502
- Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөө	(1,324)	-
- Авлага, өглөгөөр	870,110	(99,571)
12 сарын 31-нээрх	**14,100,200**	**14,515,976**

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй

а. Орлого хүлээн зөвшөөрөлт

i) Хүү болон түүнтэй адилтгах орлого

Хүү болон түүнтэй адилтгах орлого нь харилцагчдад олгосон зээлийн хүүгийн орлогоос бүрддэг. Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аккруэл сууриар бүртгэж тайлагнадаг. Үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны турш хүлээн авах мөнгөн орлогын төлбөрийг санхүүгийн хөрөнгийн дансны цэвэр дүн хүртэл хөнгөлөх түвшин юм.

Групп нь Монгол улс болон Киргиз улсаар дамжуулан нийт 15 салбараар дамжуулан хүүгийн орлого олж байна. Харилцагчтай байгуулж буй зээлийн гэрээний дундаж хугацаа 24 сар бөгөөд зээлийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу системтэй төлөлт хийгддэг.

Харилцагчийн зээлийн хүүгийн түвшинг тодорхойлохдоо тухайлсан гэрээний нөхцөл болон өөрийн бизнесийн тогтсон практикийг харгалзан үздэг. Харилцагчтай байгуулсан гэрээнээс олох хүүгийн орлогын дүн нь зээлдэгчийн эргэн төлөлтөөс хамаарах үндсэн болон нэмэгдүүлсэн хүү байна.

Групп нь үнэ цэнийн бууралтад орсон хөрөнгөөс бусад хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцдог. Энэ нь" Шатлал 1" болон "Шатлал 2"-д хамаарах санхүүгийн хөрөнгийн дансны үнээс гэрээнд заасан хүүгийн хувиар хүүгийн орлогыг аккруэл сууриар бүртгэл орлогын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэн буурч " Шатлал 3"-д орсон тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан цэвэр өртгөөс хүүгийн орлогын тооцоолол хийдэг. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орохоо больсон тохиолдолд хүүгийн орлогыг дансны үнээс тооцно.

ii) Үйлчилгээ хураамж, шимтгэлийн орлого

Групп нь өөрийн харилцагч нарт үзүүлсэн үйлчилгээнээс үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого олдог. Энэ нь ерөнхийдөө анх санхүүгийн хэрэглүүрийг гаргах үед аж ахуйн нэгжийн хүлээн авдаг үүсгэлтийн хураамж гэж ойлгож болно. Зээлийн хураамж шимтгэлийн орлого нь олгосон зээлийн дүнгээс хамаарч зээлийн гэрээ тус бүрд тусгагдсан байх бөгөөд зээл олгох үед зээлийн нийт дүнгээс гэрээнд заасан дүнгээр шимтгэл тооцож авдаг. Ийм хураамж нь зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа болон бусад аюулгүй байдлын арга хэмжээг үнэлэх ба бүртгэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцөлийг хэлэлцэх тохиролцох, баримт бичгийг бэлтгэж боловсруулах, ажил гүйлгээг дуусгаж, хаах гэх мэт үйл ажиллагааны төлбөрийг багтаасан байж болдог. Энэхүү хураамж нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн салшгүй нэг хэсэг болохгүй гэж үзэн хураамжийг СТОУС 15 "Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого" стандартын дагуу орлого хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

b. Хяналтын бус хувь оролцоо

Группийн хувьд бизнесийн нэгдлийн үр дүнд олж авсан аливаа хяналтын эрхгүй хувь оролцоог нэгдэгчийн цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн хүлээн зөвшөөрдөг. Энэ нь одоогийн өмчийн хувь оролцоо болон уг хувь оролцоог нэгдэгчийг татан буулгах үеийн цэвэр хөрөнгийг худалдан авах өдрийн бодит үнэ цэнээс хувь тэнцүүлэн хүлээн зөвшөөрөх эсвэл нэгдэгчийн тодорхойлогдож болох цэвэр хөрөнгийн хүлээн зөвшөөрсөн дүнгээс одоогийн өмчийн хэрэгслийг хувь тэнцүүлэн хүлээн зөвшөөрөх юм. Эргэлтэд байгаа хувьцааны опцион гэх мэт хяналтын эрхгүй хувь оролцооны бусад бүрэлдэхүүн хэсгийг бодит үнэ цэнээр хэмжинэ. Группийн хувьд тайлангийн өдөр хүртэл хийгдсэн худалдан авалтуудад бодит үнэ цэнэ хэрэглэх сонголтыг хийгээгүй.

Групп нь хагас эзэмшилтэй охин компаниудын нийт дэлгэрэнгүй орлогыг толгой компанийн эзэмшигчдэд болон хяналтын эрхгүй хувь оролцоо бүхий этгээдүүдэд эзэмшлийн хувьтай нь хувь тэнцүүлэн хуваарилдаг.

c. Гүүдвилл

Гүүдвил гэдэг нь Группийн нэгтгэж авсан хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөрийн худалдан авалтын өдрөөрх нийт бодит үнэ цэнээс бизнесийн нэгдэлтэй холбоотой гарсан зардлын хэтэрсэн үнийн дүнг илэрхийлнэ. Өгөгдсөн хөрөнгө, өр төлбөр, гаргасан өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнэ дээр нэгдэгч дэх хяналтын эрхгүй хувь оролцооны дүнг нэмэх бөгөөд бизнесийн нэгдлийг шатлалтай хийж гүйцэтгэсэн бол нэгдэгч дэх одоогийн өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг давхар нэмсэн дүнгээс өртөг бүрдэнэ.

Болзошгүй төлбөрийг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжиж өртөгт оруулсан. Харин болзошгүй төлбөрийг санхүүгийн өр төлбөрөөр ангилсан тохиолдолд дараа үеүдэд ашиг, алдагдлаар дахин хэмжсэн.

Гүүдвилийг биет бус хөрөнгөөр капиталжуулах бөгөөд түүний дансны үнийн бууралтыг Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Тодорхойлох боломжтой хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь төлсөн төлбөрийн бодит үнэ цэнээс хэтэрч байгаа үед тухайн илүүдэл дүнг худалдан авалтын өдрөөр Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан д бүрэн кредитэлнэ.

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-05-03
БҮРТГЭВ-02

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

d. Санхүүгийн бус хөрөнгө үнэ цэнийн бууралт

Өмч, барилга, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө зэрэг бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэ нь эргэн нөхөгдөхгүй байж болохыг илэрхийлсэн үйл явдал буюу өөрчлөлт тухайн нөхцөлд байгаа эсэхийг шалгаж үзэх ёстой. Хөрөнгийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээс (ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээс их) давсан үед хөрөнгийг бууруулах бичилт хийдэг.

Тухайлсан хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох боломжгүй байх тохиолдолд хөрөнгүүдийг бие даан тодорхой мөнгөн урсгал бий болгохгүй хөрөнгийн бүлгийн хамгийн бага нэгж болгох хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнийн бууралтыг шалгана.

Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын алдагдал нь мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилагдсан анхны дансны нийт үнийн дүнг бууруулна. Үнэ цэнийн бууралтын алдагдлын үлдэгдэл хэсэг нь бусад хөрөнгийн хамрах мөнгө бий болгогч нэгжүүдэд хувь тэнцүүлэн тооцоологдоно. Дараа үеүдэд бүх хөрөнгийн өмнө нь бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтын гарз байгаа эсэхийг дахин шалгах бөгөөд энэ магадгүй удаан хугацаанд оршин тогтнохгүй байж болно. Үнэ цэнийн бууралтын төлбөрийг хэрвээ мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь үүний дансны үнээс давсан бол дахин өөрчлөгдөнө.

Үнэ цэнийн бууралтын гарзыг Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

e. Гадаад валютаарх ажил гүйлгээ

Группийн үйл ажиллагаа эрхэлдэг үндсэн эдийн засгийн орчны валютаас ("бүртгэлийн валют") бусад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлсэн.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг бүртгэлийн тайлангийн өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Мөнгөөрх төлөгдөөгүй хөрөнгө, өр төлбөрийг дахин хөрвүүлснээс үүссэн ханшийг зөрүүг ашиг, алдагдалд шууд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Тайлант жилийн явцад хэрэглэж байсан ханш дараах байдалтай байна:

Валют	Дүндаж ханш		Хаалтын ханш	
	2020 он	2019 он	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Ам.доллар	2,813.40	2,663.54	2,849.51	2,733.52
Евро	3,212.65	2,982.51	3,495.78	3,061.00

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317... 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000175

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6960854 ... 1119256003
УЛААНБААТАР ХОТ

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

f. Санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч групп санхүүгийн хөрөнгийг доор дурдсан төрлүүдийн нэгээр нь ангилдаг. Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг групп дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүр болон цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (өр төлбөрөөр ангилагдсан мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүрийн тухай "Санхүүгийн өр төлбөр" хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана. Хейджийн хэрэглүүрийн зориулалтгүй үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар группт арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө байхгүй бөгөөд групп санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг сайн дураараа ашиг, алдагдлаар хэмжигдэх ангилалд оруулдаггүй байна.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх

Эдгээр хөрөнгө нь харилцагчид олгосон зээл болон түүний хүүгийн авлагаас ихэвчлэн үүсдэг. Гэхдээ мөн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрддэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөс үүсдэг. Эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг олж авах эсвэл гаргахтай холбоотой шууд хамааралтай гарсан ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба дараа үед үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон үнэ цэнийн бууралтыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Групп зээлийн авлагын үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг СТОУС 9-д ерөнхий арга-д үндэслэн 12 сарын болон нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлох замаар хасагдуулгын матрицыг байгуулдаг. Ингэхдээ худалдааны авлагын төлөгдөхгүй байх магадлалыг үнэлдэг. Худалдааны авлагын нийт хугацааны туршид авлага төлөгдөхгүй байхаас үүсэх хүлээгдэж буй алдагдлыг тодорхойлж уг хүлээгдэж буй алдагдлыг энэхүү магадлалаар үржүүлж тооцно. Худалдааны авлагын хувьд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн гарзын түсдаа бүртгэгдсэн хасагдуулгын данстай цэвэр дүнгээр тайлагнана. Харин хүлээн зөвшөөрсөн. Худалдааны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Холбоотой талуудаас авах авлага болон холбоотой талуудад олгосон зээлд байгуулсан үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар урьдчилан таамагласны үндсэн дээр тооцоолно. Хасагдуулгын дүнг тодорхойлохдоо ашигласан аргачлал нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан эсэхэд үндэслэнэ. Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гараагүй бол 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан бол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт цэвэр сууриар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

СЭХ
он 2021 оны 05. 27.
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭЛ-02

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

f. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Групп нь зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдлын тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс санхүүгийн байдлын тайлагналын хугацаа бүрд дангаараа томоохон дүнтэй зээл ба авлагуудыг хянаж үздэг. Бүх ангиллын хувьд үнэ цэнийн бууралтын алдагдлыг тодорхойлоход удирдлагын үнэлэмж орох бөгөөд ялангуяа ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацаа болон барьцаа хөрөнгийн дүнд орсон байдаг. Эдгээр тооцооллууд нь олон тооны хүчин зүйлүүдээр хөтлөгддөг бөгөөд тус хүчин зүйлүүдийг өөрчлөхөд өөр өөр түвшний сан үүсэх боломжтой. Мөн бүлгийн үнэлгээний өгөгдөл болон тохируулгын үнэлэмжид нэг төрлийн жижиг багцуудыг тодорхойлох, эрсдэлийн төвлөрлийн нөлөө болон эдийн засгийн мэдээлэл (үүнд эргэн төлөлтийн чиг хандлага, ипотекийн зээлийн үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс зэрэг барьцаа хөрөнгийн дүн, улсын эрсдэл, өөр өөр бүлгүүдийн гүйцэтгэл болон дампуурлын чиг хандлага) болон гэнэтийн нөхцөл байдлыг тодорхойлох зэрэг шалгууруудд багтдаг. Бодит алдагдлын нөхцөл байдал дээр тулгуурлан тооцоолох аргачлал болон таамаглалууд нь хянагдаж байдаг.

Группийн хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайлан дахь зээлийн авлага болон мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, банкин дахь хадгаламж, 3 сар болон түүнээс богино хугацаатай тургэн хөрвөх бусад хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана. Банкны овердрафтыг санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөрийн хэсэгт зээл болон өр төлбөрөөр тусгасан.

Шийдэл

Групп нь харилцагчдад олгосон зээлийг СТОУС 9-ийн дагуу ерөнхий арга болон хялбаршуулсан арга ашиглан хүлээгдэж буй алдагдлын дүнг тодорхойлдог. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсэх үнэлгээ нь тухайн тайлант үеийн эцсээр санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэлэмж буурч байгаа эсвэл, үл биелүүлэлт бодитоор гарч тохиолдсон талаарх нотолгоонд биш, харин анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш гэрээний үл биелүүлэлт гарч тохиолдох магадлал буюу эрсдэлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтэд үндэслэн тооцоолол хийдэг. Ингэхдээ нийт санхүүгийн хэрэглүүрийг 3 шатлалд хуваж авч үздэг.

Шатлал1 - Анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн алдагдалд томоохон өсөлт гараагүй буюу эргэн төлөлтийн хугацаа хэтрэлтгүй зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед **12 сарын зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан** бүртгэхээс гадна шатлал 2-оос эрсдэл нь буурч буй зээлүүд дахин ангилагдана.

Шатлал2 - Анх хүлээн зөвшөөрснөөс зээлийн алдагдалд томоохон өсөлт гарсан буюу 1-90 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойших үүсэж болох эрсдэл ихэссэн үед **нийт хугацааны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан** бүртгэхээс гадна шатлал 3-аас эрсдэл буурч буй зээлүүд дахин ангилагдана.

Шатлал3 - Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан буюу 91-ээс дээш хоног хугацаа хэтэрч алдагдал бий болсон зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойших үүсэж болох эрсдэл ихэссэн үед **нийт хугацааны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан байгуулан** бүртгэнэ.

Групп нь дээрх хугацааны хүчин зүйлээс гадна зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй томоохон мөнгөн урсгал зэргийг мөн харгалзаж үздэг.

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮНЦ ХХК
InvesCore CAPITAL
1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР ББСБ ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27
БҮРТГЭЛ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭЛ-02

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

f. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Компани нь дээрх гурван шатлалыг үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөн урсгалаар зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)-г тооцоолдог. Мөнгөний урсгал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм. ЗҮЦХА тооцооллын гол нөлөөлөгч хүчин зүйлийг тайлбарлан харуулбал:

Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал

Зээл төлөгдөхгүй байх эрсдэл тус бүрд үндэслэн тооцоолсон зээлийн алдагдлын жигнэсэн дунджийг илэрхийлнэ. Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал нь үнэ цэнийн бууралтыг тооцох санхүүгийн хэрэгслийн нийт дансны үнийг илэрхийлж, зээлдэгчийн хувьд анхдагч болон боломжит эрт төлбөрт ойртох тусам өртөх чадвараа нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэгсэл нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой

Зээлийн эргэн төлөлт хийгдээгүйгээс хүлээх алдагдал

Зээл нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүссэн хуримтлагдсан хүүг харгалзсан, ирээдүйн эргэн төлөлт хийгээгүйгээс хүлээх алдагдлыг тооцоолдог. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тооцоолол

СТОУС 9-ийн дагуу санхүүгийн бүх хөрөнгийн ангиллын үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжихэд, ялангуяа үнэ цэнийн бууралтын алдагдлыг тодорхойлохдоо ирээдүйн мөнгөн гүйлгээний хэмжээ ба цаг хугацаа, барьцаа хөрөнгийн үнэлгээ зэрэг тооцооллыг шаарддаг. Эдгээр тооцоолол нь нөөц өөр өөр хэмжээтэй болж өөрчлөхөд хүргэдэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаардаг.

Тооцоололд дараах үндсэн орц мэдээлэл, төлөөллүүд ашиглагддаг. Үүнд:

- Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал /Exposure at default/ -PD
- Зээлийн эргэн төлөлт хийгдээгүйгээс хүлээх алдагдал /Loss given default/ - LGD
- Эдийн засаг ба/эсвэл зах зээлийн ерөнхий нөхцөл байдлын өөрчлөлт (ажилгүйдлийн түвшин, хүүгийн түвшин өсөх магадлал г.м.);
- Зээлдэгчийн үйл ажиллагааны үр дүн эсвэл санхүүгийн байдалд томоохон өөрчлөлт орох;
- Аж ахуйн нэгжийн авах боломжтой санхүүгийн дэмжлэгийн үнийн дүнд өөрчлөлт орох (толгой компаниас г.м.);
- Зээлийн гэрээний нөхцөлийг зөрчих боломж эсвэл таамаглал
- Төлбөр төлөлт хойшлогдох магадлал (Тэмдэглэл: зээлийн эрсдэлд томоохон өөрчлөлт ортол төлбөр хойшлогдох тохиолдол гарахгүй байж болно).

Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнэ буурч, зээлдэгч ямар ч төлбөрийн чадваргүй болсон эсвэл шүүхийн шийдвэр гарсан үед групп нь засаглах удирдлагаар авч хэлэлцэн шууд данснаас хасах эсэхийг шийдвэрлэдэг.

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesC
УЛААНБААТАР

000178

СЗХ 2021 05 27 БҮРТГЭВ № 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021 -05- 03 БҮРТГЭВ-02

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

g. Санхүүгийн өр төлбөр

Өр төлбөрийг олж авсан зорилгоос хамаарч групп санхүүгийн өр төлбөрийг доор дурдсан хоёр төрлийн аль нэгээр нь ангилдаг. Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг групп дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болоогүй мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр болон мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүрийн тухай "Санхүүгийн хөрөнгө" хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Групп нь банктай үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцлүүд хийдэг бөгөөд үүнд гадаад валютын своп гэрээ хэлцлүүд багтана. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэн эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг үед өр төлбөр гэж бүртгэнэ.

Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар группт арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээл болон компанийн буцаан дуудах давуу эрхтэй хувьцааг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмждэг. Ингэснээр санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацааны турш тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөр бүрийн зорилгын хувьд хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купоны өглөг багтаадаг.
- Хөрвөгч зээлийн өрийн хэсгийг доор тайлбарласны дагуу хэмжинэ.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн худалдааны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

h. Хувьцаат капитал

Группийн гаргасан санхүүгийн хэрэгслүүд санхүүгийн өр төлбөр, хөрөнгийн шалгуурыг хангахгүй байх тохиолдолд л тэднийг өмчөөр ангилна. Групп энгийн хувьцаагаа өмчийн хэрэглүүр гэж ангилсан.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК InvesCore CAPITAL 8119277128 УЛААНБААТАР ХОТ

000179

"ИНВЕСКОР ББСБ" ХК УЛААНБААТАР ХОТ

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

i. Ногдол ашиг

Ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчийн группд оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийн татан авалт юм. Ногдол ашиг олгох эсэх болон нэгж хувьцаанд хэдэн төгрөгийн ногдол ашиг олгохыг группийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр тогтоох бөгөөд түүний зарласан тайлант хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

j. Зээлийн өртөг

Хугацаа шаардсан хөрөнгийн худалдаж авах, барьж байгуулах, үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн зардлыг тухайн хөрөнгө иж бүрэн, ашиглахад бэлэн болох хүртэлх хугацаанд капиталжуулдаг. Тухайн зорилгоор авсан зээлтэй холбоотой хүүгийн түвшин эсвэл группийн зээлийн ерөнхий эх үүсвэр нь ашиглагдаж буй бол жигнэсэн дундаж хүүгийн түвшнээр санхүүгийн зардлыг капиталжуулдаг. Зээлийн өртгийн капиталжуулалт нь хөрөнгийн барьж босгох үйл явц зогссон үед дуусдаг. Бусад зээлийн өртөг нь тухайн зардал гарсан үеийн хугацаандаа санхүүгийн зардалд тайлагнагддаг.

k. Түрээс

Түрээсийг тодорхойлох
Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг групп түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:

(а) Тодорхойлсон хөрөнгөтэй;
(б) Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг групп хүртдэг; ба
(в) Групп хөрөнгийг ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг групп харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй. Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг групп хүртэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо групп нь хууль ёсны эзэмшил эсвэл бусад боломжит үр өгөөжтэй хамааралтай бус харин зөвхөн хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг л авч үзнэ.

Групп нь хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо ашиглалтын хугацааны туршид хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахаа удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг харгалзан үзнэ. Хөрөнгийн шинж чанарын улмаас шийдвэр нь урьдчилан тодорхойлогдсон тул тухайн хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахтай холбоотой хамгийн их хамааралтай шийдвэр гаргахгүй байх үед групп нь хөрөнгийн загварыг гаргах үед ашиглалтын хугацааны турш хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахыг урьдчилан тодорхойлох байдлаар оролцсон эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь эдгээр шалгуурыг хангахгүй бол групп СТОУС 16-гаас бусад холбогдох СТОУС-ын мөрдөнө.

Дараах түрээснээс бусад бүх түрээсийг ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрөх замаар бүртгэнэ:

- Бага үнэ цэнтэй хөрөнгийн түрээс; ба
- 12 сар эсвэл түүнээс бага хугацаатай түрээс.

СЗХ
2021 -05- 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭСЭН-02

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

k. Түрээс (үргэлжлэл)

Түрээслүүлэгчид төлөх гэрээний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хэмжинэ. Түрээсийн нуугдмал хүүгийн түвшнийг шууд тодорхойлох боломжит бол уг түвшнийг ашигласнаар түрээсийн төлбөрийг дискаунтчилна. Хэрэв тэрхүү түвшнийг шууд тодорхойлох боломжгүй бол группийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглана.

Зөвхөн индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралтай л бол түрээсийн хувьсах төлбөрийг түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд оруулна. Ийм үед түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ хувьсах элементүүд нь түрээсийн хугацаанд өөрчлөгдөхгүй гэж төсөөлдөг. Түрээсийн бусад хувьсах төлбөрүүдийг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

l. Худалдан авсан биет бус хөрөнгө

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэж эдийн засгийн ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна. Ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгөд хорогдол тооцохгүй бөгөөд тайлант үе бүрийн эцэст аливаа үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг хянаж үзнэ.

Биет бус хөрөнгө	Ашиглалтын хугацаа
Программ хангамж	10 жил

m. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө (хөгжүүлэлтийн зардал)

Дараах шалгууруудыг хангасан бол дотооддоо хөгжүүлсэн бүтээгдэхүүний зардлыг капиталжуулна:

- борлуулах бүтээгдэхүүнийг боловсруулах техникийн боломжтой
- хөгжүүлэлтийг гүйцэтгэх хэмжээний зохих нөөц бололцоотой
- бүтээгдэхүүнийг гүйцэтгэж, борлуулах зорилготой
- Групп бүтээгдэхүүнээ борлуулах чадвартай
- бүтээгдэхүүний борлуулалт нь ирээдүйн эдийн засгийн өгөөж бий болгох ба
- төслийн зарцуулалтыг найдвартай хэмжих боломжтой.

Боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулснаар олохоор таамаглаж буй өгөөжийн хугацаанд капиталжуулсан хөгжүүлэлтийн зардлыг хорогдуулна. Хорогдуулалтын зардлыг Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн удирдлагын зардалд тусгана.

Хөгжүүлэлтийн зардал болон дотоодын төслийн судалгааны үе шатанд гарсан зардал нь дээрх шалгууруудыг хангахгүй байх тохиолдолд Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

000161

"ИНВЕСКОР ББСБ" ХК

СЭХ
2021 05. 27.
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭВ-02

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

п. Өмч, барилга, тоног төхөөрөмж

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх хүлэн зөвшөөрсний дараа үеэс анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь хэмжинэ. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг барилга, тоног төхөөрөмжийн тусдаа зүйл болгон бүртгэдэг.

Элэгдэл

Газарт элэгдэл тооцдоггүй. Дуусаагүй барилгыг бүрэн барьж, ашиглахад бэлэн болох хүртэл элэгдүүлдэггүй. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн бусад бүх зүйлсэд элэгдэл тооцох бөгөөд ингэснээрээ тэдний дансны үнэ цэнийг таамагласан ашиглалтын хугацааны туршид данснаас хасах юм. Тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлэх өртгөөс шулуун шугамын аргаар элэгдэл тооцох бөгөөд элэгдлийг тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Элэгдүүлэх өртөг нь тухайн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны эцэст буцаан борлуулах боломжит өртгийг хассан дүн байна. Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрд дахин тооцож үзнэ.

Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

Өмч, барилга, тоног төхөөрөмж	Ашиглалтын хугацаа
Барилга	25 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	2 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга, эд хогшил	10 жил

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

099162

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

о. Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжинэ. Бараа материалын өртөгт худалдан авалттай холбоотой бүх зардал, хувиргалтын зардал болон бараа материалыг өнөөгийн байршил ба нөхцөлд авч ирэхтэй холбоотой гарсан бусад бүх зардал багтана.

Цэвэр боломжит үнэ цэнэ нь тогтоогдсон борлуулах үнээс зарж борлуулахтай холбоотой зардлуудыг хассан дүнгээр тодорхойлогдоно. Хуучирсан, илүүдэл нөөцтэй, болон удаан гүйлгээтэй бараа материалуудыг олж тогтоож, цэвэр боломжит үнэ хүртэл нь бууруулж бүртгэдэг. Хэвийн харилцан сольж болохуйц зүйлсийн өртгийг тодорхойлоход жигнэсэн дундаж өртгийг хэрэглэдэг.

р. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба бүлэг хөрөнгө

Дараах тохиолдолд эргэлтийн бус хөрөнгө болон борлуулах бүлэг хөрөнгийг борлуулах зорилготой гэж ангилна:

- Шууд борлуулахад бэлэн
- Удирдлага бүтээгдэхүүнийг борлуулахаар шийдсэн
- Төлөвлөгөөнд ямар нэгэн томоохон өөрчлөлт орох эсвэл төлөвлөгөөг цуцлах магадлал бага
- Худалдан авагчдыг тогтоох идэвхтэй хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн
- Хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгийг бодит үнэ цэнэтэй нь харьцуулахад тогтоосон үнэ нь үндэслэлтэй, ба
- Ангилал хийсэн өдрөөс хойш 12 сарын дотор борлуулалт хийгдэнэ гэж үзэж байгаа.

Борлуулах зориулалттай гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгө болон борлуулах бүлэг хөрөнгийг дараах зүйлсийн аль багаар нь хэмжинэ:

- Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу борлуулахад бэлэн гэж ангилахын өмнөх дансны үнэ; ба
- Борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ.

Борлуулах зорилготой гэж ангилсны дараа эргэлтийн бус хөрөнгийг (борлуулах бүлэг хөрөнгө дэх хөрөнгө багтана) элэгдүүлэхгүй.
Тайлант жилд борлуулсан үйл ажиллагааны үр дүнг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд борлуулалтын өдөр тусгана.

q. Засгийн газрын буцалтгүй тусламж

Худалдан авсан хөрөнгийн дансны үнийг тодорхойлохдоо капиталын зарцуулалтад олгосон засгийн газрын буцалтгүй тусламжийг ихэвчлэн суутгадаг. Орлогын зарцуулалтын зориулалттай буцалтгүй тусламжийг Группийн өртөгтэй тулган цэвэрлэдэг. Групп тавигдсан шалгуурыг хангаж чадах эсэхээс засгийн газрын буцалтгүй тусламж авах эсэх нь хамаардаг тул түүнийг анх хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрдөг. Харин буцалтгүй тусламжийн шалгуурыг хангасны дараа хойшлогдсон орлогын үлдэгдлийг Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгах эсвэл худалдан авсан хөрөнгөтэй тулган цэвэрлэнэ.

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

г. Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлого, зардалд хүүгийн орлого/зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз/гарз, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн олз/гарз, ажилчдын тэтгэмжийн төлөвлөгөөний олз/гарз хамаарна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

s. Тайлант жилийн болон хойшлогдсон татвар

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагддаг. Группийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Нэгтгэсэн Санхүүгийн байдлын тайланд тусгасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь татварын сууриас зөрүүтэй байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрдөг. Харин дараах зүйлсээс үүссэн зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр гэж үзэхгүй:

- Гүүдвилийн анхны хүлээн зөвшөөрөлт
- Тухайн ажил гүйлгээ гарсан үедээ нягтлан бодох бүртгэлийн эсвэл татварын ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, бизнесийн нэгдлийн бус ажил гүйлгээний хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт, ба
- Гарсан зөрүүнд буцаалт хийх хугацааг групп хянах чадвартай охин компани болон хамтарсан хэлэлцээрт оруулсан хөрөнгө оруулалт ба тухайн зөрүүг ойрын ирээдүйд буцаахгүй байх магадлалтай байх.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.
Хөрөнгө эсвэл өр төлбөрийн татварын суурь, тодорхой ажил гүйлгээний татвар ногдоо байдал, эсвэл татвартай холбоотой бусад төсөөлөлтэй холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд Групп нь:

- Тодорхой бус татварын байр суурийг тусад нь эсвэл багцлан авч үзэх эсэх (шийдвэрлэлтийг нь хамгийн сайн таамаглаж чадах аргад үндэслэн);
- Тодорхой бус татварын байр суурийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтын эсэхийг тодорхойлох: ба

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

s. Тайлант жилийн болон хойшлогдсон татвар (үргэлжлэл)

- Тодорхой бус татварын байр суурийг хүлээн зөвшөөрөх магадлалгүй бол тодорхой бус байдлын шийдвэрлэлтийг хамгийн сайн таамаглах аргаас хамаарч хамгийн боломжит үнийн дүн эсвэл таамагласан үнэ цэнийн аргад үндэслэн тодорхой бус татварын байр суурийг хэмжинэ. Энэхүү хэмжилтийг хийхийн тулд татварын алба тус бүр өөрсдийн шалгах эрхтэй бүхий л үнийн дүнг шалгах бөгөөд эдгээр шалгалтыг хийхдээ холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна эгсэн төсөөлөлд суурилахыг шаарддаг.

Групп нь тайлант жилийн татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэрлэх хуульд заасан эрхтэй бөгөөд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь нэг ижил татварын эрх бүхий байгууллагад ногдуулсан татвартай дараах нөхцөлийн аль нэг байдлаар холбоотой байгаа бол хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь цэвэрлэнэ.

- Татвар ногдуулах ижил байгууллага, эсвэл
- Татвар ногдуулах ялгаатай байгууллагаас цэвэр сууриар тайлант үеийн өр төлбөрийг ба хөрөнгийг барагдуулах эсвэл ирээдүйн тайлант үе бүрд барагдуулахаар буюу нөхөхөөр төлөвлөсөн хойшлогдсон татварын өр төлбөр буюу хөрөнгийн нөлөө бүхий дүнгээр хөрөнгийг хүлээн авсан ба өр төлбөрийг нэгэн зэрэг барагдуулахаар төлөвлөсөн.

t. Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал)

Нэгж хувьцаанд ногдох ашиг(алдагдал) нь группийн тайлант жилийн турш эргэлтэд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваарилагдсан цэвэр ашиг, алдагдлаар тооцоологддог. Энэ нь энгийн хувьцаа нэг бүрд ногдох тайлант жилийн ашиг, алдагдлын дүнг илэрхийлнэ. Групп аливаа хорогдуулагч хэрэглүүр эзэмшдэг бол нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг(алдагдал)-ийн тооцоог мөн хийж тайлагнана.

u. Ажилчдын тэтгэмж

Түр хугацааны ажилчдын тэтгэмж
Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй суууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг. Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн групп хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа группийн компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд үг зардлыг гарсан тухайн үед нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

47. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

v. Холбоотой талууд

Хэрвээ тухайн групп нь нөгөө этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн группийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн групп өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно.

а) Аливаа хувь хүн эсвэл түүний ойр дотнын гэр бүлийн гишүүнийг дараах тохиолдлуудад группийн хувьд холбоотой тал гэж үзнэ. Хувь хүн нь:

(i) Группийг хянадаг эсвэл хамтын хяналттай бол;
(ii) Группэд мэдэгдэхүйц нөлөөтэй бол; эсвэл
(iii) Групп эсвэл түүний толгой Группийн гол удирдлагын багийн гишүүний нэг бол.

Компанийг дараах тохиолдлуудад нөгөө компанийн холбоотой тал гэж үзнэ:

(i) Нэг групп компанийн бүрэлдэхүүн компаниуд хоорондоо холбоотой талууд байна;
(ii) Компани нь нөгөө компанийнхаа хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол (эсвэл компани нь нөгөө компанийн харьяалагддаг группийн өөр нэг гишүүн компанийн хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол);
(iii) Хоёр компани хоёулаа нэг ижил гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд бол;
(iv) Компани нь гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба нөгөө компани нь уг гуравдагч талын хараат компани бол;
(v) Компани нь нөгөө компанийн эсвэл түүнтэй холбоотой компанийн ажиллагсдын ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг бол;
(vi) (а)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид хяналт эсвэл хамтын хяналттай бол; эсвэл
(vii) (а)(i)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид мэдэгдэхүйц нөлөөтэй, эсвэл нөгөө компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Групптэй хийх хэлцэлд өөрөө болон уг хувь хүнээр дамжуулан нөлөө үзүүлэх магадлалтай гэр бүлийн гишүүдийг ойр дотнын гэр бүлийн гишүүнд тооцно.

Холбоотой талуудын хоорондх ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой.
Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.

(а) Худалдан авалт
(б) Борлуулалт
(в) Түрээс
(г) Зээл
(д) Баталгаа, барьцааны нөхцөлүүд
(е) Хэрэв ирээдүйд тодорхой нэг үйл явдал хэрэгжих эсвэл хэрэгжээгүй үед ямар нэг үүрэг хүлээх амлалт
(ж) Аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс эсвэл холбоотой талын нэрийн өмнөөс аж ахуйн нэгж өр төлбөрийг барагдуулах

Компанийн санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

СЗХ
2021 .05.27 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIA STOCK EXCHANGE
2021 -05- 03
ГЭВ-02

48. Зэрэгцүүлэх үзүүлэлт

Тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс дараах зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

2019 оны 12-р сарын 31		Дахин ангиллын өмнөх мян.төг	Дахин ангилал мян.төг	Дахин ангиллын дараах мян.төг
Өр төлбөр				
Санхүүгийн өр төлбөр	(i)	4,510,193	(790,236)	3,719,957
Санхүүгийн бус өр төлбөр	(i)	799,118	788,506	1,587,624
Орлогын албан татварын өр	(i)	980,078	1,730	981,808

(i) - Үйлчлүүлэгчийн түрээсийн өр төлбөрийн дүн болон орлогын албан татварын өр төлбөрийг СЗХ-ны дүрэм, журмын дагуу санхүүгийн өр төлбөрөөс санхүүгийн бус өр төлбөр лүү дахин ангилал хийсэн.

49. Тайлангийн орчүүлга

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд тэдгээрийн хооронд ялгаа, зөрчилдөх зүйл гарвал Монгол хэл дээрх хувийг баримтална.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
1119277123
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар ердөр
2021 05 27
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

"ИНВЕСКОР ББСБ" ХК-ААС ӨРИЙН БИЧИГ ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААР

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

Хаана:	**"ИНВЕСКОР ББСБ" ХК-д**
Хаяг:	**Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Твин Тауэр-1, Байрны зүүн жигүүр, 13 давхар**
Утас/Факс:	**(976) 7709-0077**
Хааналс:	**"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН**
Хаяг:	**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот**
Утас/Факс:	**(976-11) 330048, (976-11) 330049**
Огноо:	**2020 оны 12 дугаар сарын 29-ний өдөр**

ӨМГӨӨЛЛИЙН
ТТБ
УЛА

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
8060854 1119286068
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2021.05.27
БҮРТГЭВ
1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

2020.12.29 № Д-20/236

"ИНВЕСКОР ББСБ" ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
НАР ТАНАА

"ИНВЕКСОР ББСБ" ХК-ИАС ӨРИЙН БИЧИГ ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААР ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

Тус "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь (цаашид "**МДСХ**" гэх) нь "Инвескор ББСБ" ХК (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх)-ийн өрийн бичиг гарган нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэх талаар энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Энэхүү Дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд энэ нь аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй болно.

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Энэхүү Дүгнэлт нь зөвхон хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа тоон мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Энэхүү Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх талаар;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна." гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий мэдээллийн талаар;
6. Энэхүү Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон, эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
7. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төловлогоо, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү Дүгнэлттэй холбоотой бид гаргахгүй болно;
8. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

"ИНВЕСКОР КАПИТАЛ" ХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286863
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 .05Р 27
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

МДСХ нь байгаль орчинд ээлтэй байгууллага болох зорилгынхоо хүрээнд болон Ковид 19-ийн нөхцөл байдлын улмаасулс даяар бэлэн байдал зарлаад байгаа нөхцөлд хүн хоорондын харилцаа контактыг бууруулах шаардлагыг харгалзан энэхүү Дүгнэлтийн хавсралт болох нотлох эх сурвалжуудыг файл хэлбэрээр флаш дискэнд хадгалж хавсаргасан болно. Софт хэлбэрээр хүргүүлж буй нотлох баримтууд нь Үнэт цаас гаргагч болон холбогдох байгууллагаас ирүүлсэн хувийн үнэн зөв хуулбар бөгөөд Зөвлөхийн зүгээс ямар нэг өөрчлөлт оруулаагүй болохыг үүгээр баталж байна.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС ХХН
6495997
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БЭСБ" ХК
6060054 1119296063
УЛААНБААТАР ХОТ

000176

СЗХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

АГУУЛГА

Удиртгал 5

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх 7

2. Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний Компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдлаар 9

3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх 19

4. Бусадтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх 29

5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх 41

6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин тоголдор эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх 44

7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх 47

8. Үнэт цаас бүртгүүлэх оргодол, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төголдор баримтаар нотлогдож байгаа эсэх 51

9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох 53

10. Тухайн Компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа 54

11. Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ 55

Гол дүгнэлт 56

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БЕСБ" ХХК
InvesCore
6060854 ☎1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 -05- 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 03
БҮРТГЭВ-02

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "**МДСХ**", эсхүл "**Бид**" гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "**СЗХ**" гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн богоод СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Инвескор ББСБ" ХК (Регистрийн дугаар: 6060854), (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх) нь өрийн бичиг гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч, улмаар бид 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Д-С0032018 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байна.

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйл (Компанийн үнэт цаас гаргах, худалдах, эргүүлэн авах), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу өрийн бичиг гаргаж СЗХ, Монголын хорангийн бирж (цаашид "**МХБ**" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

Хангагдсанд тооцох нөхцөл

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
6. Загвар хувилбараар ирсэн баримт бичиг нь тухайн хувилбарыг үндэс болгон баталгааждаг;
7. Компани, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хорангийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;

ИНВЕСКОР ЭЛИТ ББСБ ХХК
InvesCore CAPITAL
6317839 рд.1119277128
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР ЭЛИТ ББСБ ХХК
6060854 рд.1119296063
УЛААНБААТАР ХОТ

2021 05 27
БҮТГ
01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй.

Энэхүү өрийн бичгийн бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ-ийн "Арилжааны журам"-ын дагуу явагдана.

Бид Дүгнэлт гаргах зорилгоор Компаниас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг эх хувь болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317939 ж.1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 оны 03 сар 27 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -03- 03
MDSKhanLex
БҮРТГЭВ-02

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх

"Инвескор ББСБ" ХХК нь Компанийн тухай хуулийн дагуу нэг гишүүн (Монгол Улсын иргэн Н.Нармандах РД: АЗ62022114)-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. (Улсын бүртгэлийн дугаар: 9010002004, Регистрийн дугаар: 6060854) (Хавсралт 1.3, Хавсралт 1.5, Хавсралт 1.6).

Хувьцаа эзэмшигч Н.Нармандах нь өөрийн эзэмшлийн хувьцаанаас "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-д шилжүүлснээр 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь "Инвескор ББСБ" ХХК-ийн 39.29 хувийн хувьцаа эзэмшигчээр, цаашлаад 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 100 хувийн цор ганц хувьцаа эзэмшигчээр улсын бүртгэлд бүртгэгджээ. (Хавсралт 11.15)

"Инвескор ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Хувьцаа нэмж гаргах, хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох тухай" А/03 дугаартай шийдвэр (Хавсралт 1.7)-ээр Компанийн 10,759,188 (арван сая долоон зуун тавин ссөн мянга нэг зуун наян найман) ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн "Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай" 70 дугаартай тогтоол (Хавсралт 1.8)-оор СЗХ-ооc зөвшөөрснөөр Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болсныг 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн байна (Хавсралт 11.15).

Үнэт цаас гаргагч нь 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн гэрчилгээ (Хавсралт 1.3), 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр баталж, 2020 оны 05 сарын 28-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн Инвескор ББСБ ХК-ийн дүрэм (Хавсралт 1.4)-д тусгаснаар зээлийн үйл ажиллагаа, факторингийн үйлчилгээ үзүүлэх, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт оруулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл огох, итгэлцлийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэхээр заасан байна.

Үнэт цаас гаргагч нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зовшоорлийн тухай" хуулийн 10.1.1, 15, 15.3.1, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 9.1-д заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ 101/554 дугаар тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.1), 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.3), мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйл ажиллагаа, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.2) авсан байна.

Компанийн мэдээлэл:
Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар: 000186924;
Улсын бүртгэлийн дугаар: 9010002004;
Регистрийн дугаар: 6060854;
Хуулийн этгээдийн нэр, харицлагын хэлбэр: "Инвескор ББСБ" Хувьцаат Компани;
Хугацаа: Хугацаагүй;
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 315 (2020 оны 12 дугаар сарын 16-ны одрийн үнэт цаас эзэмшигчдийн хураангуй судалгаа);
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ: 16,282,237.386 (Хавсралт 1.4, 9.1);
Хуулийн этгээдийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, сөүл 10/1, Твин Тауэр-1 байрны зүүн жигүүр 13 давхар;
Гэрчилгээ олгосон огноо: 2019.06.11;
Гүйцэтгэх захирал: Д.Баясгалан.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6347839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

Энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн тухай 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр олгогдсон Улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000186924, Улсын бүртгэлийн дугаар 9010002004, Регистрийн дугаар 6060854) (Хавсралт 1.3) бүхий "Инвескор ББСБ" ХК нь хууль зүйн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

СЗХ
2021 .05.27 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhanBex 2021-03-03

2. Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний Компанийг удирдах чадвар, дадлага туршлагын байдлаар

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрмийн 14.1-д зүй Компанийн эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалтад "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна. Иймд Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд[1] үндэслэн зүй Компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэгт ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү хариуцсан захирал, Хууль, эрсдэлийн удирдлага хариуцсан захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Дэд захирал, Салбарын удирдлага хариуцсан захирал болон Зөөлийн хороодын гишүүдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд хамруулан авч үзлээ.

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу гурван хувьцаа эзэмшигч (Япон Улсын иргэн Кавазоэ Такааки Паспортын дугаар: TR8201699; Монгол Улсын иргэн Баянмөнхийн Анхболд РД: ЧК80011134; Монгол Улсын иргэн Батбаярын Мөнх-Очир РД: ВЮ90031832)-тэйгээр 2016.03.21-ний өдөр үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн (Улсын бүртгэлийн дугаар: 9011739005; РД: 6057209) Монгол Улсын хуулийн этгээд (Хавсралт 9.2, Хавсралт 9.3) юм.

Б.Анхболд нь Хувьцаа эзэмшигчийн 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/24 тоот шийдвэр (Хавсралт 2.1), Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/05 тоот тогтоол (Хавсралт 2.2), ТУЗ-ийн хурлын 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/28-Т тоот тогтоол (Хавсралт 2.3)-оор тус тус ТУЗ-ийн гишүүн бөгөөд даргаар сонгогдон ажиллаж байна. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/05 тоот тогтоол (Хавсралт 2.2)-оор сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гишүүдийн боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

№	Нэр	Боловсрол	Ажлын туршлага
ЕРДИЙН ГИШҮҮД:			
1.	Баянмөнхийн Анхболд (Хавсралт 2.4)	2000-2004 онд Рицумэйкан Ази-Номхон Далайн Их Сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр; 2004-2006 онд Рицумэйкан Ази-Номхон Далайн Их Сургуульд Бизнесийн удирдлагын магистр;	2006-2012 онд "Абим Консалтинг" ХХК-д бизнесийн ахлах зөвлөх; 2012-2015 онд "Шунхлай групп"-д хүний нөөцийн карьер төлөвлөлт хариуцсан захирал, дэд ерөнхийлөгч; 2016 оноос одоог хүртэл Эс Ай Би Жэй Капитал ХХК-д Гүйцэтгэх захирал.
2.	Далайжамцын Баясгалан (Хавсралт 2.5)	1997-2001 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд Эдийн засгийн	2001-2011 онд Худалдаа хөгжлийн банкинд Санхүүгийн газрын ахлах мэргэжилтэн;

[1] Компанийн дүрмийн 14.1: Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Газрын захирлууд, болон Зөөлийн хорооны гишүүд нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
Investcore CAPITAL
6317839 д.1119277120
УЛААНБААТАР ХОТ

000182

"ИНВЕСКОР ЕБСБ" ХК
Investcore
д.1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

		ухааны бакалавр;	2005-2005 онд Монголбанкинд Төслийн менежер; 2016 оноос одоог хүртэл "Инвескор ББСБ" ХК-д Гүйцэтгэх захирал.
3.	Равжирын Мөнхтөр (Хавсралт 2.6)	1997-2001 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд Эдийн засагч, эдийн засгийн онолын багш мэргэжлээр бакалавр; 2001-2003 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд Эдийн засгийн ухааны магистр;	2001-2005 онд Сэрүүлэг дээд сургуульд Багш; 2005-2016 онд Монгол Улсын Их сургуульд Багш; 2011-2016 онд Хогжлийн банкинд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга; 2016 оноос одоог хүртэл ТУЗ-ийн гишүүн.
4.	Намики Хирохито (Хавсралт 2.7)	1988-1992 онд Япон Улсын Кейо их сургуульд Эдийн засгийн ухааны бакалавр; 2003-2005 онд АНУ-ын Рочестар их сургуульд Эдийн засгийн болон бизнесийн удирдлагын магистр; АПУ-ын Вашингтон хотын Нягтлан бодох бүртгэлийн CPA зэрэг.	1992-2014 онд Мицубиши ЮФЖ Итгэлийн банкинд санхүүгийн зөвлөх, компанийн стратеги хариуцсан ажилтан; 2014 оноос одоог хүртэл "Эс Ай Би Эй ФЖ" ХХК-ийн үүсгэн байгуулагч.
5.	Гончигдоржийн Уянгахишиг (Хавсралт 2.8)	1994-1998 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээр сургуульд Эрх зүйч мэргэжлээр бакалавр; 1999-2002 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бонн хотын Их Сургуульд Харьцуулсан эрх зүйн магистр.	2002-2010 онд "Цэц" хуулийн фирмд Өмгөөлөгч, Партнер; 2010-2012 онд "Си Энд Жи Партнерс" хуулийн фирмд үүсгэн байгуулагч, партнер; 2012-2014 онд "Шупхлай Групп" ХХК-д үйл ажиллагаа хариуцсан захирал; 2015-2018 онд "Голомт банк" ХХК-д хуулийн хэлтсийн захирал; 2018 оноос одоог хүртэл "Инвескор Капитал ҮЦК" ХХК-д Гүйцэтгэх захирал.
6.	Тунсагийн Тэлмэн (Хавсралт 2.9)	1996-2000 онд Санхүү Эдийн Засгийн Дээд сургуульд Банк, зээлийн эдийн засагч санхүүч бакалавр; 2007-2009 онд Миссури мужийн Их Сургуульд Бизнесийн удирдлагын магистр.	2000-2010 онд Монголбанкинд Аудитор, хяналт шалгагч; 2010-2013 онд Монгол даатгалд Даатгал эрхэлсэн дэд захирал; 2013-2014 онд Монгол алт компанид Хоронго оруулалтын газрын захирал; 2014-2016 онд "Микрокредит ББСБ" ХХК-д Гүйцэтгэх захирал; 2016-2017 онд Ходолмор

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6317839 1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 .05. 27 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

			Нийгмийн хамгааллын яаманд Сайдын зөвлөх; 2017-2019 онд Монгол амьдрал ХХК-д Захирал; 2019 оноос одоог хүртэл Амар даатгал ХХК-д Бизнес хөгжлийн газрын захирал
ХАРААТ БУС ГИШҮҮД:			
7.	Чулуундоржийн Хашчулуун (Хавсралт 2.10)	1984-1989 онд ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийг эдийн засагч, улс төрийн эдийн засгийн онолын багш чиглэлээр бакалавр; 1994-1996 онд Япон Улсын Йокохома хотын их сургуулийг эдийн засгийн ухааны магистр; 1996-2003 онд Япон Улсын Кеио Их сургуулийг эдийн засгийн ухааны доктор.	2004-2009 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд захирал; 2009-2012 онд Засгийн газрын тохируулагч агентлагид Үндэсний хөгжлийн Шинэтгэлийн хорооны дарга; 2010-2011 онд Хөгжлийн банкинд ТУЗ-ийн дарга; 2012 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Сургуульд Эдийн засгийн тэнхмийн Профессор.
8.	Дангаасүрэнгийн Энхбат (Хавсралт 2.11)	1975-1980 онд Уралын Техникийн ИС /УПИ/-д Системийн инженер; 1984-1988 онд Оросын шинжлэх ухаан, технологийн улсын их сургууль /МИСИС/-д Техникийн шинжлэх ухааны доктор.	1980-1984 онд Статистикийн төв газарт Програм зохиогч; 1988-1989 онд Микропроцессорын техникийн олон улсын лабораторид эрхлэгч; 1989-1991 онд Үндэсний информатикийн төвд Захирал; 1990-1991 онд Шинжлэх ухааны техникийн улсын хороонд Дэд дарга; 1991-1993 онд Үндэсний хөгжлийн яамд Дэд сайд; 1994-2008 онд Датаком ХХК-д Ерөнхий захирал; 2008-2012 онд Улсын их хурлын гишүүн; 2012-2018 онд Нээлттэй мэдлэг боловсролын хүрээлэнд Удирдах зөвлөлийн дарга; 2018 оноос одоог хүртэл Хархорум Дижитал ХХК-д Ерөнхий захирал.
9.	Чимэдгочоогийн Өнөржаргал (Хавсралт 2.12)	1993-1997 онд Санхүү Эдийн Засгийн Дээд сургуульд Ня-бо эдийн засагч мэргэжлээр бизнесийн удирдлагын бакалавр; 2000-2002 онд Монгол Улсын	1996-2000 онд Монгол Японы хамтарсан "Монгол Ханамаса ба ГБ" ХХК-д Тооцооны нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчид; 2000-2002 онд Засагт хан дээд

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БЕСБ" ХХК
InvesCore
УЛААНБААТАР

СЗХ
2021 -05- 27
БҮРТГЭВ
№ 21

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

		Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд Бизнесийн удирдлагын магистр.	сургуульд Цагийн багш; 2002-2005 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуульд багш; 2003-2009 онд "Саксон Монголиа" ХХК-д гэрээт нягтлан бодогч; 2005 оноос одоог хүртэл Санхүү Эдийн Засгийн Их сургуульд Багш.

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нь "Инвескор ББСБ" ХХК-ийн үүсгэн байгуулагчийн 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/02 тоот шийдвэр (Хавсралт 2.13), ТУЗ-ийн хурлын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/40-Т тоот тогтоол (Хавсралт 2.14)-оор, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Энэрэл нь ТУЗ-ийн даргын 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/04-ТД тоот шийдвэр (Хавсралт 2.15)-ээр, Санхүү хариуцсан захирал Ш.Цэрэндаваа нь Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Б/118 тоот тушаал (Хавсралт 2.16)-аар, Хууль, эрсдэлийн удирдлага хариуцсан захирал Н.Арсланбаатар, Үйл ажиллагаа хариуцсан захирал Ш.Эрдэнэбилэг, Дэд захирал-Санхүү Р.Пүрэв нар нь Гүйцэтгэх захирлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/434 тоот тушаал (Хавсралт 2.17)-аар, Дэд захирал Х.Амгаланбаатар нь Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 дугаар сарын 09-ний одрийн В/341 тоот тушаал (Хавсралт 2.18)-аар, Салбарын удирдлагын хариуцсан захирал О.Дабааням нь Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/081 тоот тушаал (Хавсралт 2.9)-аар, Ерөнхий нягтлан бодогч Г.Ариунзул нь Гүйцэтгэх захирлын 2020 оны 10 дугаар сарын 12-ны одор Б/280 тоот тушаал (Хавсралт 2.20)-аар, Стратеги, удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн захирал С.Тулга нь Гүйцэтгэх захирлын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн Б/200 тоот тушаал (Хавсралт 2.21)-аар тус тус томилогдон ажиллаж байна. Түүнчлэн Зөвлөлийн хорооны гишүүн Р.Пүрэв, Ш.Эрдэнбилэг, Б.Анхболд нар нь Гүйцэтгэх захирлын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн В/02 тоот тушаал (Хавсралт 2.22), 2019 оны 12 дугаар сарын 25-ны одрийн В/368-2 тоот тушаал (Хавсралт 2.23)-аар тус тус томилогдсон байна.

№	Нэр	Боловсрол	Ажлын туршлага
1.	**Далайжамцийн Баясгалан** (Гүйцэтгэх захирал)	(Дээрхээс танилцана уу.)	(Дээрхээс танилцана уу.)
2.	**Амарсанаагийн Энэрэл** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) (Хавсралт 2.24)	2010-2013 онд Америкийн нэгдсэн Улсад Пүрдү их сургуулийн Кэллий Бизнесийн Их Сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр; 2017 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн их сургуульд эрх зүйн бакалавр; 2019 онд Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн их сургуульд Санхүүгийн мэргэжлээр магистр.	2013-2014 онд Эрнст Анд Янг Монгол Аудит ХХК-д туслах аудитор: 2014-2015 онд "Эс Жи Эм Эс" ХХК, Вагнер Ази тоног төхөөрөмж ХХК-д Ерөнхий нягтлан бодогч; 2016 онд Шангр-Ла зочид буудал ХХК-д өглөгийн нягтлан бодогч; 2017-2019 онд ХААН банкинд мэргэжилтэн;

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02
MDSKhanBex
ЭЗХ
2021.05.27
БҮРТГЭВ

			2019 оноос одоог хүртэл "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-д санхүүгийн ахлах мэргэжилтэн.
3.	**Ганхуягийн Ариунзул** (Ерөнхий нягтлан бодогч) (Хавсралт 2.25)	2018 онд Мандах Их Сургуульд Нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалавр.	2018-2019 онд "Инвескор ББСБ" ХК-д нягтлан бодогч; 2020 оноос одоог хүртэл "Инвескор ББСБ" ХК-д Ерөнхий нягтлан бодогч.
4.	**Шанивын Цэрэндаваа** (Санхүү хариуцсан захирал) (Хавсралт 2.26)	1995 онд Монгол Улсын эдийн засгийн коллежийн бизнес удирдлагын бакалавр; 2000 онд Монгол Улсын Их Сургуульд Бизнесийн удирдлагын магистр	1996-1997 онд Ардын Банкинд ня-бо; 1997-2000 онд Европын Сэргээн босголт, хөгжлийн банкинд ня-бо; 2002-2003 онд "Ассейс Инвест ББСБ" ХХК-д ня-бо; 2003-2007 онд Анод банкинд Салбарын эрхлэгч, аудитор; 2007-2014 онд "Кредит Монгол ББСБ" ХХК-д аудитор, дотоод аудитор; 2015-2020 онд Голомт банкинд Ахлах менежер; 2020 оноос одоог хүртэл "Инвескор ББСБ" ХК-ийн Санхүү хариуцсан захирал.
5.	**Нацагдоржийн Арсланбаатар** (Хууль, эрсдэлийн удирдлага хариуцсан захирал) (Хавсралт 2.27)	1997-2001 онд Гурван тамир дээд сургуульд Нягтлан бодох бүртгэл-эдийн засаг мэргэжлээр бакалавр.	2002-2005 онд Хасбанкинд Зээлийн эдийн засагч, Зээлийн эрсдэлийн менежер, Салбарын захирал, Хэлтсийн захирал; 2016-2017 онд Ариг банкинд Эрсдэлийн ахлах шинжээч.
6.	**Шаравхоролын Эрдэнэбилэг** (Үйл ажиллагаа хариуцсан захирал) (Хавсралт 2.28)	1997-2001 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд Нягтлан бодогч-Эдийн засагч мэргэжлээр бакалавр; 2003-2006 онд Японы Ritsumeikan ASia Pacific University-д Олон улсын хамтын ажиллагааны бодлогоор магистр.	2006-2009 онд Худалдаа хөгжлийн банкинд мэргэжилтэн; 2011-2016 онд Гадаад Харилцааны Яамд мэргэжилтэн.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03
MDSKhanLex
БҮРТГЭВ-02

7.	**Ханцуйтын Амгаланбаатар** (Дэд захирал) (Хавсралт 2.29)	2005 онд Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургуульд Санхүү-Банк бакалавр; 2017 онд Монгол Улсын их сургуулийн Бизнесийн сургуульд Бизнесийн удирдлагын магистр.	2005-2010 онд Худалдаа хөгжлийн банкинд эдийн засагч, ахлах эдийн засагч; 2010-2014 онд Худалдаа хөгжлийн банкинд Салбарын захирал; 2014-2019 онд Худалдаа хөгжлийн банкинд Газрын захирал.
8.	**Октябрь Дававаням** (Салбарын удирдлага хариуцсан захирал) (Хавсралт 2.30)	2011 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд менежмент, санхүүгийн бакалавр.	2011-2014 онд Худалдаа хөгжлийн банкинд Данс хариуцсан ажилтан; 2014-2016 Худалдаа хөгжлийн банкинд Данс хариуцсан ахлах ажилтан; 2016-2018 онд Худалдаа хогжлийн банкинд СУГ менежер; 2018-2019 онд Худалдаа хогжлийн банкинд Салбарын захирал.
9.	**Ралгаагийн Пүрэв** (Дэд захирал - Санхүү) (Хавсралт 2.31)	2002 онд Монгол Улсын Эдийн Засгийн Их сургуулийн Эдийн засгийн сургуульд Нягтлан бодох бүртгэл-эдийн засгийн мэргэжлээр бакалавр; 2011 онд Японы Олон Улсын Их Сургуульд Бизнес Удирдлагын магистр.	2002 онд Голомт банкинд Туслах дилер; 2003-2009 онд Сангийн Яаманд Мэргэжилтэн; 2011-2016 онд Оюу толгой ХХК-д аудитор; 2017 онд одоог хүртэл "Инвескор ББСБ" ХК-д Санхүү эрхэлсэн захирал.
10.	**Сэргэлэнгийн Тулга** (Стратеги, Удирдлага, Төлөвлөлтийн хэлтсийн захирал) (Хавсралт 2.32)	2012 онд Санхүү Эдийн Засгийн Дээд сургуульд бизнесийн удирдлагын бакалавр.	2012-2019 онд Голомт банк ХХК-д ахлах менежер; 2019-2020 онд "Эс Жи Эс И Эм" ХХК-д ерөнхий менежер.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА					
№	**Нэрс/Шаардлага**	**Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан**	**Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)***	**Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)**	**Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)**

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317339 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000187

СЭХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhaanLex 2021-02-03
БҮРТГЭВ-02

		тушаал хашдаг эсэх			
1.	**Б.Анхболд** (ТУЗ-ийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.08.25-ны өдөр, Дугаар 0930282/ (Хавсралт 2.33)	Тийм
2.	**Д.Баясгалан** (ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.08.25-ны өдөр, Дугаар 0930283/ (Хавсралт 2.34)	Тийм
3.	**Р.Мөнхтор** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2012.11.30-ны өдөр, Дугаар 0131037/ (Хавсралт 2.35)	Тийм
4.	**Намики Хирохито** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2015.11.07-ны өдөр, Дугаар 0430372/ (Хавсралт 2.36)	Тийм
5.	**Г.Уянгахишиг** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2013.01.19-ны өдөр/ (Хавсралт 2.37)	Тийм
6.	**Т.Тэлмэн** (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.11.144-ний өдөр, Дугаар 0230292/ (Хавсралт 2.38)	Тийм
7.	**Ч.Хашчулуун** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2014.09.06-ны өдөр, Дугаар 1030024/ (Хавсралт 2.39)	Тийм
8.	**Д.Энхбат** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2019.06.15-ны өдөр, Дугаар 0131146/ (Хавсралт 2.40)	Тийм
9.	**Ч. Өнөржаргал** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2019.06.15-ны өдөр, Дугаар 0131143/	Тийм

"ИНВЕСКОР КЭПИТАЛ ХХК"
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КЭПИТАЛ ХХК"
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

000188

СЭХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

				(Хавсралт 2.41)	
10.	**А.Энэрэл** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм /2019.06.13-ны өдөр, Дугаар 0230350/ (Хавсралт 2.42)	Тийм
11.	**Г.Ариунзул** (Еронхий нягтлан бодогч)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
12.	**Ш.Цэрэндаваа** (Санхүү хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
13.	**Н.Арсланбаатар** (Хууль, эрсдэлийн удирдлага хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
14.	**Ш.Эрдэнэбилэг** (Үйл ажиллагаа хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.08.25-ны өдөр, Дугаар 0930285/ (Хавсралт 2.28)	Тийм
15.	**Х.Амгаланбаатар** (Дэд захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
16.	**О.Давааням** (Салбарын удирдлага хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
17.	**Р.Пүрэв** (Дэд захирал - Санхүү)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.08.25-ны өдөр, Дугаар 0930284/ (Хавсралт 2.31)	Тийм

*Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013.01.31-ний өдрийн А/12 тоот тушаалын 4 дүгээр хавсралтад заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг омгооллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан ял шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага

"ИНВЕСКОР БББ" ХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БББ" ХК
InvesCore FINANCIAL INSTITUTION
6368654 ☎1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2021.05.27 ЭВ
№ 41

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

№	Шаардлага	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс		
		Ч.Хашчулуун	Д.Энхбат	Ч.Өнөржаргал
1.	Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1)	Тийм**	Тийм**	Тийм**
2.	Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд аливаа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2, КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
3.	Төрийн үйлчилгээнийхээс бусад торийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3)	Тийм**	Тийм**	Тийм**
4.	Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4)	Тийм**	Тийм**	Тийм**
5.	Сүүлийн 5 жилд компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
6.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
7.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
8.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
9.	Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**
10.	Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх (КЗК-ийн 5.2.4)	Тийм**	Тийм**	Тийм**

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БЕСБ" ХК
InvesCore
6060 ... 119286063
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар
2021 -05- 27
БҮРТГЭЛ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03
БҮРТГЭЛ-02

**Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодексийн 5.2.4-т заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа богоод тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв. Түүнчлэн ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүн нь Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БЕСБ" ХК
InvesCore
6000656 ☎1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSK
2021-12-03
БҮРТГЭВ-02

3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-ноос батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх

Инвескор ББСБ ХК-ийн дүрэм. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 тоот тогтоолоор батлагдсан "Инвескор ББСБ" ХК-ийн Дүрэм (цаашид "**Дүрэм**" гэх) нь (Хавсралт 1.4) хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Дүрэм нь нийт 15 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, Компанийн эрх хэмжээ, Компанийн хувь нийлүүлсэн болон хувьцаа, Компани үнэт цаас гаргах, худалдах, эргүүлэн авах, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, Компанийн санхүүгийн үйл ажиллагааны бүртгэл, тайлан нягтлан ашиг хуваарилан олгох, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, өр төлбөрийг барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагчийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

Компанийн засаглалын журмууд

Хөдөлмөрийн дотоод журам. Компанийн тухай хуулийн 83.1, Компанийн дүрмийн 11.1-д заасан бүрэн эрхийн дагуу Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 сарын 30 өдрийн В/152 тоот тушаалын Хавсралт 1-ээр батлагдсан "Инвескор ББСБ" ХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам (Хавсралт 3.1)-ыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тайлбар, хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, ажил олгогчийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, ажилд авах хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлын цаг, амралтын хугацаа, чөлөө олгох, цалин хөлс, олговор, тэтгэмж дэмжлэг, ажлын гүйцэтгэл, ур чадварын үнэлгээ хийх, сургалт хогжил, албан тушаал оорчлох, албан томилолтоор ажиллах, ажил хавсран, хослон, орлон гүйцэтгэх, хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага, ажил хүлээлцэх, ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох, цуцлах, бусад гэсэн 17 бүлэг болон ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдөл, орон тооны цомхотголын улмаас хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай мэдэгдэл, ажилтан эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй нь тогтоогдсоны улмаас хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай мэдэгдэл, ажил сайжруулах төлөвлөгөө, ажил хүлээлцэх акт, тойрох хуудас гэсэн 6 маягтаас бүрдсэн байна.

Үнэт цаас гаргагчийн Хөдөлмөрийн дотоод журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5.1, 130.1-т заасан шаардлага болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

Зээлийн үйл ажиллагааны журам. Иргэн хуулийн этгээдийн зээлийн хүсэлтийг хүлээн авч, холбогдох материалыг бүрдүүлэх, судалгаа шинжилгээ хийх, зээл олгох тухай шийдвэр гаргах, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, зээлийг бүцаан төлүүлэхтэй холбоотой ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулах зорилгоор "Инвескор ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааны журам" (Хавсралт 3.2)-ийг Гүйцэтгэх захирлын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн В/38 тоот тушаалын хавсралтаар батлажээ. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, зээлийн үйл ажиллагаанд мөрдөх зарчим, зээлийн нөхцөл, ёс зүй, үүрэг хариуцлага, зээлийн үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэг, процесс, зээлийн хяналт, зээлийн эрсдэлд оорчлолт оруулах, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэх, хяналт, хариуцлага гэсэн зохицуулалт бүхий нийт 7 бүлгээс бүрдсэн байна. Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ХХК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
1112286063
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он 2021 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhan
БҮРТГЭВ-02

Зээлийн хорооны үйл ажиллагааны журам. Зээлийн хорооны эрхлэх үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийг сонгох, хорооны хуралдаан, гишүүдийн үүрэг хариуцлага зэрэг асуудлыг зохицуулах зорилгоор Зээлийн хорооны үйл ажиллагааны журам (Хавсралт 3.3)-ыг "Инвескор ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн В/186 тоот тушаалын хавсралт 9-өөр батлаж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, зээлийн хорооны үйл ажиллагаа, зээлийн хорооны эрх хэмжээ, зээлийн хорооны бүтэц, бүрэлдэхүүн, зээлийн хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх, зээлийн хорооны дарга, зээлийн хорооны хуралдаан, хүлээх хариуцлага, хүчин төгөлдөр болохтой холбоотой харилцааг зохицуулсан байна.

Зээлийн бодлого. Толоолон удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/13-Т тоот тогтоолын хавсралт 2-оор зээлийн үйл ажиллагаа, түүнд баримтлах зарчим, зээлийн бүтээгдэхүүн, харилцагчийн мэдээллийн нууцлал, сонирхлын зөрчил, зээлийн хамрах хүрээ, зээлийн нөхцөл, зээлийн шийдвэр гаргалт, зээлийн хэрэг бүртгэл, зээлийн мэдээлэл, тайлагналтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн бодлогыг (Хавсралт 3.4) батлан мөрдүүлж байна. Энэхүү бодлого нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчимд нийцэж байна.

Эрсдэлийн удирдлагын бодлого. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/13-Т тоот тогтоолын хавсралт 1-ээр Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, бизнесийн үндсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг ханган ажиллах үр дүнтэй, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн бодлогыг (Хавсралт 3.5) батлан мөрдүүлж байна. Энэхүү бодлого нь эрсдэлийн төрөл, хамгаалалтын бүс, эрсдэлийн засаглал, эрсдэлийн хүлээн зовшоорох хэм хэмжээ, эрсдэлийн шинжилгээ ба тайлагналт, нэр хүндийн болон стратегийн эрсдэлийг нь СЭХ-оос баталсан зохистой харьцааны шалгуурт нийцэж байна.

Богино хугацааны санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах журам. Гүйцэтгэх захирлын 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн В/186 тоот тушаалын Хавсралт 3-аар ашиг олох, санхүүгийн эрсдэлийг бууруулах, хорогийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ББСБ-ын мөнгөн урсгалыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор богино хугацааны санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, түүнийг борлуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.6) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд нийцэж байна.

Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн В/255 тоот тушаалын Хавсралт 2-оор Компанийн үзүүлэх хоронго оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.7) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээрх зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний төрөл, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний зохион байгуулалт, мэдээллийн сан, ёс зүй ба сонирхлын зөрчил, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хяналт хариуцлагын үйл ажиллагааг зохицуулсан. Энэхүү журам нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нийцэж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 д.1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БАРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhanbank

Факторингийн үйл ажиллагааны журам. Факторингийн үйл ажиллагааг удирдах, үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавих, факторингийн үйл ажиллагааны ерөнхий зарчмуудыг тодорхойлохтой холбоотой "Инвескор ББСБ" ХК-ийн Факторингийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.8)-ыг Инвескор ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн В/255 дугаар тушаалын хавсралт №1-ээр батлаж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү журам нь факторингийн үйл ажиллагаанд мордох зарчим, ажилтны ёс зүй, хүлээх хариуцлага, факторингийн үйлчилгээний хүсэлт судлах ажиллагаа, факторингийн үйлчилгээ үзүүлэх авлагын шаардлага, авлагын үнэлгээ, факторингийн үйлчилгээний хүсэлт судлах үйл ажиллагаа, факторингийн үйлчилгээ үзүүлэх авлагын шаардлага, авлагын үнэлгээ, факторингийн үйлчилгээний хүсэлт шийдвэрлэх, факторингийн үйлчилгээ үзүүлэх, гэрээ байгуулах, харилцагч болон үүрэг гүйцэтгэгчийн бүрдүүлэх баримт бичиг, факторингийн үйл ажиллагааг ББСБ-ын нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Итгэлцлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 05 дугаар сарын 26-ны одрийн В/105 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Инвескор ББСБ" ХК-ийн Итгэлцлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний журмыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, хамрах хүрээ, нийтлэг нэр томьёо, баримтлах зарчим, хамгаалалтын бүсүүдийн чиг үүрэг, итгэлцлийн бүтээгдэхүүн, итгэлцлийн үйлчилгээний процесс, итгэлцэл барьцаалсан зээл, хориглох зүйл зэргийг зохицуулсан 9 бүлгээс бүрдсэн журам (Хавсралт 3.9)-ыг батлан мөрдүүлж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журамд заасан зарчимд нийцэж байна.

Ажиллагсдын цалин хангамж, урамшуулал олгох тухай журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 сарын 30-ны өдрийн В/152 тоот тушаалын Хавсралт 4-ээр "Инвескор ББСБ" ХК-ийн ажилтны цалин хөлс, хөнгөлөлт, хангамж, шагнал урамшууллыг тооцож олгох, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийтлэг үндэслэл, нэр томьёоны тайлбар, цалин, хөлс тооцож олгох, хөнгөлөлт хангамжийг тооцож олгох, шагнал урамшууллыг тооцон олгох, бусад гэсэн 6 бүлэг, "Инвескор ББСБ" ХК-ийн ажилтнуудын хөнгөлөлтийн багц, "Инвескор ББСБ" ХК-ийн ажилтнуудын буцалтгүй тусламжийн багц гэсэн 2 хавсралтаас бүрдсэн журам (Хавсралт 3.10)-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нийцэж байна.

Түлхүүр ажилтны хуримтлалын сангийн тухай журам. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хурлын Л/26 тоот тогтоолын Хавсралт 1-ээр "Инвескор ББСБ" ХК-тай хөдөлмөрийн болон контракт гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа түлхүүр ажилтныг урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдгээрийн нийгмийн хангамжийн асуудлыг дэмжих зорилгоор ажиллагсдын хуримтлалын сан бий болгох, түүнтэй холбоотойгоор Инвескор болон ажиллагсдын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 11 бүлэг, 3 хавсралтаас бүрдсэн журам (Хавсралт 3.11)-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь хуримтлалын сан үүсгэх, түүнийг тооцох нөхцөл журам, Компанийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, хуримтлалын сангийн мөнгийг олгох журам, хуримтлалын сангаас гарах нөхцөлүүд зэргийг зохицуулсан нь хууль тогтоомжид нийцэж байна.

Ногдол ашгийн бодлого. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодексд нийцүүлэх тодорхойлох зорилгоор Ногдол ашгийн бодлого (Хавсралт 3.12)-ыг

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ...1119277129
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
...1115286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhan
БҮРТГЭВ-02

"Инвескор ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/05-Т тоот тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, погдол ашиг хуваарилах нөхцөл, погдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Дотоод хяналтын журам. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/05-Т тоот тогтоолын хавсралт 4-өөр Компанийн үйл ажиллагаа, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах, зөрчил дахин давтагдахаас сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн дотоод хяналтын журмыг (Хавсралт 3.13) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Компанийн дотоод хяналт хариуцсан алба/ажилтны эрх, үүрэг, дотоод хяналтын үйл ажиллагаа, дотоод хяналтаар илэрсэн зөрчилд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, ББСБ-ын дотоод журамд заасан хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан нь холбогдох хууль тогтоомж, 2011 оны Засгийн газрын 311 тоот тогтоолд нийцсэн байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам. ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох журам, дахин нэр дэвших болзол, хараат бус гишүүний шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн хурлын зарыг хүргэх, хуралд оролцох, санал өгөх, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах журам, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага зэрэг ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 11 бүлгээс бүрдсэн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.14)-ыг 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хурлын А/28-Т тоот тогтоолын хавсралт 1-ээр батлсан байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4.4-д "ТУЗ-ийн хурлаар асуудал шийдвэрлэхэд ТУЗ-ийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно" гэж заасан нь Компанийн тухай хуулийн 80.6, Компанийн дүрмийн 9.9-д "...дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно..." гэж зохицуулсантай нийцээгүй байна. Гэсэн хэдий ч Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн тэмдэглэлүүдтэй танилцахад дийлэнх олонхиос багагүй саналаар шийдвэрээ гаргаж байсан нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасанд нийцэж байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4.4 дэх заалтыг хууль, дүрэмд нийцүүлэхийг Үнэт цаас гаргагчид бичгээр зөвлөсөн болно. Уг заалтаас бусдаар энэхүү журам нь Компанийн тухай хуульд нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журам. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналт, үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журам (Хавсралт 3.15)-ыг Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 08 дугаар сарын 05-ны одрийн А/28 тоот тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, хорооны гишүүнчлэл, хорооны нарийн бичгийн дарга, хорооны хурал, хорооны бүрэн эрх, хорооны үүрэг, хариуцлага, ажлын тайлантай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексд нийцэж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 д.1119277128
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

000195

СЗХ
он сар өдөр
2023 05 30
Б/4715/ЗВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын хорооны журам. Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулах, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын хорооны журам (Хавсралт 3.16)-ыг Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/28 тоот тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, хорооны гишүүнчлэл, хорооны нарийн бичгийн дарга, хорооны хурал, хорооны бүрэн эрх, хорооны үүрэг, хариуцлага, ажлын тайлантай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексд нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчдэд тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг сонгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам (Хавсралт 3.17)-ыг Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/28 тоот тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, хорооны гишүүнчлэл, хорооны нарийн бичгийн дарга, хорооны хурал, хорооны бүрэн эрх, хорооны чиг үүрэг, ажлын тайлантай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексд нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны журам. Компанийн эрсдэлийн удирдлагыг тодорхойлох, эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн хяналтыг тогтолцоо, үйл ажиллагаанд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны журам (Хавсралт 3.18)-ыг Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/28 тоот тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, хорооны гишүүнчлэл, хорооны нарийн бичгийн дарга, хорооны хурал, хорооны бүрэн эрх, хорооны чиг үүрэг ажлын тайлантай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексд нийцэж байна.

Тусгай активын үйл ажиллагааны журам. Гүйцэтгэх захирлын 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн В/186 тоот тушаалын Хавсралт 8-аар Байгууллагын балансад бүртгэлтэй эрсдэлд орж болзошгүй болон эрсдэлд орсон зээлийг Тусгай активын албанд шилжүүлэх, Зээлийн эрсдэлийн сангаас хаах, тусгай активын албанд шилжсэн болон Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийг төлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.19) батлан мөрдүүлж байна.

Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.4 дэх заалт, Монгол Улсын нутаг дэвсгэрт гуравдагч этгээдэд аливаа толборийн баталгаа гаргахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Толборийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам (Хавсралт 3.20)-ыг "Инвескор ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн В/186 тоот тушаалын хавсралт 6-аар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, толборийн баталгааны үндсэн нөхцөлүүд, төлбөрийн баталгаа гаргуулахыг хүссэн харилцагчийн бүрдүүлэх бичиг баримт, толборийн баталгаа гаргах үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн

"ИНВЕСКОР КАПИТАЛ" ХК
Investcore CAPITAL
6317839 ...1119277129
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
Investcore
...1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 .09. 27 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-09-03
БҮРТГЭВ-02

ББСБ-ын үүрэг дуусгавар болох, төлборийн баталгаа дуудагдсан тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгон арилжаалах журам. Толоолон удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/10-Т тоот тогтоолын хавсралтаар нэмж гаргаж буй хувьцааг хөрөнгө оруулагчдаас захиалга авах замаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод шуурхай явуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн Компанийн нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгон арилжаалах журам (Хавсралт 3.21) батлан мордүүлж байна. Энэхүү журам нь хувьцаа арилжаалахтай холбоотой үйл ажиллагаа, нийтэд мэдээлэл хүргэх сурталчлах, хувьцааны анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл, үнэ тогтоох, хуваарилалт, арилжаа дуусгавар болохтой холбоотой харилцааг зохицуулсан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын хөрөнгийн биржээс батлсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 2 дугаар бүлэгт тус тус пийцсэн байна.

Харилцагчийн үйлчилгээний нэгдсэн стандарт. Гүйцэтгэх захирлын 2020 оны 08 дугаар сарын 10-ний өдрийн В/179 тоот тушаалын Хавсралтаар батлсан "Инвескор ББСБ" ХК-ийн Харилцагчийн үйлчилгээний нэгдсэн стандарт (Хавсралт 3.22)-ыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, харилцагчийн үйлчилгээнд баримтлах зарчим, харилцагчийн үйлчилгээний нэгдсэн стандартын бүрдэл хэсэг, харилцааны стандарт, утсан харилцааны стандарт, дүрэмт хувцас харагдах байдлын стандарт, ажлын байранд биеэ авч явах стандарт, ажлын ширээний стандарт, хяналт ба үнэлгээ гэсэн 9 бүлэг болон KPI гүйцэтгэлийн үнэлгээг тооцох аргачлал, харилцааны хяналт хийх аргачлал, харилцааны үнэлгээний хуудас, утсан харилцааны нууц худалдан авалтын хяналт хийх аргачлал, утсан харилцааны хяналтын үнэлгээний хуудас, салбар дээрх цууц худалдан авалтын хяналтын үнэлгээний хуудас, удирдлагын үнэлгээний хуудас гэсэн 6 хавсралтаас бүрдсэн байна.

Салбарын удирдлагын газрын үйл ажиллагааны журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн В/06 тоот тушаалын Хавсралтаар батлсан "Инвескор ББСБ" ХК-ийн Салбарын удирдлагын газрын үйл ажиллагааны журам (Хавсралт 3.23)-ыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, салбарын удирдлагын газар, түүний бүтэц зохион байгуулалт, салбарын удирдлагын газрын зорилго, үндсэн чиг үүрэг, салбарын төсөв, төлөвлөгөө боловсруулах, хуваарилах, тайлан мэдээ боловсруулах, хянах, салбарыг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, салбарын үйл ажиллагаанд тавих хяналт, түүнийг сайжруулах, талаар арга хэмжээ авах, салбарын бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, боловсон хүчний бодлогод оролцох оролцоо, бүтээгдэхүүний удирдлага, харилцагчийн үйлчилгээ, хяналт хариуцлага гэсэн 10 бүлэг болон салбарын төсөв, төлөвлөгөөг хуваарилах, гүйцэтгэлийг хянах үйл явц, салбар шинээр байгуулахад хийгдэх зах зээлийн судалгаа, үр ашгийн тооцоолол, салбарын ерөнхий бүтэц гэсэн 3 хавсралтаас бүрдсэн байна.

Ажилтны ёс зүйн дүрэм. Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн В/07 тоот тушаалын Хавсралтаар батлсан "Инвескор ББСБ" ХК-ийн нийт ажилтны өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах зарчим, ёс зүйн дүрэм, хэм хэмжээг тодорхойлон хэвшүүлэх, дагаж мөрдөх, болон ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах журам (Хавсралт 3.24)-ыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, компанийн эрхэм зорилго,

InvesCore CAPITAL
6317839 ...1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
6060854 ...1119280063
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар
2021.05.27 В
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

MDS KhanLex

үнэт зүйлс, алсын хараа, баримтлах зарчим, ажилтны бисэ авч явах соёл, компанийн өмч хөрөнгө, компанийн мэдээлэл технологийн нэгдсэн систем, ёс зүйн хороо гэсэн нийт 7 бүлгээс бүрдсэн байна.

Салбарын үйл ажиллагааг зохицуулах журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн В/20 тоот тушаалын Хавсралтаар батлагдсан "Инвескор ББСБ" ХК-ийн Салбарын үйл ажиллагааг зохицуулах журам (Хавсралт 3.25)-ын загварыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, маркетинг сурталчилгаа, салбарын аюулгүй байдал, хяналт хариуцлага гэсэн 6 бүлэг болон салбарын байрны хаалт хийх үеийн шаардах хуудас гэсэн хавсралтаас бүрдсэн байна.

Компани нь Орхон аймагт 1 (Хавсралт 3.26), Сүхбаатар дүүрэгт 4 (Хавсралт 3.27, Хавсралт 3.28, Хавсралт 3.29, Хавсралт 3.30), Сонгинохайрхан дүүрэгт 1 (Хавсралт 3.31), Баянзүрх дүүрэгт 4 (Хавсралт 3.32, Хавсралт 3.33, Хавсралт 3.34, Хавсралт 3.35), Хан-Уул дүүрэгт 1 (Хавсралт 3.36), Баянгол дүүрэгт 1 (Хавсралт 3.37), Чингэлтэй дүүрэгт 1 (Хавсралт 3.38), нийт 13 салбарын үйл ажиллагааг тус журмаар зохицуулж байна.

Эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлах, танилцах, үнэлэх үйл ажиллагааны журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн В/39 тоот тушаалын Хавсралтаар батлагдсан "Инвескор ББСБ" ХК-ийн тодорхой харилцааг байнга, тогтвортой зохицуулах, ББСБ-ын хэмжээнд мөрдөгдөх тушаал, журам болон заавар зэрэг хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлах, танилцах, үнэлэх үйл ажиллагааг зохицуулах журам (Хавсралт 3.39)-ыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус журам нь зорилго, эрх зүйн актын тослийн торол, тавигдах шаардлага, эрх зүйн актын төсөл боловсруулах үйл ажиллагаа, эрх зүйн актыг батлах үйл ажиллагаа, эрх зүйн актыг танилцах үйл ажиллагаа, эрх зүйн актыг үнэлэх үйл ажиллагаа бүхий 6 зүйл, болон эрх зүйн актын төсөл боловсруулах, батлах, танилцах, үнэлэх үйл ажиллагааны зураглал, эрх зүйн актад тавигдах шаардлага, бодлого журмын хэрэгжилтийг үнэлэх хуудас, процессын зураглал гэсэн 4 хавсралтаас бүрдсэн байна.

Зээлийн мэдээллийн сангийн журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн В/65 тоот тушаалын Хавсралтаар зээлийн мэдээллийн санг ашиглах, нийлүүлэхтэй холбогдуулан үйл ажиллагаанд баримтлах зарчим, чиг үүрэг, хариуцлага болон мэдээллийн үнэн, бодит байдлыг хангах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.40) батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, зээлийн мэдээллийн сангийн шимтгэл, хяналт хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан ба Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйл, 28.2-т заасантай нийцэж байна.

Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн В/66 тоот тушаалын хавсралт 1-ээр Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ тогтоож тэдгээрийг ханган ажиллах үр дүнтэй, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.41) батлан хэрэгжүүлж байна. Энэхүү журам нь эрсдэлийн бодлого, журмын засаглал, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, хамгаалах нөхцөл, эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн тайлагналт ба хяналт, бодлого, журмын үнэлгээтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн заршимд нийцэж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ...1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ...1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhard.mn
2021-02-03
БҮБ-ГДВ-02

Зээлийн эрсдэлийн ерөнхий журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн В/66 тоот тушаалын хавсралт 2-оор зээлийн эрсдэлийг удирдахад баримтлах зарчим, хамгаалалтын бүс, тэдгээрийн үүрэг, хариуцлага, зээлийн багцын удирдлага, зээл хүсэгч болон барьцаа хөрөнгийн стандартын шаардлага, зээл шийдвэрлэх эрхийн хэмжээ, зээлийн эрсдэлийг үнэлэх аргачлал болон зээлийн хяналт хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан нийт 14 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.42) батлан хэрэгжүүлж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах ерөнхий журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн В/66 тоот тушаалын хавсралт 3-аар Компанийн хэмжээнд хамгаалалтын гурван бүсийн чиг үүрэгт тулгуурлан үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд удирдах тогтоол бий болгох, урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоонд суурилсан үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.43) батлан хэрэгжүүлж байна. Энэхүү журам нь Компанийн эрсдэлийг ангилж, үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн тохиолдлыг бүртгэх, хянах, үнэлэх, тайлагнах, ажилчдын дагаж мөрдөх үйл ажиллагааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчимд нийцэж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах үйл ажиллагааны журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн В/66 тоот тушаалын хавсралт 4-өөр эрсдэлийг удирдах ерөнхий журмыг хэрэгжүүлэх зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.44) батлан хэрэгжүүлж байна. Энэхүү журам нь эрсдэлийн үнэлгээ хийх, хяналтыг хэрэгжүүлэх болон тэдгээрийн хэрэгжилтийг хянах, тайлагнах, эрсдэлийн тохиолдлыг тайлагнах, процессуудын нэгдсэн бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулсан байна. Энэхүү журам Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчимд нийцэж байна.

Ажилтны зээлийн журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны одрийн В/81 тоот тушаалын Хавсралтаар ""Инвескор ББСБ" ХК-ийн Ажилтны зээлийн журам" (Хавсралт 3.45) нь батлагдсан байна. Тус журам нь Компани болон түүний охин компани, хамаарал бүхий компаниудын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн хэрэгцээг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, ажилтанд олгох зээлийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн нөхцөлийг тодорхойлох, зээлийн санал шийдвэрлэх эрх бүхий этгээдийг тодорхойлох болон зээлийн хүсэлт хүлээн авах, судлах, шийдвэр гаргах, эргэн төлөлтөд хяналт тавих, зээлийг бүцаан толүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 7 бүлэг, 4 хавсралт, 2 маягтаас бүрдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Зээлийн баримт бичгүүдийн эх хувийг архивд хадгалах журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн В/106 тоот тушаалын Хавсралтаар "Зээлийн баримт бичгүүдийн эх хувийг архивд хадгалах журам" (Хавсралт 3.46) нь батлагдсан байна. Тус журам нь Зээлийн хэрэг бүртгэлийн алба болон салбаруудад зээлийн эх баримт бичиг, бүртгэх, хадгалах, түр хугацаагаар олгох, буцаан авах, архив хариуцсан ажилтны эрх үүргийг тодорхойлох, дээрх үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор 7 бүлэг, 2 хавсралтаас бүрдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Мэдээлэл технологийн журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний одрийн В/66-Б тоот тушаалын Хавсралт 1-ээр батлагдсан "Мэдээлэл технологийн журам" (Хавсралт 3.47) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тайлбар, сүлжээний стандарт шаардлага, түүний хяналт, үндсэн болон нөөц төв, серверийн өрөөний стандарт, хяналт, бүртгэлийн системийн үйл ажиллагаа, өгөгдлийн сангийн удирдлага, сервер,

"ИНВЕСКОР КАПИТАЛ ХХК"
InvesCore CAPITAL
6317839 ᵾ1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6000854 ᵾ1115286083
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhanLex
2021-02-03
БҮРТГЭВ-02

систем, өгөгдлийн санг нөөцлөх, программ хангамж хөгжүүлэлтийн удирдлага, тусгайлсан хяналт, удирдлага, хариуцлага, бусад гэсэн 11 бүлгээс бүрдсэн байна.

Мэдээллийн системийн тасалдалгүй байдлыг хангах журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн В/66-Б тоот тушаалын Хавсралт 2-оор "Мэдээллийн системийн тасалдалгүй байдлыг хангах журам" (Хавсралт 3.48) нь батлагдсан байна. Тус журам нь Компани мэдээлэл технологийн дэд бүтэц, систем, серверүүд, программ хангамжийн тасралтгүй найдвартай аюулгүй ажиллагааг хангах, тасалдал үүссэн үед авах арга хэмжээ, аливаа болзошгүй тасалдлаас сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 6 бүлэг, 8 хавсралтаас бүрдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн В/66-Б тоот тушаалын Хавсралт 3-аар "Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах журам" (Хавсралт 3.49) нь батлагдсан байна. Тус журам нь Компанид мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, мэдээ, мэдээлэл, сүлжээ, системийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, гаднаас болон дотоодоос учирч болох халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэх, хор хохирол, эрсдэл учирсан тохиолдолд нэн даруй шаардлагатай арга хэмжээг авахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 10 бүлгээс бүрдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн В/297 тоот тушаалын Хавсралтаар ""Инвескор ББСБ" ХК-ийн Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам" (Хавсралт 3.50) нь батлагдсан байна. Тус журам нь Компанийн зээлийн үйл ажиллагаа болон зээлийн эрсдэлийн удирдлагад баримтлах бодлогод нийцүүлэн барьцаа хөрөнгийн үнэлгээний стандартыг тогтоох зорилгоор 6 бүлэг, 3 хавсралтаас бүрдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Албан томилолтын журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн В/152 тоот тушаалын Хавсралтаар баталсан "Инвескор ББСБ" ХК-ийн Албан томилолтын журам (Хавсралт 3.51) нь хүчин тоголдор мордогдож байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тайлбар, албан томилолт олгох, гүйцэтгэсэн ажлыг тайлагнах, дүгнэх, албан томилолтын зардлын төсөв, түүний биелэлтийн тооцоог хийх, албан томилолтын хугацааг сунгах, хариуцлага, бусад гэсэн 7 бүлэг болон албан томилолтын удирдамж, албан томилолтын зардлын төсөв, томилолтын зардлын гүйцэтгэлийн тайлан гэсэн 3 хавсралтаас бүрдсэн байна.

Цаг бүртгэл, амралт чөлөөний журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн В/152 тоот тушаалын Хавсралтаар баталсан "Инвескор ББСБ" ХК-ийн Цаг бүртгэл, амралт чөлөөний журам (Хавсралт 3.52) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тайлбар, цаг бүртгэлийн систем, аюулгүй ажиллагаа, ажил амралтын цаг, ажлын цаг бүртгүүлэх, ажлын цагийн хоцролт, ажил таслалт, чөлөө олголт, ээлжийн амралт, хариуцлага гэсэн 10 бүлэг болон сануулах хуудас гэсэн хавсралтаас бүрдсэн байна.

Онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө. Гүйцэтгэх захирлын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн В/205 тоот тушаалын Хавсралтаар баталсан "Инвескор ББСБ" ХК-ийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө (Хавсралт 3.53) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хөрөнгө завших, залилангийн эсрэг журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн В/206 тоот тушаалын Хавсралтаар баталсан "Инвескор ББСБ" ХК-ийн хөрөнгө

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

000200

СЗХ
2021-05-27
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

завших, залилангийн эсрэг журам (Хавсралт 3.54) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, хамрах хүрээ, хөрөнгө завших, залилангийн тодорхойлолт, үүрэг хариуцлага, хоронго завших, залиланг мэдээлэх, шалгах үйл ажиллагаа гэсэн 5 бүлгээс бүрдсэн байна.

Шүгэл үлээх журам. Гүйцэтгэх захирлын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн В/206 тоот тушаалын Хавсралтаар батлсан "Инвескор ББСБ" ХК-ийн шүгэл үлээх журам (Хавсралт 3.55) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус журам нь нийтлэг үндэслэл, баримтлах зарчим, шүгэл үлээх, зөрчил шалган шийдвэрлэх, шүгэл үлээгчийг хамгаалах гэсэн 5 бүлгээс бүрдсэн байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хотолбор. Гүйцэтгэх захирлын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн В/220 тоот тушаалын хавсралтаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлгээ хийх, харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох, санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээний тайлан гаргах, баримт, материалыг хадгалах, дотоод сургалт, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, тэдгээрийн хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 12 бүлгээс бүрдсэн хөтөлбөрийг (Хавсралт 3.56) батлан мөрдүүлж байна. Тус хөтөлбөрөөр зохицуулаагүй харилцааг холбогдох хууль, эрх бүхий байгууллагын журам, зааврыг баримтлан ажиллахаар тусгажээ. Энэхүү хөтөлбөр нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкнаас батлсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 208 (Хавсралт 3.57) тоот гүйцэтгэх захирлын тушаалаар "Комплаенсын мэргэжилтэн" албан тушаалыг хослон гүйцэтгүүлэхээр Ц.Алтаннавчийг томилсон ба тус ажилтан нь энэхүү Хотолборийн 2.1.3, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4.11-д заасны дагуу Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг болно.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого. "Эс Ай би Жэй Капитал" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/05 тоот тогтоолын хавсралт 1-ээр тус компанийн охин компани болох "Инвескор ББСБ" ХК-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагаанд баримтлах бодлого, зарчмыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн бодлогыг (Хавсралт 3.58) батлан мөрдүүлж байна. Энэхүү бодлого нь "Инвескор ББСБ" ХК-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөрийн салшгүй хэсэг ба нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкнаас батлсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааны журам, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой эгээдийг тодорхойлох журмын 3.1.2-т заасантай нийцэж байна.

Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос батлсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

000201

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
2021 05 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

Гүйцэтгэх захиралтай байгуулсан Контрактын гэрээ. Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нь 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/02 дугаартай Үүсгэн байгуулагчдын шийдвэр (Хавсралт 2.13)-ээр анх томилогдсон. Толоолон удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/40-Т дугаар тогтоол (Хавсралт 2.14)-ын дагуу ТУЗ-ын дарга Б.Лхболдтой ЕА19010201 дугаартай "Хөдөлмөрийн контракт"-г (Хавсралт 4.1)-г 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр шинэчлэн байгуулсан байна. Энэхүү гэрээг 4 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд цэр томьёо, ажлын байрны ерөнхий зохицуулалт, ажил олгогчийн эрх, үүрэг, захирлын эрх, үүрэг, цалин, урамшуулал, хангамж, гэрээг дүгнэх, үр дүнг тооцох, контрактын хугацаа, гэрээ дуусгавар болох, хариуцлага, оюуны өмч ба нууцлал, ажлаас гарсны дараа хүлээх үүрэг, бусад зэрэг харилцааг зохицуулсан нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэж байна.

Оффис түрээсийн гэрээ. Инвескор нь Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүл гудамж 10 1, Твин Тауэр барилгын 15 давхар барилгын 13 давхарын нийт 324.48 м.кв. бүхий оффисын зориулалттай талбайг сар бүр нийт 10,103,000 төгрөгийн түрээсийн төлбөртэйгөөр "Хурган Мөнх" ХХК-тай байгуулсан 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн гэрээгээр түрээслэн үйл ажиллагаа явуулж байна. Түрээсийн гэрээ (Хавсралт 4.2)-г 2.5 жилийн хугацаатайгаар байгуулсан ба тус гэрээ нь Иргэний хуульд нийцэж байна.

Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан CBS программ хангамжийн захиалгын гэрээ. 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ББСБ-д зориулсан CBS программ хангамжийг хогжүүлж, нийлүүлэх Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан CBS программ хангамжийн захиалгын гэрээ (Хавсралт 4.3)-г "Дижитал Воркс" ХХК (гүйцэтгэгч)-тай байгуулсан. Энэхүү гэрээгээр бараа бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, нийлүүлэх нөхцөл, гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, оюуны өмч, лицензийн эрх, талуудын эрх, үүрэг, эрх шилжүүлэх, эрсдэл шилжих, нууцлал, гэрээ хүчин төгөлдөр болох, дуусгавар болох, хариуцлага, давагдашгүй хүчин зүйлс, маргаан шийдвэрлэх харилцааг зохицуулсан нь Иргэний хуулийн 31-р бүлэг, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 7.1.1, 18.2, 23.4-д нийцсэн байна.

Хамтран ажиллах гэрээ. Компани нь "Сайн Интернэшнл" ХХК-тай Бэлтгэн нийлүүлэгч нь ББСБ-ийн зээлийн үйлчилгээгээр дамжуулан Гэрээнд заасан өөрийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчид худалдах, ББСБ нь худалдсан барааны үнийг төлүүлэх зорилгоор худалдан авагчид зээл олгохтой холбоотой үүссэн харилцааг зохицуулахаар 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 19040401 тоот "Хамтран ажиллах гэрээ" (Хавсралт 4.4)-г 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийг дуустал хугацаагаар байгуулжээ. Гэрээнд гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний талуудын нэр, хаяг, хамтын үйл ажиллагааны зорилго, бэлтгэн нийлүүлэгчийн эрх, үүрэг, банк бус санхүүгийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, гэрээ цуцлах үндэслэл, гэрээний хугацаа, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл заалтуудыг 8 хавсралтуудын хамт тусгасан байна ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хуульд нийцсэн байна.

19040401 тоот Хамтран ажиллах гэрээнд 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан 19040401-1 тоот Хамтран ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 4.5) гэрээгээр 8 хавсралтыг шинэчлэн баталжээ. Тус Хамтран ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ, хавсралтууд нь 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан 19040401 тоот Хамтран ажиллах гэрээний салшгүй хэсэг байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ХХК"
InvesCore CAPITAL
6317639 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ББСБ" ХК
InvesCore
1119288063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 .05. 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

Ажил гүйцэтгэх гэрээ. Компани нь "Эйч Пи Эс" ХХК-тай захиалагчаас Киоск машин нийлүүлэх, Киоск машины систем хөгжүүлэх, нэвтрүүлэх, киоскын нэвтрүүлэлтийн дараах засвар үйлчилгээг гүйцэтгэгчид даалгаж, гэрээнд заасны дагуу хөлсийг төлөх ба Гүйцэтгэгч ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанартай хийж гүйцэтгэх, гэрээт ажлын үр дүнг хүлээн авах, хүлээлгэ өгөхтэй холбогдсон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилгоор 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр №20011701 тоот Ажил гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.6)-г 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл 2 сар 28 хоногийн хугацаатай байгуулсан. Энэхүү гэрээгээр ерөнхий зүйл, гэрээний хугацаа, ажлын чанар, төлбөрийн нөхцөл, гүйцэтгэгчийн эрх, үүрэг, захиалагчийн эрх, үүрэг, хариуцлага, гэрээний нууцлал, мэдээллийн өмчлөх эрх, зардал хуваарилах, талууд харилцах, маргаан шийдвэрлэх, баталгаа, давагдашгүй хүчин зүйл, эрсдэл хуваарилах, гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт оорчлолт оруулах, бусад зүйл заалтуудыг ажлын даалгавар, шаардлага, ажил гүйцэтгэх хуваарь зэргийг тусгасан нь Иргэний хуульд нийцсэн байна.

№20011701 тоот тоот Ажил гүйцэтгэх гэрээнд 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр №20011701-2 тоот Ажил гүйцэтгэх нэмэлт гэрээ (Хавсралт 4.7)-гээр киоск машины нэмэлт хөгжүүлэлтийн хэвийн ажиллагаа, засвар үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэх харилцааг зохицуулсан байна.

№20011701 тоот Ажил гүйцэтгэх гэрээнд 2020 оны 03 дугаар сарын 23-ний өдөр №20011701-1 тоот Ажил гүйцэтгэх нэмэлт гэрээ (Хавсралт 4.8)-гээр Компанид нийт 16 Киоск машин буюу hardware нийлүүлэх, түүний нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээг "Эйч Пи Эс" ХХК-д даалгаж, гэрээнд заасан хөлсийг төлөх, ажлын үр дүнг хүлээн авах, хүлээлгэн өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Дээр дурдсан 2 нэмэлт гэрээ нь талуудын хооронд байгуулсан №20011701 тоот гэрээний салшгүй нэг хэсэг байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загварууд:

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний загвар. Итгэл хүлээгч нь Итгэл хүлээлгэгчийн хүсэлтээр мөнгөн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, ашиг/үр шим олж өгөх зорилгоор Итгэл хүлээлгэгчээс итгэл хүлээгчид шилжүүлсэн хөрөнгийг хадгалах, хянах, ашиглах, захиран зарцуулахтай холбоотойгоор талуудын эрх, үүргийг тодорхойлох, холбогдох харилцааг зохицуулах зорилгоор Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.9) болон Тусгай нөхцөлтэй хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.10)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна. Энэхүү гэрээний загварыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам болон Иргэний хуулийн 406-р зүйлд заасны дагуу боловсруулсан байна.

Итгэлцэл барьцаалсан зээлийн гэрээний загвар. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр байршуулсан мөнгөн хөрөнгийг барьцаалан зээл олгохтой холбоотойгоор талуудын эрх, үүргийг тодорхойлох, холбогдох харилцааг зохицуулах зорилгоор Итгэлцэл барьцаалсан зээлийн гэрээ (Хавсралт 4.11)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна.

Хөдөлмөрийн гэрээ. Хөдөлмөрийн гэрээний загвар (Хавсралт 4.12) нь нийтлэг үндэслэл, ажлын байрны ерөнхий зохицуулалт, гэрээний хугацаа, цалин, урамшуулал, ажил, амралтын цаг, ажилтны эрх, үүрэг, ажил олгогчийн эрх, үүрэг, гэрээг дуусгавар болгох, цуцлах, хариуцлага, маргаан шийдвэрлэх, бусад гэсэн нийт 11 зүйлээс бүрдсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн 21.1 хэсэгт заасан "ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан

"ИНВЕСКОР КАПИТАЛ ЧИЙ ЭМ"
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060654 ☎1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

ажил, үүрэг, үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл" зэрэг гол нөхцөлийг бүрэн тусгасан Хөдөлмөрийн тухай хуулийн 21-д нийцсэн байна.

Хөдөлмөрийн гэрээний 3.6-д заасан "Ажил олгогч тухайн үеийн ажлын нөхцөл байдал, шаардлага, Компанийн ирээдүйн бодлогод тулгуурлан, энэхүү гэрээнд тусгагдаагүй хуульд нийцсэн үүрэг даалгавар огох, түүний үр дүнг шаардах эрхтэй ба Ажилтан шууд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үүрэгтэй. Ийнхүү даалгасан үүрэг даалгаврын биелэлт нь энэхүү гэрээг дүгнэх үзүүлэлтэд мөн хамаарна" гэсэн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 31.1 дэх хэсэгт заасан "Ажил олгогч нь энэ хуульд зааснаас бусад тохиолдолд ажилтнаас хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил гүйцэтгэхийг шаардаж болохгүй" гэсэнтэй нийцэхгүй байна. Энэхүү зөрчлийг арилгуулахаар Үнэт цаас гаргагчид бичгээр зөвлөсөн болно.

Дээрхээс бусад зохицуулалт нь Хөдөлмөрийн тухай хуульд тогтоомжид нийцсэн байна.

Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар. Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар нь нийтлэг үндэслэл, үндсэн нөхцөл, ажил олгогчийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, ажилтны хүлээх хариуцлага, маргаан шийдвэрлэх, бусад гэсэн 7 зүйл болон эд хөрөнгө хүлээлгэн өгсөн акт гэсэн 1 хавсралт (Хавсралт 4.13)-аас бүрдсэн байна.

Нууц хадгалах гэрээний загвар. Нууц хадгалах гэрээний загвар (Хавсралт 4.14) нь нийтлэг үндэслэл, байгууллагын хүлээх эрх, үүрэг, ажилтны хүлээх эрх, үүрэг, хариуцлага, бусад зүйл бүхий нийт 5 зүйлээс бүрдсэн байна. Гэрээ нь Иргэний хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжид нийцсэн байна.

Зээлийн гэрээний загвар. Компанийн харилцагчидтай байгуулдаг зээлийн гэрээ (Хавсралт 4.15)-ээр Зээлдэгчид зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, Зээлдэгчийн зүгээс түүний зарцуулалтад хяналт тавих, зээлийг эргэн төлөх болон тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулж байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42-р зүйлд "42.1.Барьцаалагч нь энэ хуулийн 41.1-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг шаардах тухайгаа барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ.

42.2. Барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгч нь мэдэгдэлд заасан хугацаанд хариу өгөөгүй бол барьцаалагч нь энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцаалуулагч болон тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

42.3. Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдэлд 30 хоногийн дотор барьцаалуулагч хариу өгөөгүй буюу үүргээ биелүүлээгүй бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах ажиллагааг эхлүүлнэ." гэж тус тус зааснаас харахад барьцаалагч нь үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулахдаа зайлшгүй барьцаалуулагчид мэдэгдсэний үндсэн дээр хэрэгжүүлэхээр заасан байна. Зээлийн гэрээний загварын 4.1.4, 6.2.7, 7.1.6, 7.1.7, 8.1 дэх заалтуудад үл маргах журмаар барьцааны зүйлийг шилжүүлэн авах, борлуулах талаар заасан нь барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгө байх тохиолдолд дээр дурдсан Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн заалтад нийцээгүй байна. Загвар гэрээний дурдсан заалтууд нь зөвхөн хөдлөх эд хөрөнгийн барьцааны хувьд хамааралтайг тодруулж, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухайд уг загварыг хуульд нийцүүлэн сайжруулах, үүнтэй адилаар зээлийн эрх нээх гэрээний загвар, холбогдох барьцааны гэрээний загваруудыг мөн сайжруулахыг Үнэт цаас гаргагчид бичгээр зөвлөв.

Зээлийн эрх нээх гэрээний загвар. Зээлдүүлэгч, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР БРОКЕР" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
2021.05.27
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

Зээлдүүлэгч болон зээлдэгчийн хооронд зээлийн эрх нээх, зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, зээлийн зарцуулалтад Зээлдүүлэгчийн зүгээс хяналт тавих, зээлийг буцаан төлөх болон уг зээлтэй холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилгоор Зээлийн эрх нээх гэрээ (Хавсралт 4.16)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулдаг байна.

Зээлийн барьцааны гэрээний загвар. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг Барьцаалагч нь Барьцааны Зүйлээр тэргүүн ээлжинд хангуулах, Барьцаалуулагч нь Зээлийн Гэрээний үүргийг биелүүлэхийг баталгаа болгон Барьцааны Зүйлийг барьцаалуулах, Барьцааны Зүйлийн үнэлгээ, чанарыг тодорхойлох, Барьцааны Зүйлийг ашиглах, хамгаалах болон Зээлийн Гэрээний үүргийг Барьцааны Зүйлээр хангуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Зээлийн барьцааны гэрээ (Хавсралт 4.17)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна.

Эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх (Фидуци) гэрээний загвар. Гэрээнд заасан ходлох эд хөрөнгүүдийг Үүрэг Гүйцэтгүүлэгчийн эзэмшил, өмчлөлд шилжүүлэх, Үүрэг Гүйцэтгэгч нь Зээлийн Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдолд уг эд хөрөнгийг Үүрэг Гүйцэтгүүлэгчид буцаан шилжүүлэх үүрэг хүлээх, Үүрэг Гүйцэтгэгч нь Зээлийн Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үүрэг Гүйцэтгүүлэгч нь өмчлөлдөө шилжүүлэн авсан эд хөрөнгийг бодитоор Үүрэг Гүйцэтгэгчээс гаргуулан авахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Фидуцийн гэрээ (Хавсралт 4.18)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна.

Батлан даалтын гэрээний загвар: Зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг Зээлийн Гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг баталж, Зээлдэгч Зээлийн Гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Батлан даагч нь Зээлдэгчийн нэрийн өмнөөс ББСБ-ийн өмнө түүний Зээлийн Гэрээний үүргийг өөрийн эдийн болон эдийн бус эд хөрөнгөөр гүйцэтгэх болохыг баталж байгаатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Батлан даалтын гэрээ (Хавсралт 4.19)-ний загвараар үйлчлүүлэгчидтэй гэрээ байгуулж байна.

Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ. Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд нээлттэй бонд гаргах зориулалтаар "Инвескор ББСБ" ХК-ийн бизнесийн үнэлгээг тогтоохтой холбоотой харилцааг Инвескор болон "Гэрэгэ Эстимэйт" ХХК-тай 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.20)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд хөрөнгийн үнэлгээний зориулалт, хөрөнгийн үнэлгээний зүйл, түүний шинж, талуудын эрх үүрэг, хорогийн үнэлгээний холбоо, хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журмыг тусгажээ. Талуудын хооронд байгуулсан гэрээнд үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан тухай мэдээлэл тусгаагүй боловч бидэнд "Монре даатгал" ХХК болон "Гэрэгэ эстимэйт" ХХК нарын хооронд 2020 оны 10 дугаар сарын 03-ны өдөр хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэхдээ гаргасан мэргэжлийн бруутай үйлдлээс шалтгаалсан хариуцлагын талаарх Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээ (Хавсралт 4.21) байгуулсан нь 2021 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байх тул Хорогийн үнэлгээний тухай хуулийн 6-д заасан шаардлагад нийцсэн гэж үзэв.

Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ. 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/31-Т тоот ТУЗ-ийн хурлын "Үнэт цаас нээлттэй гаргах тухай" тогтоолыш үндсэн дээр сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмын дагуу Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах ажлыг зохион байгуулах, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3-д Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг тапилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гарган Андеррайтер-зөвлөх үйлчилгээг үзүүлэх, Компани нь үйлчилгээний төлбөрийг төлөх болон бусад хариуцлагыг хүлээхтэй

ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore CAPITAL
6317839 ... 1119277129
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060054 ... 1119286263
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021.05.27 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

холбоотой харилцааг зохицуулсан UWSA_201204/1 дугаартай "Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.22)-г 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр олгосон тусгай зөвшөөрлийн №3/113 дугаар гэрчилгээ, (Хавсралт 4.23) /http://www.frc.mn/o/19665/, 6317839 регистрийн дугаартай "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан нь Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

Ажил гүйцэтгэх гэрээ /аудит/. "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй гаргахаар төлөвлөж буй 20 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнтэй Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах ажиллагаанд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх (2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон)-ийг хяпахтай холбогдсон харилцааг "БДО аудит" ХХК-тай байгуулсан 2 тоот "Ажил гүйцэтгэх гэрээ" (Хавсралт 4.24)-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна.

Андеррайтер-зуучлалын үйлчилгээний гэрээ. (Хавсралт 4.25). "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь Компанийн бондыг Төв клирингийн биржийн бус зах зээлд "Өрийн бичгийн хөтөлбөр"-ийн дагуу, хаалттай хүрээнд хэсэгчлэн гаргах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3-д Хоронго оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гарган Андеррайтерийн үйлчилгээг Компанид үзүүлэх, Компани нь үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан"Андеррайтер-зуучлалын үйлчилгээний гэрээ"-г тусгай зөвшөөрлийн 3/61 дугаар гэрчилгээ /http://www.frc.mn/o/6709/, 5251494 регистрийн дугаартай "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-тай байгуулсан нь Иргэний хууль, Үнэт цаасны тухай хууль болон бусад холбогдох дүрэм журамд нийцсэн байна.

Төлбөрийн тасалдлын даатгалын гэрээ (Хавсралт 4.26). "Монгол даатгал" ХК, "Ти ди би Капитал ҮЦК" ХХК-тай Даатгуулагч нь хөрөнгө оруулагчийг төлөөлөн Даатгалын зүйлийг харилцан тохиролцсон үнэлгээгээр даатгуулах, Бонд гаргагч нь Даатгалын зүйлтэй холбоотой бүхий л үүргийг хэрэгжүүлж, даатгалын хураамж төлөх, Даатгагч нь даатгалын тохиолдолд үүсэхэд нөхөн төлбөрийн эрхтэй этгээдэд нөхөн төлбөрийг үл маргах журмаар олгох харилцааг зохицуулсан даатгалын зүйлийн нөхцөлүүд, гэрээний хугацаа, талуудын гаргах баталгаа, талуудын эрх, үүрэг, гэрээний нууцлал, гэрээний хариуцлагын талаар тусгасан TDBC-156/2020 тоот "Толборийн тасалдлын даатгалын гэрээ"-г 2020 оны 04 дүгээр сарын 06-ны одор байгуулжээ.

Зээлийн гэрээнүүд:

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК болон "Инвескор ББСБ" ХК нарын хооронд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан 18033001 тоот Зээлийн гэрээ (Хавсралт 4.27)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 25,000,000,000 (хорин таван тэрбум) төгрөг
- Зээлийн зориулалт: бизнесийн эргэлтийн зээл
- Зээлийн хүү: жилийн ХХ хувь
- Зээл олгох валют – зээл болон зээлийн эргэн төлөлтийг төгрөгөөр
- Зээлийн хугацаа: 15 жил

Энэхүү гэрээ нь Компанийн тухай хуулийн 87-р зүйлийн 87.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэлд, мөн Компанийн тухай хуулийн 89-р зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд нэгэн зэрэг хамаарч байна. Компанийн тухай хуулийн 92.5 дахь хэсэгт "Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд ... түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277120
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ☎1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2021 05 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

	Зураг 1.4-1 Байгууллагын бүтэц	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын баталгаа

000258



	Үнэн зөв	

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



Б. Анхболд

ТУЗ-ийн дарга

Ажлын туршлага

- Инвескор ББСБ: ТУЗ-ийн дарга
- Эс Ай Би Жэй Капитал: Гүйцэтгэх захирал
- Шунхлай групп: Дэд ерөнхийлөгч
- Abeam Consulting (Япон): Ахлах зөвлөх

Боловсрол

- Рицүмейкан Ази-Номхон Далайн Их Сургууль (Япон): Бизнесийн удирдлагын магистр

Үнэн зөв

2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/24 тоот Хувьцаа эзэмшигчийн шийдвэр, 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/05 тоот Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол, Б.Анхболдын анкет https://www.inves

	• Рицүмейкан Ази-Номхон Далайн Их Сургууль (Япон): Бизнесийн удирдлагын бакалавр		core.mn/index.php?view=stock_governance
 Д.Баясгалан ТУЗ-ийн гишүүн	Ажлын туршлага • Инвескор ББСБ: Гүйцэтгэх захирал • Монголбанк: Төслийн менежер • Худалдаа Хөгжлийн Банк: Санхүүгийн газрын ахлах мэргэжилтэн Боловсрол • Монгол Улсын Их Сургууль: Эдийн засгийн ухааны бакалавр	Үнэн зөв	2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/02 тоот "Инвескор ББСБ" ХХК-ийн үүсгэн байгуулагчийн шийдвэр, 2019 оны 01 дүгээр сарын 02-ны одрийн А/40-Т тоот ТУЗ-ийн хурлын тогтоол, Д.Баясгалангийн анкет, https://www.invescore.mn/index.php?view=stock_governance
 Р.Мөнхтөр ТУЗ-ийн гишүүн	Ажлын туршлага • Эс Ай Би Жэй Капитал: Дэд захирал • Инвескор ББСБ: Дэд захирал • Монгол Улсын Хөгжлийн банк: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга • Монгол Улсын Их Сургууль: Багш • Сэрүүлэг дээд сургууль: Багш Боловсрол • Монгол Улсын Их Сургууль: Эдийн засгийн ухааны магистр • Монгол Улсын Их Сургууль: Эдийн засгийн ухааны бакалавр	Үнэн зөв Үнэн зөв	2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит

000260



Намики Хирохито

ТУЗ-ийн гишүүн

Ажлын туршлага

- Инвескор Жапан: Гүйцэтгэх захирал
- Mitsubishi UFJ Trust and Bank (Япон): Ахлах шинжээч

Боловсрол

- Рочестерийн Их Сургууль (АНУ): Бизнесийн удирдлагын магистр
- Кейо Их Сургууль (Япон): Эдийн засгийн ухааны бакалавр

бус хурлын А/05 тоот тогтоол, Р.Менхтөрийн анкет, https://www.investcore.mn/index.php?view=stock_governance



Г. Уянгахишиг

ТУЗ-ийн гишүүн

Ажлын туршлага

- Инвескор Капитал ҮЦК: Гүйцэтгэх захирал
- Голомт Банк: Хуулийн хэлтсийн захирал
- Шунхлай Групп: Үйл ажиллагаа хариуцсан захирал
- Си Энд Жи Партнерс хуулийн фирм: Үүсгэн байгуулагч партнер
- Цэц хуулийн фирм: Өмгөөлөгч, партнер

Боловсрол

- Бонн хотын Их Сургууль (ХБНГУ): Хууль, эрхзүйн магистр
- Монгол Улсын Их Сургууль: Эрх зүйч бакалавр

2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 тоот тогтоол, Намики Хирохитогийн анкет, https://www.investcore.mn/index.php?view=stock_governance



Т. Тэлмэн

ТУЗ-ийн гишүүн

Ажлын туршлага

- Амар Даатгал: Бизнес хөгжлийн газрын захирал
- Монголын Амьдрал ХХК: Захирал
- Хөдөлмөр Нийгмийн Хамгаллын Яам: Сайдын зөвлөх
- Микрокредит ББСБ: Гүйцэтгэх захирал
- Монголын Алт Компани: Хөрөнгө оруулалтын газрын захирал
- Монгол Даатгал: Даатгал эрхэлсэн дэд захирал
- Монголбанк: Аудитор, хянан шалгагч

2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 тоот тогтоол, Г.Уянгахишиг анкет, https://www.investcore.mn/index.php?view=stock_governance



Ч.Хашчулуун

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол

- Миссури мужийн Их Сургууль (АНУ): Бизнесийн удирдлагын магистр
- Санхүү Эдийн Засгийн Их Сургууль: Санхүүч, банкны эдийн засагч бакалавр

Ажлын туршлага

- Монголбанк: Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн
- Бизнес Эдийн Засгийн сургуулиудын консорциум: Гүйцэтгэх захирал
- Засгийн газрын тохируулагч агентлаг: Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хорооны дарга
- Монгол Улсын Их Сургууль: Эдийн Засгийн Сургуулийн захирал

2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 тоот тогтоол, Т.Тэлмэнгийн анкет, https://www.invescore.mn/index.php?view=stock_governance



Д. Энхбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол

- Кейо Их Сургууль (Япон): Эдийн засгийн ухааны доктор
- Йокохама Хотын Их Сургууль (Япон): Эдийн засгийн ухааны магистр
- Москвагийн Улсын Их Сургууль (ОХУ): Эдийн засгийн ухааны бакалавр

Ажлын туршлага

- Хархорум Дижитал: Ерөнхий захирал
- Нээлттэй мэдлэг боловсролын хүрээлэн: Удирдах зөвлөлийн дарга
- Улсын Их Хурал: УИХ-ын гишүүн
- Датаком: Ерөнхий захирал
- Үндэсний хөгжлийн яам: Дэд сайд
- Шинжлэх Ухаан Техникийн улсын хороо: Дэд дарга
- Үндэсний Информатикийн Төв: Захирал
- Микропроцессорын техникийн олон улсын лаборатори: Эрхлэгч
- Статистикийн Төв газар: Программ зохиогч

2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 тоот тогтоол, Ч.Хашчулуун анкет, https://www.invescore.m



Ч. Өнөржаргал

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол

- Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (Орос): Техникийн шинжлэх ухааны доктор
- Уралын Техникийн Их Сургууль (Орос): Системийн инженер

Ажлын туршлага

- Санхүү Эдийн Засгийн Их Сургууль: Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн ахлах багш
- BDO Адвойсэри Такс ТМЗ: Татварын ахлах зөвлөх
- Саксон Монголиа: Гэрээт нягтлан бодогч
- Футура Фэйшн: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх
- Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхим: Багш
- Монгол Ханамаса: Нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогч

Боловсрол

- Монгол Улсын Их Сургууль: Бизнесийн удирдлагын магистр
- Санхүү Эдийн Засгийн Их Сургууль: Бизнесийн удирдлагын бакалавр

n/index.php?view=stock_governance

2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 тоот тогтоол, Д.Энхбатын анкет, https://www.invescore.mn/index.php?view=stock_governance

2019 оны 07 дугаар сарын 25-ны одрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 тоот тогтоол, Ч.Өнөржаргал

000263

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-02-03

ИНВЕСКОР КАПИТАЛ УРАХ ХК
6347839, 4119277129
УЛААНБААТАР ХОТ
Investcore

2021-05-27

			анкет, https://www.invescore.mn/index.php?view=stock_governance
	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн ТУЗ-н дэргэдэх хороодын бүрэлдэхүүн болон холбогдох журмууд нь ТУЗ-н 2019 оны 8 сарын 5-ны өдрийн А/28-Т тоот тогтоолоор батлагдсан. **Хүснэгт 1.4-1 ТУЗ-н дэргэдэх хороодын бүрэлдэхүүн**		Үнэн зөв	ТУЗ-н 2019 оны 8 сарын 5-ны өдрийн А/28-Т тоот тогтоол
	Хороо	**Дарга**	**Гишүүд**	Үнэн зөв	ТУЗ-н 2019 оны 8 сарын 5-ны өдрийн А/28-Т тоот тогтоол
	Аудитын хороо	Ч.Өнөржаргал	Ч.Хашчулуун, Р.Мөнхтөр		
	Цалин урамшууллын хороо	Д.Энхбат	Т.Тэлмэн, Ч.Өнөржаргал		
	Нэр дэвшүүлэх хороо	Ч.Хашчулуун	Д.Энхбат, Х.Намики		
	Эрсдэлийн удирдлагын хороо	Б.Анхболд	Д.Баясгалан, Г.Уянгахишиг		
	Удирдлагын баг				
	  			Үнэн зөв	Д. Баясгалан, Х.Амгаланбаатар, Р.Нүрэв, О.Дабааням, Н.Арсланбаатар, Ш.Эрдэнэбилэг, Ш.Цэрэндаваа, С.Тулга, А.Энэрэл, нарын анкет мэдэгдэл, баталгаа

000264

ИНВЕСКОР ЭССЭС ХК
6369063
УЛААНБААТАР ХОТ
Investcore

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
Бүртгэсэн

Д. Баясгалан Гүйцэтгэх захирал Ажлын туршлага • Монголбанк: Төслийн менежер • ХХБ: Санхүүгийн ахлах мэргэжилтэн	Х. Амгаланбаатар Дэд захирал Ажлын туршлага • ХХБ: Газрын захирал • ХХБ: Салбарын захирал • ХХБ: Ахлах эдийн засагч	Р. Пүрэв Санхүү хариуцсан дэд захирал Ажлын туршлага • Ою Толгой ХХК: Аудитор • Сангийн яам: Мэргэжилтэн • Голомт банк: Дилер
		
О. Дабааням Салбарын удирдлагын газрын захирал Ажлын туршлага • ХХБ: Салбарын захирал • ХХБ: Менежер • ХХБ: Ахлах эдийн засагч	Н. Арсланбаатар Хууль, эрсдэлийн удирдлагын газрын захирал Ажлын туршлага • Инвескор: СУГ захирал • Ариг банк: Ахлах эрсдэлийн менежер • Хас банк:Бүс хариуцсан захирал	Ш. Эрдэнэбилэг Үйл ажиллагааны газрын захирал Ажлын туршлага • Инвескор: Салбарын захирал • Гадаад харилцааны яам: Мэргэжилтэн • ХХБ: Мэргэжилтэн

0000265

		
Ш.Цэрэндаваа Санхүүгийн газрын захирал Ажлын туршлага • Голомт банк: Ахлах менежер • Кредит Монгол: Санхүүгийн захирал • Анод банк: Салбарын захирал, Аудитор, ДАГ захирал • Ард банк: Нягтлан бодогч	С.Тулга Стратеги, удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн захирал Ажлын туршлага • Мирамон Фанд: Бизнес хөгжлийн захирал • Голомт банк: Ахлах менежер	А.Энэрэл ТУЗ-н нарийн бичгийн дарга Ажлын туршлага • Эс Ай Би Жэй Капитал: Санхүүгийн ахлах мэргэжилтэн • Хаан банк: Мэргэжилтэн • Шангри-Ла зочид буудал: Нягтлан бодогч • Вагнер Ази Тоног Төхөөрөмж: Ерөнхий ня-бо

Компанийн ТУЗ-ийн гишүүд, бусад эрх бүхий албан тушаалтнуудын туршлага болон холбогдох хууль, журмын шаардлагыг хангасан болох тухай Хуулийн дүгнэлтийн 2 дугаар хэсэгт оруулжээ.

1.5	**1.5. Үнэт цаас гаргагчийн Зах Зээлийн Үнэлгээ, Арилжааны Идэвх** Инвескор ББСБ нь 2019 онд нийт хувьцааныхаа 15% буюу 10,759,188 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар олон нийтэд санал болгосон ба нийт санал болгосон хувьцааны 85%-ийг стратегийн хөрөнгө оруулагчдад, 15%-ийг олон нийтэд санал болгон арилжаалсан бөгөөд хөрөнгө оруулагчид нийт 18.9 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлж, анхдагч зах зээлийн арилжаа нийлүүлэлтээсээ давж амжилттай хаагдсан билээ.	Үнэн зөв	Андеррайтерийн шинжилгээ
	Хүснэгт 1.5-1 Үнэт цаас гаргагчийн хувьцааны мэдээлэл Үнэт цаасны код: INV Зах зээлийн үнэлгээ: 209.4 тэрбум төгрөг Зарласан хувьцааны тоо ширхэг: 82,000,000 ширхэг Хаалтын ханш (2020.12.25): 2,920.0 төгрөг 52 д/х дээд ханш: 2,940.0 төгрөг 52 д/х доод ханш: 2,198.0 төгрөг Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн: 2019.06.10 Түүнээс хойш ханшийн өсөлт: 73.8% *Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, 2019.06.10-2020.12.25*		Монголын хөрөнгийн бирж, 2019.06.10-2020.12.25
	График 1.5-1 Үнэт цаас гаргагчийн хувьцааны ханш, арилжаа		Монголын хөрөнгийн бирж, 2019.06.10-2020.12.25



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, 2019.06.10-2020.12.25

	"Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаа нь МХБ-ийн ТОП-20 индекс, арилжааны Б самбарт багтдаг богоод 2020 оны эхний хагас жилийн байдлаар арилжааны идэвхийн хувьд 7-р байранд эрэмбэлэгдэж байна.	Андеррайтерийн шинжилгээ
1.6	**1.6. Үнэт цаас гаргагчийн Үйл Ажиллагаа** Зээлийн үйл ажиллагаа Үнэт цаас гаргагч нь уламжлалт болон финтект суурилсан зээлийн үйлчилгээг зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлөөр санал болгон ажилладаг бөгөөд 2020 оны 3 дугаар улирлын байдлаар зээлийн багц нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34% хувиар өсжээ. Тус тайлант хугацаанд зээлдэгчийн тоо 50,762 болж, зээлийн багцын хэмжээ 84.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.	Андеррайтерийн шинжилгээ
	Бизнесийн зээлийн төрөл ✓ Эргэлтийн хөрөнгийн зээл ✓ Хөрөнгө оруулалтын зээл ✓ Жижиг, дунд бизнесийн зээл ✓ Бизнесийн зээлийн шугам **Хэрэглээний зээлийн төрөл** ✓ Цалингийн зээл ✓ Шуурхай зээл ✓ Автомашин худалдан авах зээл ✓ Итгэлцэл барьцаалсан зээл	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.invescore.mn/view/loan/?page=item Зээлийн үйл ажиллагааны журам

✓ Толборийн баталгаа, факторинг ✓ Кредит карт ✓ Дугааргүй авто машин барьцаалсан зээл	
График 1.6-1 Зээлийн багцын өсөлт (цэвэр), 2016-2020.III  	Андеррайтерийн шинжилгээ
2020 оны 3-р улирлын байдлаар банкны салбарын зээл 17.2 их наяд төгрөг, ББСБ-ын салбарын зээл 1.3 их наяд төгрөг байсан бөгөөд Үнэт цаас гаргагчийн зээлийн багц 84.9 тэрбум төгрөг, эрсдлийн сан хассан дүн нь 83.0 тэрбум төгрөг байна. Зээлийн багцын дүнгээр ББСБ-н зах зээлд эзлэх хувь 6.6% байна.	Андеррайтерийн шинжилгээ
График 1.6-2 Зээлийн багцын бүтэц, 2020.III улирал  	Андеррайтерийн шинжилгээ

"Инвескор ББСБ" ХК-ийн зээлийн багц нь бүтээгдэхүүний төрөл, харилцагчийн сегмент болон эдийн засгийн салбаруудаар жигд тараан байршигдсан тул эдийн засгийн гадаад шок болон эрсдэлийн нөлөөлөл харьцангуй бага байдаг.		Андеррайтерийн шинжилгээ
График 1.6-3 Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанар 2020.III 		Андеррайтерийн шинжилгээ
2020 оны III улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь 3.6% байгаа нь ББСБ-ын салбарын үзүүлэлт (9.4%)-ээс 5.8 нэгжээр бага байна. *(Санхүүгийн Зохицуулах Хороо, ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн танилцуулга)*		Андеррайтерийн шинжилгээ
Итгэлцлийн үйлчилгээ		Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.invescore.mn/view/loan/?page=item&id=10
Компани нь итгэлцлийн үйлчилгээгээр гурван төрлийн (₮, $, ¥) валютаар дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдаас эх үүсвэр татлаг бөгөөд 2020 оны 3-р улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг 39.6 тэрбум төгрөгт хүрээд байна.		Андеррайтерийн шинжилгээ
2020 оны 3-р байдлаар итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий 42 ББСБ байгаагаас "Инвескор ББСБ" ХК нь салбарын нийт итгэлцлийн үйлчилгээний 28 хувийг дангаар бүрдүүлсэн нь хөрөнгө оруулагчдын дунд тус компанийн нэр хүнд, итгэл өндөр байгааг илтгэж байна. *(Санхүүгийн Зохицуулах Хороо, ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн танилцуулга)*	Үнэн зөв	Санхүүгийн Зохицуулах Хороо, ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн танилцуулга

График 1.6-3 Үнэт цаас гаргагчийн итгэлцлийн үйлчилгээ

Итгэлцлийн хэмжээ, тэрбум төгрөг



ББСБ салбарт эзлэх хувь, 2020.III



Андеррайтерийн шинжилгээ

Цахим хэтэвч болон зээлийн үйлчилгээ "Инвескор ББСБ" ХК-ийн 100% охин компани болох "Инвескор Хэтэвч" ХХК нь 2020 оны 1 дүгээр сард Покет аппликэйшнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.	Үнэн зөв	"Инвескор хэтэвч ББСБ" ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ
Харилцагчийн аппликэйшн болон бүртгэлийн системийн хөгжүүлэлтийг Инвескор Санхүүгийн Группийн нэг хэсэг болох "Инвескор Эй Ай Лаб" ХХК хариуцаж гүйцэтгэсэн.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.unread.today/c/spotlight-pocket	
"Покет нь цахим зээл, төлбөр тооцооны цогц үйлчилгээ бүхий хиймэл оюун ухаан, гар утасны аппликэйшнд суурилсан дэвшилтэт технологийн бүтээгдэхүүн юм"	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.unread.today/c/spotlight-pocket	

000271

Покет аппликэйшн нь доорх бүтээгдэхүүн үйлчилгээг агуулдаг. Үүнд:

- ✓ Барьцаагүй онлайн бичил зээл
- ✓ Цахим мөнгөний хэтэвч
- ✓ Шимтгэлгүй гүйлгээ, шилжүүлэг
- ✓ Покет Купон – худалдаа, үйлчилгээний хөнгөлөлтийн үйлчилгээ
- ✓ Покет Зеро - дараа төлөх нөхцөлөөр бараа үйлчилгээ авах толборийн систем
- ✓ Покет Студент – оюутнуудад зориулсан багц үйлчилгээ

Зураг 1.6-1Аппликэйшний онцлог талууд:

pocket
илүү happy ...

Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://pocket.mn/?utm_term=pocket&utm_campaign=Website%20traffic-Search-pocket&utm_source=adwords&utm_medium=ppc&hsa_acc=5392469927&hsa_cam=9343064818&hsa_grp=94936386419&hsa_ad=418320084905&hsa_src=g&hsa_tgt=kwd-10396591&hsa_kw=pocket&hsa_mt=b&hsa_net=adwords&hsa_ver=3&gclid=Cj0KCQiAuJb_BRDJARIsAKkycUlRRQ24rHooGKkz6p_Q26kb23eN173448kAMD_I4ZA6HzRWRt1taQcaAgjtEALw_wcB

Get Happy

Зээлийн хэмжээ
20,000₮-10,000,000₮
Хамгийн багаас хамгийн өндөр дүнгээр зээл авах боломжтой

Зээлийн шимтгэл, хүү
Сонгосон хугацаанд зөвхөн шимтгэл авна. Хугацаа нь дуусангүүт хэнгоор хүү тооцогдоно.

Зээл олгох хугацаа
14, 30, 60 хоног

Invest Happy

Smartfund
Энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчид зөвхөн зээлдэгч байх бус хэтэвчээр хөрөнгө оруулагч байх боломжийг олгоно.

Pay Happy

Pocket Wallet
Төлбөр тооцоо төлөх.
Хэтэвч хэрэглэхэд бонус оноо нэмэгдэнэ.

Урамшууллын зоос
Хэтэвчинд байгаа мөнгөн дүнд хугацаагүй хадгаламж шиг бага хэмжээний урамшууллын зоос олгож, зооснуудаа сард 1 удаа ₮-т хөрвүүлж авах боломж.

Reward Happy

Бонус оноо
Бонус цуглуулах
1. Зээлээ хугацаандаа төлөх
2. Хэтэвч хооронд шилжүүлэг хийх
3. Мэдээ унших түгээх
4. Тоглоом тоглох
5. Хөрөнгө оруулах, хандив өгөх
6. Найзаа урих
Цуглуулсан бонус оноогоороо зээрэглэл ахина. Зээрэглэл ахих тусам зээлийн хэмжээ нэмэгдэж, шимтгэл буурна.

	Покет аппликэйшн - хувилбар 2.0 Покет аппликэйшний 2.0 хувилбарт дараа төлбөрт нөхцөлөөр бараа бүтээгдэхүүн үйлчилгээ худалдаж авах буюу Покет Зеро үйлчилгээ багтсан. Энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчдэд хүү шимтгэлгүй, урьдчилгаа толборгүйгээр 30 гаруй хамтран ажиллагч компаниудын бүтээгдэхүүнийг зээлээр худалдаж авах боломжийг олгож байна. **Зураг 1.6-1 Покет Зеро үйлчилгээний онцлогууд** 	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://pocket.mn/?utm_term=pocket&utm_campaign=Website%20traffic-Search-pocket&utm_source=adwords&utm_medium=ppc&hsa_acc=5392469927&hsa_cam=9343064818&hsa_grp=94936386419&hsa_ad=418320084905&hsa_src=g&hsa_tgt=kwd-10396591&hsa_kw=pocket&hsa_mt=b&hsa_net=adwords&hsa_ver=3&gclid=Cj0KCQiAuJb_BRDJARIsAKkycUlRRQ24rHooGKkz6p_Q26kb23cN173448kAMD_I4ZA6HzRWRt1taQcaAgjtEALw_wcB

000273

График 1.6-4 Покет Зээлийн гэрээ байгуулсан харилцагчийн тоо  	Андеррайтерийн шинжилгээ
2020 оны 3-р улирлын байдлаар нийт 160 мянган харилцагч Покет аппликэйшн-д бүртгүүлсэн бөгөөд үүний 39,702 нь зээлийн гэрээ байгуулаад байна. Мөн аппликэйшн нь Монгол Улсын хэмжээнд богино хугацаанд хамгийн их татагдсан Топ 3 аппликэйшний нэг бөгөөд Play Store болон App store дээр дундажаар 4.7 үнэлгээтэй байна.	Андеррайтерийн шинжилгээ
График 1.6-5 Покет Зээлийн багц (сая ₮)  	Андеррайтерийн шинжилгээ
Нийгмийн даатгал болон зээлийн мэдээллийн санд тулгуурлан хөгжүүлсэн скорингийн цогц систем нь зээлийн эрсдэлийг бага байлгах болон үр дүнтэй удирдах гол хүчин зүйл юм. 2020 оны 3-р улирлын байдлаар Покет	Андеррайтерийн шинжилгээ

000274

аппликэйшнээр олгосон зээлийн багц дахь хугацаа хэтэрсэн зээл 3.3%, чанаргүй зээл 1.4% байгаа богоод 2021-2023 онд хугацаа хэтэрсэн зээлийг 5%, чанаргүй зээлийн хувийг 3%-с хэтрүүлэхгүй ажиллана.		
Покет аппликэйшний хувьд 2021 онд илүү бие даасан байдлаар санхүүгийн олон төрлийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээ агуулсан платформ буюу санхүүгийн экосистем болох зорилготой байгаа юм.	Андеррайтерийн шинжилгээ	
Төсөл хөтөлбөрүүд		
Инвескор Аллианс		
"Инвескор ББСБ" ХК нь дотоодын зах зээлд барьж буй "Ухаалаг төлөлт" стратегийн хүрээнд 2020 оны 3 дугаар улиралд "Инвескор Аллианс" хөтөлбөрийг амжилттай эхлүүлсэн юм.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн бизнес төлөвлөгөө
Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Инвескор ББСБ салбартаа тэргүүлэгч байгууллагын хувьд хуримтлуулсан туршлага, ноу-хаугаа ашиглан орон нутгийн ББСБ-уудыг чадавхижуулах, улмаар орон нутгийн харилцагчдын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа юм.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн бизнес төлөвлөгөө
Зураг 1.6-2 Инвескор Аллианс хөтөлбөрийн гишүүдийн танилцуулга, сургалт	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.invescore.mn/view/article/?page=item&id=239	
Инвескор нь Аллианс хөтөлбөрт нэгдсэн ББСБ-уудад дараах чиглэлүүдээр хамтран ажиллана. Үүнд: ✓ Зөв засаглал, менежмент ✓ Эрсдэл, комплаенсын удирдлага ✓ Борлуулалтын удирдлага ✓ Харилцагчийн үйлчилгээ ✓ Хүний нөөцийн бодлого ✓ Сургалт, зөвлөх үйлчилгээ ✓ Систем, программ хангамж ✓ Тогтвортой эх үүсвэр ✓ Хамтын санхүүжилт	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.invescore.mn/view/article/?page=item&id=239	
SMB Сэмбий хөтөлбөр	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн бизнес төлөвлөгөө
"Инвескор ББСБ" ХК нь 2018 оноос хойш өөрийн бизнесийн харилцагчдад зориулсан үнэ төлбөргүй сургалт, зөвлөх үйлчилгээний SMB хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн үндсэн зарчим нь 50%-ийн санхүүжилт, 50%-ийн зөвлөгөө бөгөөд 2018 оноос хойш уг хөтөлбөрт нийт 116 харилцагч хамрагдсан байна. 2021 онд шинээр 20 гаруй харилцагчийг хамруулахаар төлөвлөж байна.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн бизнес төлөвлөгөө

	Сургалт, зөвлөгөөний хамрах хүрээ: Хөтөлбөрийн зорилтот харилцагчид: ***Мэдээллийн технологи болон автоматжуулалт***	✓ Татвар, нягтлан бодох бүртгэл ✓ Санхүүгийн менежмент ✓ Хууль эрхзүй ✓ Бизнес төлөвлөгөө ✓ Стратеги менежмент ✓ Зах зээлийн судалгаа ✓ Эмэгтэй бизнес эрхлэгчид ✓ Ногоон санхүүжилт авах харилцагчид ✓ Орон нутгийн ЖДҮ эрхлэгчид ✓ Банкнаас зээл авах боломжгүй бизнес эрхлэгчид	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.invescore.mn/index.php?view=sembii

СЗХ
2021 .05 27 өдөр
БҮРТГЭВ
№ 01

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛА'АНБААТАР ХОТ

000276

"ИНВЕСКОР БЕСБ" ХК
InvesCore

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

"Инвескор ББСБ ХК" нь Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд Процессийн дахин инженерчлэл хийж, шинэчилж сайжруулсан үйл ажиллагааны процесстоо хүний гар ажиллагааг 80 хүртэл хувиар автомажуулсан CBS (Core Banking System) болон Smart LOS (Loan Originator System) гэсэн хоёр гол системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

Smart LOS

Смарт-ЛОС нь зээлийн судалгаа, шийдвэр гаргалт, олголт, явцын хяналт, хаалт гэсэн үндсэн 5 үйл явцыг бүрэн автоматжуулсан зээлийн үйл ажиллагааны дотоод систем бөгөөд уг системээр дамжуулан харилцагчийн 22 төрлийн мэдээллийг албан ёсны эх сурвалжаас авч, зээлийн судалгааны тайланг бэлтгэн шийдвэр гаргахад бэлэн болгож өгдөг ба хүнээс хамааралтай алдааг 80 хувиар бууруулахын зэрэгцээ харилцагчдад түргэн шуурхай мэдээллийн нууцлалыг чанд хадгалсан үйлчилгээ үзүүлэх боломжийг олгодгоороо давуу талтай.

CBS - Core Banking System

CBS систем нь Smart-LOS системтэй холбогдон банк бус санхүүгийн байгууллагын үндсэн үйл ажиллагааг түргэн шуурхай гүйцэтгэдэг.

CBS систем нь дараах давуу талуудтай. Үүнд:

- ✓ Зохицуулагч байгууллагын шаардлагад нийцсэн
- ✓ Эрхийн зохицуулалт, хяналт
- ✓ Мэдээллийн аюулгүй байдал
- ✓ Дэлгэрэнгүй тайлан мэдээллүүд, дашбоард
- ✓ Мэдээллийн нөөцлөлт (backup)
- ✓ Мобайлд суурилсан харилцагчийн үйлчилгээ
- ✓ Арилжааны банкуудын гүйлгээний системтэй холбогдсон

Инвескор Смарт Киоск төхөөрөмж

Үнэт цаас гаргагч нь 2020 оны 3 дугаар улиралд Смарт киоск буюу зээлийн эдийн засагчийн үйл ажиллагааг орлох, ирээдүйд биет салбарыг дангаар орлох зорилготой, технологийн шинэлэг шийдэл бүхий төхөөрөмжийг амжилттай нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар зарим худалдааны компаниудтай хамтран бага дүнтэй лизингийн зээлийг киоскоор дамжуулан шуурхай олгож байна. Киоск төхөөрөмжийг нэвтрүүлснээр зээлийн судалгаанд зарцуулах хугацааг 5 дахин бууруулсан.

Зураг 1.6-4 Смарт Киоск

Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл
https://www.invescore.mn/index.php?view=about&scroll_to=structure#,
http://bloombergtv.mn/%D0%B8%D0%BD%D0%B2%D0%B5%D1%81%D0%BA%D0%BE%D1%80-%D1%8D%D0%B9-%D0%B0%D0%B9-%D0%BB%D0%B0%D0%B1-%D1%84%D0%B8%D0%BD%D1%82%D0%B5%D0%BA-%D0%B1%D2%AF%D1%82%D1%8D%D1%8D%D0%B3%D0%B4%D1%8D%D1%85%D2%AF%D2%AF%D0%BD%D1%8D%D1%8D-%D1%8D%D0%BD%D1%8D-%D0%BE%D0%BD%D1%8B-iii-%D1%83%D0%BB%D0%B8%D1%80%D0%B0%D0%BB%D0%B4-%D0%B7%D0%B0%D1%85-%D0%B7%D1%8D%D1%8D%D0%BB%D0%B4-%D0%BD%D1%8D%D0%B2%D1%82%D1%80%D2%AF%D2%AF%D0%BB%D0%BD%D1%8D/?cid=133



2021 онд киоскоор үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн хэрэглээний тодийгүй бизнесийн зээл олгох ба харилцагчдад зээлийн төлөлт хийж, дансны хуулгаа авах боломжийг бүрдүүлэх юм.

Мон киоск тохооромжийг томоохон худалдаа үйлчилгээний байгууллагууд болон сүлжээ дэлгүүрүүдэл байршуулж бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлнэ.

1.7	**1.7. Өсөлт Хогжил /Давуу Тал**	
"Инвескор ББСБ" ХК нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш 4 жилийн хугацаанд Монголын ББСБ-ын салбарын тэргүүлэгч байгууллага болж хогжсон богоод харилцагчийн тоо, зээлийн багц, ашигт ажиллагаа болон шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ ямагт тэргүүн эгнээнд явж ирсэн. Үүнд нөлөөлсон гол хүчин зүйлүүдийг дурдвал:	Андеррайтерийн шинжилгээ	
Зах зээлийн өсөлт, хогжил		
ББСБ-ын салбар, арилжааны банкны салбараас илүү хурдтай өсч хогжиж байгаа бол "Инвескор ББСБ" ХК нь салбартаа хамгийн өндөр өсөлттэй байгаа нь тогтвортой санхүүжилт, мэргэжлийн үйл ажиллагаа, технологид суурилсан шийдэл, автоматжуулалт, түргэн шуурхай үйлчилгээний үр дүн юм.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл. https://www.invescore.mn/index.php?view=about#	
Компанийн засаглал		
Зураг 1.7-1 Инвескор ББСБ - IPO Үнэт цаас гаргагч нь хувийн хэвшлийн түүхэн дэх хамгийн том IPO-г амжилттай хийж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд компанийн засаглалын үндсэн тулгуур зарчмуудыг даган мөрдөж Монгол Улсдаа тедийгүй бүс нутагтаа зөв засаглал, зөв менежмент болон ил тод байдлаар үлгэр жишээ болж байна.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл. https://www.invescore.mn/index.php?view=stock_governance	
"Инвескор ББСБ" ХК нь дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг бөгөөд засаглалын баримт бичгүүд нь хууль тогтоомж болон СЗХ-оос батлагдсан "Компанийн засаглалын кодекс" нийцсэн тухай Хуулийн дүгнэлтийн 3 дугаар хэсэгт дурдсан байна.	Үнэн зөв	Гүйцэтгэх захирлын баталгаа
Хүний нөөц		
Гадаад, дотоодын банк болон санхүүгийн байгууллагуудад олон жил ажилласан туршлагатай эерэг хандлагатай мэргэжилтнүүдээр багаа бүрдүүлдэг тул бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, мэргэжлийн байдлаараа тэргүүлж байна.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.invescore.mn/index.php?view=human_resource&scroll_to=about	

	График 1.7-1 Үндсэн ажилтны тоо		
		Андеррайтерийн шинжилгээ	
	Эрсдэлийн удирдлага		
	"Инвескор ББСБ" ХК-ийн хувьд эрсдэлийн удирдлагын бодлогыг 3 түвшинд хэрэгжүүлж, зээлийн эрсдэлийн бодлого, журам, бусад аргачлалуудын хувьд санхүүгийн салбартаа тэргүүлж байна. Үүний нотолгоо нь 2020 оны 3-р улирлын байдлаар ББСБ болон санхүүгийн салбартаа чанаргүй зээлийн хувь хэмжээгээр хамгийн бага нь байна. Гол шалтгаанууд нь зээлийн судалгаа, зээл олголтын үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан, мөн зээлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүний хүчин зүйлийг зохистой түвшинд барьж, олон улсын түвшний скоринг системийг ашигладагт оршино. Мөн зээлийн борлуулалт, судалгаа, олголт, хяналтын бүх түвшинд дараалсан хяналтын систем ажиллаж байдгийн зэрэгцээ зээлдэгчидтэй байнгын эргэх холбоотой ажилладаг тул асуудлуудыг түргэн шуурхай шийдвэрлэж болзошгүй эрсдлүүдээс урьдчилан сэргийлдэг.	Андеррайтерийн шинжилгээ	
	Гадаад зах зээлд баримтлах "Санхүүгийн экспорт" стратеги		
	"Инвескор ББСБ" ХК нь өөрийн бизнесээ зөвхөн лотоод зах зээлээр хязгаарлахгүйгээр Монголтой соёл болон бусад зүйлээрээ адил тостэй хогжиж буй орнуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ экспортлох бодлого баримталдаг. Төв Азийн хогжиж буй орнуудын зах зээлд өөрсдийн амжилт туршлага, финтек бүтээгдэхүүн, санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн давуу талаа ашиглан, салбар компани байгуулах төлөвлөгөөний дагуу Киргиз Улсад хоёр охин компани байгуулж, үйл ажиллагааг нь амжилттай эхлүүлээд байна.	Андеррайтерийн шинжилгээ	

000280

	"Золотой Стандарт" МКК – 2020 оны 1 сард Киргиз Улсын "Золотой Стандарт" МКК-г худалдан авч "Инвескор ББСБ" ХК нь 100 хувь эзэмших болсон. Хүний нөөцийг шинээр бүрдүүлж, компанийн бодлого журмуудыг шинэчлэн сайжруулж, CBS болон LOS системийг амжилттай нэвтрүүлсэн.	Үнэн зөв	Золотой стандарт МКК (Киргиз) гэрчилгээ
	"Покет КГ" ХХК – 2020 оны 8 сард байгуулагдсан. Покет аппликэйшний Киргизийн зах зээлд зориулсан хувилбарыг хөгжүүлж нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр түс улсад нэвтрэх хамгийн анхны хэтэвчид суурилсан финтек, бичил зээлийн онлайн үйлчилгээ болох юм.	Үнэн зөв	Покет КГ (Киргиз) гэрчилгээ
1.8	**1.8. Эрсдэлийн удирдлага**		
	"Инвескор ББСБ" ХК нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлагдсан журмын дагуу эрсдэлийн удирдлагын цогц бодлого хэрэгжүүлэг бөгөөд 2020 онд эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бататган сайжруулж, хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлж, холбогдох хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн бодлого, журмуудаа шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. 2020 оны 3-р улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн ББСБ-ын болон санхүүгийн салбартаа чанаргүй зээлийн хувь хэмжээгээр хамгийн бага нь байна. Үндсэн шалтгаанууд нь зээлийн судалгаа, зээл олголтын үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан, мөн зээлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүний хүчин зүйлийг зохистой түвшинд барьж, олон улсын түвшний скоринг системийг ашигладагт оршино. Мөн зээл олголт хийгдсэний дараа харилцагчтайгаа тогтмол харилцаж, тусалж дэмжих, зөвлөгөө өгөх байдлаар хамтран ажилладаг тул асуудлуудыг түргэн шуурхай шийдвэрлэж болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлдэг.	Андеррайтерийн шинжилгээ	
	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны гол зорилго нь зохицуулагч байгууллагын хязгаарлалтын хүрээнд байгууллагын хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг удирдах эрсдэлийн төрөл тус бүрээр тодорхойлж тэдгээрийн хэрэгжилтийг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Гүйцэтгэх удирдлагын хороонд сар бүр тайлагнан ажиллаж байна.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого, Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам.
	Эрсдэлийн соёл		
	ББСБ нь эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо амжилттай суурилуулж, холбогдох бодлого журмуудаа шинэчилсэнтэй зэрэгцэн Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд болон холбоотой компаниудын бүхий л ажилтнуудыг хамруулсан "Эрсдэлийн соёл"-ыг түгээх шат дараалсан сургалтуудыг амжилттай зохион байгуулж ажилтан бүр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг, ажилтан бүр эрсдэлийн менежер байх соёлыг түгээн ажиллаж байна.	Андеррайтерийн шинжилгээ	

Эрсдэлийн төрөл			
"Инвескор ББСБ" ХК нь учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангилж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч ажилладаг. Үүнд:		Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого, Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам.
Зээлийн эрсдэл:	Үнэт цаас гаргагч **нь зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлого болон холбогдох үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлуулж байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь эрсдэлд суурилсан аргачлалаар харилцагчийг үнэлэх, зээл олгох шалгуурыг эрсдэлд суурилсан байдлаар тогтоох, харилцагчийг зээлийн эрсдэлд орохоос хамгаалах зэрэг хариуцлагатай, зөв зээлийн үйл ажиллагааг харилцагчид хүргэх давуу талыг бий болгож байна.** Үнэт цаас гаргагч **нь хүлээн зөвшөөрөх зээлдэгчийн стандарт шаардлага болон зээлийн төрөл, бүтээгдэхүүн бүрээр эрсдэлийн хязгаарлалт, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг ялгаатай тогтоон хяналтыг хэрэгжүүлэх замаар зээлийн эрсдэлийг оновчтой удирдан ажиллаж байна.**	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого, Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам.
Зээлийн төвлөрлийн эрсдэл:	Үнэт цаас гаргагч нь зохицуулагч байгууллагын үйл ажиллагааны хязгаарыг ханган ажиллаж байгаа бөгөөд бизнесийн стратеги төлөвлөгөө, өөрийн үйл ажиллагааны онцлог, салбаруудын байршил, харилцагчдын сегмент зэрэгт тулгуурлан зээлийн багцын төвлөрлийг эдийн засгийн сектор болон бүтээгдэхүүний түвшинд ангилан тогтоож тэдгээрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
Зах зээлийн эрсдэл	Үнэт цаас гаргагч нь санхүүгийн эрсдэлийг удирдах журмын дагуу хүүгийн болон валютын ханшийн эрсдэлийг удирдаж ажилладаг. Үүний тулд гадаад валютын актив пассивын зөрүүг үе шаттайгаар бууруулж, актив, пассивын хүүгийн зохистой харьцааг хадгалах, эргэн төлөгдөх хугацааны зөрүүг бууруулах ажлуудыг гүйцэтгэж байна.		
Өөрийн хөрөнгийн эрсдэл	Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн газар болон Хууль эрсдэлийн удирдлагын газар нь өөрийн хөрөнгийн эрсдэлийг удирдаж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилладаг. Уг газрууд нь өөрийн хөрөнгийн эрсдэлийг		

	удирдах чиглэлээр Гүйцэтгэх захирал болон ТУЗ-д тухай бүр тайлагнаж үүрэг даалгавар авч ажилладаг.		
Хөрвөх чадварын эрдэл	Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн газар нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого журмыг боловсруулж батлуулах болон хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэдэг.		
Үйл ажиллагааны эрдэл:	Үнэт цаас гаргагч нь хяналтад суурилсан үйл ажиллагааны эрсдэлийн тогтолцоог бий болгосноор аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын дотоод тогтолцоотой болж, ажилтнууд үүсч болзошгүй эрсдэлийн тохиолдлын талаар мэдээлдэг, эрсдэл бий болохоос өмнө сэргийлж чаддаг соёл руу шилжиж байна. Үүний тулд "Инвескор ББСБ" ХК-ийн нэгж бүр өөрийн хариуцдаг үйл ажиллагааны процессыг тодорхойлж, тухайн процесст оролцогчдын чиг үүргийг тодорхойлон байгууллагын үйл ажиллагааны эрсдэлээс амжилттай хамгаалан ажиллаж байна. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь процессын нэгдсэн тогтолцоотой болж газар нэгжүүд болон албан тушаалтнуудын чиг үүргийн давхардлыг арилгаж, үр ашигтай, үр дүнтэй хяналтын тогтолцоог бий болгож, хүнд биш процесст суурилсан бизнесийн тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.		
Ашиглалтын байдлын эрсдэл	Үнэт цаас гаргагч нь харилцагчдадаа шинэ технологид суурилсан хурдан шуурхай, сонирхол татсан орсолдохүйц, хэрэглэгч төвтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож ажилладаг бөгөөд Мэдээлэл технологи, Мэдээллийн ашиглалтын байдал, Цахим ашиглалтын байдалд онцгой анхаарал хандуулан олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн мэдээллийн технологийн үйл ажиллагаагаа улам сайжруулж эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг илрүүлэх, тайлагнах, бууруулах, хянаж ажиллах тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Мөн харилцагчийн мэдээллийн нууцлалд онцгой анхаарах, бизнесийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор үйл ажиллагаандаа хэрэглэдэг бүхий л мэдээллийн системүүдийн нөөц бололцоог сайжруулж, шинэчлэх, дэвшилтэд технологиудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь бодит ашиглалтын байдлын удирдлагыг ашиглалтын байдлын заавар зөвлөмж гарган нийт ажилтнуудад мөрдүүлэх, Бизнесийн тасралтгүй		

	байдлын төлөвлөгөөний дагуу онцгой байдлын үед ажиллах заавар зөвлөмжийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Үүний үр дүнд ажилтан бүр байгууллагад учирч болзошгүй бодит аюул занал, эрсдэлийн талаар ойлголттой болж өдөр тутмын үйл ажиллагаандаа урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэвшсэн.		
Ёс зүйн эрсдэл	Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Бизнесийн болон Ажилтны баримтлах ёс зүйн дүрмийг батлуулж, ажилтан бүр дагаж мөрдөх, биелүүлж ажиллах үүргийг хүлээсэн бөгөөд ёс зүйн зөрчилтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэр гаргах процессыг тодорхой болгож улмаар Шүгэл үлээх журмыг боловсруулан гаргаж нийт ажилтнуудад таниулан, хэрэгжүүлж ажиллаж байна.		
Хянан нийцүүлэлтийн эрсдэл	Үнэт цаас гаргагч нь хянан нийцүүлэлт хариуцсан ажилтныг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилон ажиллаж байгаа бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогыг толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан групп болон охин компаниудад нэгэн адил мөрдөн ажиллаж байна. Компланс хариуцсан ажилтан нь Үнэт цаас гаргагч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үнэт цаас гаргагч ажилтан бүр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээлэлтэй байх зорилгоор жилд нэг удаа сургалтад заавал хамрагдсан байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргийг биелүүлэн ажиллаж байна.		
Нэр хүндийн эрсдэл	Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлага болон салбар нэгжийн удирдлагууд нь ажилтнуудлаа ББСБ-ын нэр хүнд, үнэ цэнийн талаарх ойлголт мэдээллийг өгөх, нэр хүндийн эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалт мэдээллийг тогтмол өгдөг бөгөөд ажилтан бүр байгууллагын бизнес, үйл ажиллагаа, нэр хүндэд халдсан эсвэл учирч болзошгүй аюул занал байгааг илрүүлсэн, мэдсэн даруй өөрийн удирдлагад эсвэл Хууль, Эрсдэлийн удирдлагын газар болон Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх үүрэгтэй ба ингэснээр тухайн эрсдэлээс цаг алдалгүй сэргийлэх, бууруулах ач холбогдолтой.		
Стратегийн эрсдэл:	Гүйцэтгэх захирал нь ББСБ-ын эрхэм зорилго, үнэт зүйлсийн хүрээнд ББСБ-ын орлогын эх үүсвэрт эерэг, ашигтай байх бизнес төлөвлөгөө болон холбогдох		

шийдвэрийг гаргана. Гэвч эдийн засгийн, зохицуулагч байгууллагын эсвэл орсолдөөний зэрэг серөг нөлөөллүүд нь алдагдалд хүргэж болзошгүй байдаг тул стратегийн эрсдэлийг бүрэн бууруулах боломжгүй байдаг. Стратегийн голлох шийдвэрийг хянан үзэх, сорих, батлах, Стратегийн үндсэн шийдвэрүүд болон шийдвэр гаргах үйл явцын талаар Гүйцэтгэх захирал болон удирдлагын багт санал, зөвлөмж өгөх нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг байна.		
Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн засаглал нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:		
✓ Хамгаалалтын гурван бүс буюу эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого
✓ Засаглалын бичиг баримтууд буюу эрсдэлийн удирдлагын бодлого, холбоглох эрсдэлүүдийг удирдах ерөнхий журмууд болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журам, стандарт болон заавар.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого
✓ Засаглалын хороод буюу ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих хороод.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого
Хамгаалалтын гурван бүс буюу эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий одор тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь дараах байдлаар хуваарилагдсан байна.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого

Эрсдэлийн торол	Хамгаалалтын I бүс	Хамгаалалтын II бүс	Хамгаалалтын III бүс
Зээлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	Дотоод аудитын газар, Төлөөлөн удирдах зөвлөл
Зээлийн төвлөрлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Зах зээлийн эрсдэл	Санхүү хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Өөрийн хөрөнгийн эрсдэл	Санхүү хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Хөрвөх чадварын эрсдэл	Санхүү хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж	
Үйл ажиллагааны эрсдэл	Бизнес/ Арын албаны нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж	

	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлого

Аюулгүй байдлын эрсдэл	Бизнес/ Арын албаны нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж		
Ёс зүйн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Хуулийн нэгж		
Хянан нийцүүлэлтийн эрсдэл	Бизнес/ Арын албаны нэгжүүд	Хуулийн нэгж		
Нэр хүндийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж		
Стратегийн эрсдэл	Гүйцэтгэх захирал	Төлөөлөн удирдах зөвлөл		

Засаглалын бичиг баримтууд буюу эрсдэлийн удирдлагын бодлого, журмууд:

№	Эрсдэлийн бодлого, журмууд	Хариуцах эзэн	Батлах эрх бүхий хороо		
1	Эрсдэлийн удирдлагын бодлого	Хууль, эрсдэлийн удирдлагын газар	Төлөөлөн удирдах зөвлөл	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам.
2	Зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам / Зээлийн төвлөрлийн эрсдэл багтсан/	Хууль, эрсдэлийн удирдлагын газар	Удирдлагын хороо		
3	Зах зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам	Санхүү газар			
4	Өөрийн хөрөнгийн эрсдэлийг удирдах ерөнхий журам	Санхүү газар			
5	Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах ерөнхий журам	Санхүү газар			
6	Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах ерөнхий журам болон үйл ажиллагааны журам	Хууль, эрсдэлийн удирдлагын газар			
7	Аюулгүй байдлын эрсдэлтэй холбоотой журам, зааврууд	Үйл ажиллагааны газар, Мэдээлэл, технологийн газар			
8	Ёс зүйн эрсдэлтэй холбоотой журам, зааврууд	Хууль, эрсдэлийн удирдлагын газар			
9	Хянан нийцүүлэлтийн эрсдэлтэй холбоотой журам, зааврууд	Хууль, эрсдэлийн удирдлагын газар			

1.9

1.9. Санхүүгийн Тайлан

Санхүүгийн мэдээлэл

График 1.9-1 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, тэрбум төгрөг



Санхүүгийн мэдээлэл



График 1.9-2 Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа, тэрбум төгрөг		
	Санхүүгийн мэдээлэл	
Хүснэгт 1.9-1 Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн орлогын тайлан		
Хүснэгт 1.9-2 Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	Санхүүгийн мэдээлэл	
"Инвескор ББСБ" ХК нь СЗХ-ны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай" 85 дугаар тогтоолын дагуу нийт 8.2 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг биржийн бус зах зээл дээр амжилттай гаргаж арилжаалсан бөгөөд хүүгийн болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу төлж байна.	Үнэн зөв	СЗХ-ны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай" 85 дугаар тогтоол
Хүснэгт 1.9-3 Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн мөнгөн урсгалын тайлан	Санхүүгийн мэдээлэл	

1.10	**1.10. Санхүүгийн Тайланд Хийсэн Аудитын Дүгнэлт**	Үнэн зөв	Аудитын Дүгнэлт
	“БДО Аудит” ХХК		Аудитын Дүгнэлт
	“Инвескор ББСБ” ХК болон түүний охин компаниудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланд “БДО Аудит” ХХК нь аудит хийж, дүгнэлт гаргасан бөгөөд мөн Үнэт цаас гаргахтай холбоотойгоор Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд заасны дагуу дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийн дагуу Үнэт цаас гаргагчийн 2019 оны 12 сарын 31-ний одрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь “Инвескор ББСБ” ХК-ийн 2019 оны аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэлтэй тохирч байна хэмээн дүгнэсэн байна. Аудитын компанийн дүгнэлт болон Үнэт цаас гаргагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланг танилцуулгад хавсаргасан болно.	Үнэн зөв	Аудитын Дүгнэлт
1.11	**1.11. Их Хэмжээний Хэлцэл, Түүний Хэрэгжилт**		
	Хүснэгт 1.1.11-1.1: Үнэт цаас гаргагчийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэл /2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар/		

№	Гэрээний тал	Утга	Гэрээний огноо	Тайлбар	Хэрэгжилтийн явц	Үнэн зөв	Гүйцэтгэх захирлын баталгаа
1	Байгууллага	Зээлийн эрх нээх үндсэн гэрээ	2017.03.30	"Инвескор ББСБ" ХК нь өөрийн хувьцаа эзэмшигч хэрэгжиж байгаа болох “Эс Ай Би Жэй	Одоо хүчин төгөлдөр бөгөөд Зээлдэгч нь		

				Капитал" ХХК-иас 25 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг жилийн 19 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай, бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар нээлгэж авсан байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл хийх журам, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	зээлийн хүүг хуримтлуулж тооцон үндсэн төлбөртэй хамт зээлийн хугацааны эцэст төлнө.		
2	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2017.11.09	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 58 сая иенийг 48 сарын хугацаатай. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт толно.		
3	Байгууллага	Зээлийн гэрээ	2018.08.17	Үнэт цаас гаргагч нь Зээлийн гэрээний дагуу 30 сая иенийг зээлийг 3 жилийн хугацаатай, хүүг сар бүр төлөх хуваарьтайгаар зээл олгосон.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.		

				Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	
4	Иргэн	Зээлийн гэрээ	2019.06.06	Үнэт цаас гаргагч нь Зээлийн гэрээний дагуу 1.3 сая ам.долларын зээлийг 1 жилийн хугацаатай, сар бүр төлөх хуваарьтайгаар олгосон. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа боговод Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.
5	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ	2019.06.13	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 900 сая төгрөгийг 2 жилийн хугацаанд итгэмжлэн удирдана.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг огоожийн хамт толно.

		(Итгэлцлийн үйлчилгээ)		Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.		
6	Байгууллага	Зээлийн гэрээ	2019.06.20	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 1.4 сая ам долларыг 2 жилийн хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.	
7	Байгууллага	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2019.08.29	Үнэт цаас гаргагч нь 520 мянган ам долларыг 36 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.	
8	Байгууллага	Биржийн бус зах зээлд үнэт цаас	2020.04.06	Үнэт цаас гаргагч нь 10 тэрбум төгрөгийн биржийн бус зах зээлд үнэт цаас	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Худалдагч нь	

		худалдах, худалдан авах		худалдах, худалдан авах гэрээ хийсэн. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Үнэт цаас гаргагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа болно.		
9	Байгууллага	Зээлийн эрх нээх гэрээ	2020.03.04	"Инвескор ББСБ" ХК нь Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан Зээлийн эрх нээх гэрээ болон Зээлийн эрх нээх нэмэлт гэрээний дагуу нийт 1.9 тэрбум төгрөгийг жилийн 19.2 хувийн хүүтэй зээлэх зээлийн эрх нээлгэсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд зээлийн толборийн үлдэгдэлгүй.		
10	Иргэн	Хоронго итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.04.24	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 300,000 ам.долларыг 12 сарын хугацаанд итгэмжлэн удирдана.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.		

				Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.		
11	Байгууллага	Зээлийн гэрээ	2020.07.01	Үнэт цаас гаргагч нь Зээлийн гэрээний дагуу 4.8 тэрбум төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, хүүг улирал бүр төлөх хуваарьтайгаар олгосон. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.	
12	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.07.06	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 900 сая төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг огоожийн хамт төлнө.	

000294

13	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.07.17	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 6.5 тэрбум төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.		
14	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.09.03	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 2 тэрбум төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа богоод хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.		
15	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.09.04	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 1.1 тэрбум төгрөгийг 24 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа богоод хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.		
16	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн	2020.09.09	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 2.4 сая ам долларын	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст		

			удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.	итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.		
17	Иргэн	Зээлийн гэрээ	2020.09.21	Үнэт цаас гаргагч нь Зээлийн гэрээний дагуу 1.5 тэрбум төгрөгийн зээлийг 24 сарын хугацаатай, хүүг сар бүр төлөх хуваарьтайгаар олгосон. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.		
18	Иргэн	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Итгэлцлийн үйлчилгээ)	2020.09.24	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр 10 тэрбум төгрөгийг 6 сарын хугацаанд итгэмжлэн удирдана. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд хугацааны эцэст итгэлцэлд байршуулсан дүнг өгөөжийн хамт төлнө.		

				үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарна.			
19	Байгууллага	Зээлийн гэрээ	2020.11.06	Үнэт цаас гаргагч нь Зээлийн гэрээний дагуу 491 мянган ам. доллар зээлийг 3 сарын хугацаатай, хүүг сар бүр толох хуваарьтайгаар олгосон. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын зорчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.	Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Зээлдэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлж байгаа.		
20	Байгууллага	Хөрөнгө Худалдах, худалдан авах гэрээ	2020.12.25	Үнэт цаас гаргагч нь 9.95 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл бүхий Зээлийн хөрөнгийг худалдан авах тухай гэрээ байгуулсан. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарах ба тус хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан сонирхлын	Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Худалдагч нь Үнэт цаас гаргагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа болно.		

	зорчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн.		
1.12	**1.12. Холбоотой Этгээдүүдийн Талаарх Мэдээлэл** Үнэт цаас гаргагчийн толгой, охин болон хараат компанийн тухай мэдээлэл болон тэдгээрийн холбоо хамаарлыг нотлох холбогдох баримтуудыг Хуулийн дүгнэлтийн 7 дугаар хэсэгт тусган оруулсан болно.		
	"Инвескор Хэтэвч ББСБ" ХХК /Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани/	Үнэн зөв	"Инвескор хэтэвч ББСБ" ХХК,-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
	"Покет" аппликэйшн нь харилцагчдад бичил зээлийг 24/7-ийн турш санал болгох бөгөөд мөн цахим хэтэвч болон төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. 2020 оны 3-р улирлын эцсийн байдлаар 40 мянган харилцагчийн 7.3 тэрбумын зээлийн багцтай байна.	Андеррайтерийн шинжилгээ	
	"Покет КГ" ХХК /Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани/	Үнэн зөв	Покет КГ (Киргиз) гэрчилгээ
	Компани нь 2020 оны 8-р сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд Киргиз Улсын зах зээлд "Покет" цахим хэтэвчийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.	Андеррайтерийн шинжилгээ	
	"Золотой Стандарт" МКК /Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани/	Үнэн зөв	Золотой стандарт МКК (Киргиз) гэрчилгээ
	Худалдаа, ходоо аж ахуйн салбарын жижиг бизнес эрхлэгчдэд чиглэсэн банк бус санхүүгийн байгууллага бөгөөд 2020 оны 3-р улирлын эцсийн байдлаар 199 харилцагчтай, 1.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн багцтай байна.	Андеррайтерийн шинжилгээ	
	"Инвескор Лизинг" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/	Үнэн зөв	"Инвескор лизинг" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
	2017 онд байгуулагдсан бөгөөд автомашин, үл хөдлөх хөрөнгө, тоног тохооромжийн түрээс болон санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхэлдэг. Галаадад амьдардаг Монгол иргэддээ зориулсан орон сууцны уян хатан нөхцөл бүхий лизингийн үйлчилгээг нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.	Андеррайтерийн шинжилгээ	

СЭХ
2021 оны 2 тедер
БҮРТГЭВ
№ 01
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦТ" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР ББСБ" ХХК
InvesCore
6069854 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000298

“Инвескор Капитал ҮЦК” ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/	Үнэн зөв	“Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
2018 онд байгуулагдсан брокер, андеррайтер, зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч компани юм. 5 ажилтантай бөгөөд 2019 онд “Инвескор ББСБ” ХК-ийн IPO-г амжилттай зохион байгуулсан бөгөөд дотоодын 400, гадаадын 20 харилцагчтай.	Андеррайтерийн шинжилгээ	
“Инвескор Фанд” ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/	Үнэн зөв	"Инвескор фанд" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
2019 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгө оруулалт зуучлал, краудфандинг платформын үйл ажиллагаа эрхэлж байна. Платформын бэлтгэл ажлууд бүрэн хангагдаж зах зээлд нэвтрүүлэхэд бэлэн болсон.	Андеррайтерийн шинжилгээ	
“Инвескор Проперти” ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/	Үнэн зөв	"Инвескор Проперти" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
2017 онд байгуулагдсан тус компани нь Монголын үл хөдлөх хөрөнгийн менежментийн чиглэлээр тэргүүлэгч компаниудын нэг юм. Нийт 25 ажилтантай бөгөөд дараах төслүүдийн борлуулалт, менежментийн үйл ажиллагааг гүйцэтгэдэг. ✓ Амбассадор Резиденс / VIP тансаг зэрэглэлийн орон сууц / ✓ Pro One / үйлчилгээтэй оффис / ✓ Хоймор /оффис /	Андеррайтерийн шинжилгээ	
“Инвескор Жапан” ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/	Үнэн зөв	"Инвесзор Жапан" ХХК-ийн гэрчилгээ
2019 онд байгуулагдсан бөгөөд Инвескор Санхүүгийн Группт санхүүгийн зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалт босгох үйлчилгээг үзүүлдэг. Түүнчлэн компани нь Япон Улс дахь “Инвескор ББСБ” ХК-ийн төлөөлөгчөөр ажиллаж, боломжит хөрөнгө оруулагчид, болон түншүүдтэй харилцаа тогтоож байна.	Андеррайтерийн шинжилгээ	
“Инвескор Эй Ай Лаб” ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/	Үнэн зөв	"Инвескор Эй Ай Лаб" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм

	2018 онд байгуулагдсан бөгөөд хиймэл оюун ухаанд суурилсан программ хангамж боловсруулах, санхүүгийн бүх төрлийн системүүд хөгжүүлэх, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь дараах системүүд болон Финтекийн шийдлүүдийг амжилттай боловсруулсан. 2020 оны хагас жилийн байдлаар 21 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Гол бүтээлүүд: ✓ SMART LOS систем (зээлийн эх үүсвэр, зээлийн үнэлгээ, зээл батлах, зээлийн хяналт тавих систем) ✓ ПОКЕТ систем (онлайн зээлийн болон санхүүгийн үйлчилгээний бүрэн автоматжуулсан платформ) ✓ Японы хиймэл оюун ухааны хөгжүүлэгч Libera Inc.-тай хамтран хиймэл оюун ухаан дээр суурилсан зээлийн үнэлгээний систем ✓ "Инвескор Фанд" ХХК-д зориулсан краудфандинг ба P2P зээлийн платформ ✓ "Инвескор" ББСБ ХК-ийн бусад системүүдийн интеграци	Андеррайтерийн шинжилгээ	
	"Коло Тинкинг" ХХК /Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани/	Үнэн зөв	"Коло Тинкинг" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
	2020 онд байгуулагдсан бөгөөд мэргэжлийн дизайн, гэрэл зураг, маркетинг, сурталчилгааны чиглэлээр ажилладаг. Инвескор групп, Инвескор ББСБ ХК-ийн вэбсайт болон Покет аппликэйшний дизайныг хөгжүүлсэн.		
	1.13. Үнэт цаас гаргагчийн Ногдол Ашгийн Бодлого		
	Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулсан бөгөөд уг бодлогыг ТУЗ-ийн 2019 оны 2-р сарын 4-ний өдрийн А/05-Т тоот тогтоолоор баталсан байна.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн ногдол ашгийн бодлого
	"Инвескор ББСБ" ХК-ийн ногдол ашгийн боллогоор ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн ногдол ашгийн бодлого
	Ногдол ашиг хуваарилах нохцол		

	Үнэт цаас гаргагч нь дор дурдсан нөхцөл бүрэн хангагдаж байгаа тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд: ✓ Ногдол ашиг төлсний дараа Үнэт цаас гаргагч толбөрийн чадвартай байх, Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байх; ✓ Ногдол ашиг төлсний дараах Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, Үнэт цаас гаргагчийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх; ✓ Үнэт цаас гаргагч хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авах шаардагдах хөрөнгөтэй байх; ✓ Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал нь Үнэт цаас гаргагчийн тогтвортой үйл ажиллагааг хангахуйц байх;	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2
	Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах		
	Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан, санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. Хэрэв Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай гайлбар өгнө.	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн ногдол ашгийн бодлого
	Ногдох ашиг хуваарилах Үнэт цаас гаргагч хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үндэслэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-өөс гаргах ба ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлийг тусгана. Үүнд: ✓ Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ; ✓ Ногдол ашиг олгох хэлбэр; ✓ Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр; ✓ Ногдол ашиг төлөх өдөр; ✓ Бусад холбогдох асуудал	Үнэн зөв	"Инвескор ББСБ" ХК-ийн ногдол ашгийн бодлогын 3.1, 4.1
	Тайлагнах		
	Үнэт цаас гаргагч ногдол ашиг хуваарилсан талаар Нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмын дагуу санхүүгийн тайланд үнэн зөвөөр тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилалтын тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14-т заасны дагуу ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж,		

	тогтсон хугацаанд Хороо болон Биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.		

0003332

2	**ХОЁР. ЗАХ ЗЭЭЛ**		
2.1	**2.1 Макро Эдийн Засгийн Төлөв Байдал**		
	Эдийн засгийн осолт		
	Монгол Улсын хувьд 2020 оны 11 сар хүртэл Ковид-19 вирусын тархалтыг дотоодоо алдаагүй амжилттай хамгаалсан боловч ДНБ 2020 оны 3-р улирлын байдлаар -7.3%-аар агшсан үзүүлэлттэй байна.	Андеррайтерийн шинжилгээ	
	График 2.1-1 Бодит ДНБ: жилийн өөрчлөлт		
		Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Монголбанк, Asian Development Outlook 2020 (ADB)	
	Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Монголбанк, Asian Development Outlook 2020 (ADB)		
	Үндсэн шалтгаан нь Ковид-19 цар тахал анх БНХАУ-д дэгдсэн тул хил хааж, хөл хорио тогтоосон нь нүүрсний экспортыг саатуулсан бөгөөд голлох түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр буурсан. Жишээ нь 2020 оны 1 дүгээр улиралд Монгол Улсын төсвийн орлогын 15 хувийг бүрдүүлдэг зэсийн үнэ 6,300-аас 5,700 ам.доллар болж 10.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.mongolbank.mn/documents/sanhuugintb/FSC_report_202008.pdf 4-р хуудас	
	Үүнээс гадна бөөний болон жижиглэн худалдааны нийлүүлэлт буурч, хүнсний бус худалдааны салбар, үзвэр үйлчилгээний салбаруудын орлого тасалдах болсон. Ийнхүү 2020 оны эхний хагас жил гэхэд банкны салбарт нийт	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.mongolbank.mn/documents/sanhuugintb/FSC_report_202008.pdf 5-р хуудас	

126 мянган зээлдэгчийн 1.8 их наяд төгрөг, ААН-ийн 2,672 зээлдэгчийн 3.1 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүсээд байна (Монголбанк).	
2020 оны 11 сард дотооддоо Ковид-19 вирусын халдварыг алдсанаас шалтгаалж Улаанбаатар хот болон зарим аймгуудад хөл хорио тогтоосон.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.legalinfo.mn/law/details/15717?lawid=15717 https://www.legalinfo.mn/law/details/15746?lawid=15746 https://www.legalinfo.mn/law/details/15770?lawid=15770 https://www.legalinfo.mn/law/details/15803?lawid=15803
Иймд Монголбанк 2020 оны эдийн засгийн агшилтыг -2.6%-р гэж тооцоолж байсан бол -5.4 хувь болгож өөрчилжээ. Харин 2021 онд эдийн засаг 5.1 хувиар өсөх боломжтой гэж Монголбанк тооцоолсон байна. Судлаачдын таамаглаж буйгаар Монгол Улсын хувьд эдийн засгийн сэргэлт харьцангуй хурдан байх боломжтой бөгөөд гол хүчин зүйлүүднь нүүрс, зэс, алтны экспорт, дотоодын хэрэглээ, хувийн секторын өсөлт байна.	Андеррайтерийн шинжилгээ
Мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүү	
График 2.1-2 Бодлогын хүү (%)	
	Монголбанк, Төв банкны үйл ажиллагааны статистик
Эх сурвалж: Монголбанк, Төв банкны үйл ажиллагааны статистик	

Монголбанк 2020 оны 11-р сард бодлогын хүүг 8-аас 6 хувь хүртэл бууруулсан нь 2007 оноос энэхүү хэрэгслийг хэрэглэх болсноос хойш түүхэн тоод түвшин юм. Түүнчлэн төгрөгийн заавал байлгах ёстой нөөцийн хэмжээг 2.5 хувиар бууруулж 6 хувь болгосон байна. Энэ нь цар тахлын үед банк болон санхүүгийн байгууллагын салбарт зах зээлийн мөнгөний урсгалыг сайжруулах мөн учирч болзошгүй эрсдэлийг зөөлрүүлэх зорилготой юм. 2016 оноос хойш идэвхтэй бодлогын хүү буурч байгаа бөгөөд үүнтэй адилтгаж зээл болон хадгаламжийн хүү буурсаар байна. Хадгаламжийн хүү буурснаар иргэд болон ААН-үүдийн хувьд хорогийн зах зээлийн бүтээгдэхүүнүүдийг илүү сонирхож эхэлж байна. Мөн, зээлийн хүү буурснаар зах зээлийн мөнгөний эргэлт ихсэж, санхүүгийн өсөлтийг дэмжих болон тогтворжуулахад том нөлөө үзүүлэх юм.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.mongolbank.mn/news.aspx?id=2681&tid=1 https://www.mongolbank.mn/news.aspx?id=2663&tid=1
График 2.1-3 Мөнгөний нийлүүлэлт	
	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	
2021 онд мөнгөний нийлүүлэлт дунджаар 20%-р өсч 26.9 их наяд төгрөгт хүрнэ гэж таамаглаж байна. Мөнгөний тэлэх бодлогын үр дүнд арилжааны банкнуудын зээл, хадгаламжийн хүү буурах мөн төгрөгийн ханшид сулрах нөлөөлөл үзүүлэхээр байна.	Андеррайтерийн шинжилгээ
Монголбанк уул уурхайн бус экспортын болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжихэд зориулсан урт хугацаат санхүүжилт олгох зорилгоор 2 жилийн хугацаатай репо арилжааг зарлахаар шийдвэрлэсэн ба 2020 оны 4-р улиралд нийт 230 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкнуудад олгохоор шийдвэрлэсэн байна.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.mongolbank.mn/news.aspx?tid=1&id=2691

Төлбөрийн тэнцэл		
График 2.1-4 Нийт тэнцэл, сая ам.доллар		
	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	
Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан		
Оны эхнээс 3-р улирлын эцэс гэхэд нийт төлбөрийн тэнцэл 804 сая ам.долларын алдагдалтай болсон байна. 2021 онд гадаад худалдааны зөрэг тэнцлээс шалтгаалж төлбөрийн тэнцэл нэмэх утгатай гарах боломжтой байна. 2021 онд нийт 12 тэрбум ам.долларын урсгал орох, нийт 11.6 тэрбум ам.долларын урсгал гарах төлөвтэй байна.	Андеррайтерийн шинжилгээ	
Монгол Улсын нийт гадаад өр 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 30.8 тэрбум ам.доллар байгаа нь ДНБ-ий 234 хувийг эзэлж байна. 2021 онд төлөх Мазаалай бондын дийлэнх хэсгийг 2026 онд төлөгдөх жилийн 4.5% хүүтэй Номад бондоор дахин санхүүжүүлсэн тул 2021 онд төлөх өөр томоохон бондын төлбөр байхгүй байна.	https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0700_028V3&DEBT_select_all=0&DEBTSingleSelect=_1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202002&viewtype=table Андеррайтерийн шинжилгээ	
Арилжааны банк		
Цар тахалтай холбоотойгоор санхүүгийн зах зээлд арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад зээлийн нөхцөл өөрчлөх, хугацааг сунгах, мөн эргэн төлөлтийг хойшлуулах шаардлага тулгарсан. Хэдийгээр харилцагчдын хүсэлтээр зээлийн гэрээний хугацааг сунгаж үндсэн толборийг хойшлуулж байгаа ч гэсэн хугацаа	Андеррайтерийн шинжилгээ	

	хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувь нэмэгдэж байна. Арилжааны банкнуудын чанаргүй зээлийн хувь нь 2020 оны 9 дүгээр сарын байдлаар 11.4% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5%-иар ихэссэн үзүүлэлттэй гарсан байна.	
	График 2.1-5 Шинээр олгосон зээлийн ЖДХ (сараар)	
		Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо
	Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо	
	Арилжааны банкнуудын зээлийн багц 2020 оны 9 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар буурсан буюу 18.0 их наяд төгрөгөөс 17.2 их наяд төгрөг болсон байна. 2020 онд арилжааны банкнуудын дотоод Credit standard буюу Зээлийн шалгуур индекс илүү чангарсан гэж Монголбанк үзэж байна.	Андеррайтерийн шинжилгээ

000307

	График 2.1-6 Шинээр татсан хадгаламжийн Ж/ДХ (жилээр)		
		Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо
	Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо		
2.2	**2.2 ББСБ-ын Салбар**		
	Үндсэн үзүүлэлтүүд		
	ББСБ-ын салбар нь Монгол Улсын санхүүгийн сектор дотор хамгийн өндөр өсөлттэй яваа салбар юм. Сүүлийн 5 жилийн дотор ББСБ-ын салбарын нийт актив 2.4 дахин, зээлийн багц 3.1 дахин, өөрийн хөрөнгө 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа бол банкны салбар энэ хугацаанд 1.6 дахин, даатгалын салбар 2.2 дахин оссон үзүүлэлттэй байна.	Андеррайтерийн шинжилгээ	

График 0-1 ББСБ хороонго, зээл /тэрбум.төг/		
	Санхүүгийн зохицуулах хороо	
Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо		
ББСБ-ын салбарт Инвескор Хэтэвч ББСБ, "Ти Финанс ББСБ, Номор Кредит ББСБ, Мобифинанс ББСБ, Лэндмн ББСБ, Ашид Капитал ББСБ, Ард Кредит ББСБ зэрэг 15 компаниуд финтект суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчийн тоо огцом өсч 1.6 саяд хүрээд байна. Өөрөөр хэлбэл өмнө нь ББСБ-аар үйлчлүүлж байгаагүй харилцагчид технологид суурилсан шинэ бүтээгдэхүүнийг хэрэглэж, банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг болж байна.	Андеррайтерийн шинжилгээ	

График 0-2 ББСБ орлогын тайлан /тэрбум.төг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 0-1 ББСБ салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт, тэрбум ₮	2016		2017		2018		2019Q3		2020Q3	
Нийт актив	787.2	26%	969.2	23%	1,285	33%	1,629	27%	1,942	19%
Зээлийн багц	436.1	22%	582	33%	870	49%	1,169	34%	1,358	16%
Өөрийн хөрөнгө	578.5	36%	758.2	31%	977	29%	1,203	23%	1,377	14%
ББСБ тоо	518	15%	534	3%	539	1%	539	0%	533	-1%
Харилцагчийн тоо мян.	592	-7%	1471	148%	1,601	9%	2,330	46%	2,639	13%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хороо

2020 оны 3-р улирлын байдлаар нийт 533 ББСБ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 29, хөдөө орон нутагт 77, зөвхөн гадаад валютын эрхтэй 38 ББСБ байна. СЗХ-оос үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ болох 2.5 тэрбум төгрөгийг хангаж буй ББСБ одоогийн байдлаар 169 байна. ББСБ-уудыг нийт активын хэмжээгээр ангилж үзэхэд 5.0 тэрбумаас дээш активтай 62 ББСБ нь нийт зах зээлийн 56 хувийг эзэлж байна.

Андеррайтерийн шинжилгээ

	Зээлийн багц, чанар	Андеррайтерийн шинжилгээ
	2020 оны 3-р улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын зээлийн багц 1,358.0 тэрбум төгрөг байгаа ба зээлийн үлдэгдлийн 97.3 хувийг төгрөгөөр, 2.7 хувийг валютаар олгосон байна. 2020 оны 9 сарын байдлаар ББСБ салбарын нийт зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 43.9 хувиар өсч 551 мянгад хүрсэн байна. Цаг хугацаатай уралдаж үйл ажиллагаагаа явуулж байгаа жижиг лунд үйлдвэрлэл болон бизнес эрхлэгчдийн хувьд ББСБ нь зээлийн шийдвэрийг түргэн шуурхай гаргадаг учраас илүү эрэлт хэрэгцээнд нь нийцэж байна.	
	Олгосон зээлийн 90.1% буюу 1,082.1 тэрбум төгрөгийн зээлийг хувь хүнд, 9.9% буюу 118.3 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол төлөгдсөн зээлийн 91% буюу 989.2 тэрбум төгрөг нь хувь хүнээс, 9% нь буюу 97.7 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.	
	Нийт олгосон зээлийн 64.4% буюу 772.6 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлд, 11.9% буюу 142.9 тэрбум төгрөг нь худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 65.6% буюу 712.6 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлээс, 13.8% буюу 149.5 тэрбум төгрөг нь худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ. ББСБ-уудын жигнэсэн дундаж хүү нь 2016 оны 3-р улирлаас эхлэн тогтмол буурч байгаа ба 2020 оны 3-р улирлын байдлаар 2.9% байгаа ба банкны салбартай харьцуулахад 1.5 нэгжээр өндөр байна.	
2.3	**2.3 Бизнесийн Үйл Ажиллагааны Төсөөлөл**	
	"Инвескор ББСБ" ХК нь 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 21.3 тэрбум төгрөгийн хүүгийн цэвэр орлого, 13.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Харин 2021 онд цэвэр ашгийн дүнг 62%-р нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд зээлийн хүүгийн орлогоос гадна шинээр нэвтрүүлэх үйлчилгээнүүдийн шимтгэлийн орлого уг өсөлтийг бүрдүүлж байна.	Санхүүгийн мэдээлэл
	Хүснэгт 0-1 Орлогын тайлангийн төлөвлөгөө Өмнөх хэсэг дурдсан макро эдийн засгийн төсөөлөл дээр үндэслэн компанийн ухаалгаар тэлэх стратегийн үр дүнд нийт зээлийн багцын 2021 онд 60%-р өсгөх төлөвлөгөөтэй байна. Шинээр байгуулах салбаруудаа зорилтот харилцагчдын дэргэд байршуулж зах зээлээ тэлэх бол бүтээгдэхүүний хувьд хэрэглээний зээлээ автоматжуулж, бизнесийн зээл рүү илүү хүн хүчээ чиглүүлнэ. Мөн орон нутгийн зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана. Зээлийн багцын өсөлтийг эрсдэлийн удирдлагын зөв бодлого, аргачлалуудтай хослуулан хэрэгжүүлснээр зээлийн чанарыг бууруулахгүй, цаашид одоо байгаа түвшнээс сайжруулах болно.	Санхүүгийн мэдээлэл

СЭХ
БҮРТГЭВ
2021-02-27
№ 01

	Хүснэгт 0-2 Санхүүгийн байдлын тайлангийн төловлогоо **Хүснэгт 0-3 Мөнгөн гүйлгээний тайлан**	Санхүүгийн мэдээлэл	
3	**ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ**		
3.1	**3.1 Үнэт Цаас Гаргах Үндэслэл / Зорилго**		
	"Инвескор ББСБ" ХК нь харилцагч параа урт хугацаатай, тогтвортой санхүүжилтээр хангах, санхүүгийн найдвартай түнш, дэмжигч нь байх эрхэм зорилгын хүрээнд бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэх шаардлагатай болдог. Үнэт цаас гаргагч нь зах зээлийн нөхцөл байдал, өөрийн санхүүгийн үзүүлэлт, дотоод нөөц бололцоо зэргийг үндэслэн үнэт цаас гаргах шийдвэрийг гаргасан бөгөөд уг үнэт цаас гаргалт нь компанийн зээл олголт болон ашигт ажиллагааг нэмэгдүүлж, харилцагчид болон хөрөнгө оруулагчдад үнэ цэнэ бий болгоно гэж үзсэн..	Андеррайтерийн шинжилгээ	
3.2	**3.2 Үнэт Цаасны Нохцол** "Инвескор ББСБ" ХК нь дараах нөхцөл бүхий нээлттэй өрийн хэрэгсэл буюу үнэт цаас гаргах хөтөлбөрийг Монголын Хорөнгийн Бирж дээр олон нийтэд санал болгож хэрэгжүүлнэ.	Үнэн зөв	ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/31-Т тоот Үнэт цаас нээлттэй гаргах тухай тогтоол

Бондын бүртгэл	Монголын Хөрөнгийн Бирж		
Бондын төрөл	Энгийн хүүтэй бонд		
Бондын арилжаа	Олон нийтэд		
Хотолборийн нийт үнийн дүн	20.0 тэрбум төгрог		
Нэгж бондын нэрлэсэн үнэ	100,000 төгрог		
Нийт тоо, ширхэг	200,000 ширхэг		
Анхдагч зах зээлд хэсэгчлэн гаргаж арилжаалах хуваарь	Транч 1	Транч 2	Транч 3
Хугацаа	2021 оны 3 сар	2021 оны 5 сар	2021 оны 8 сар
Дүн	MNT 8 тэрбум	MNT 6 тэрбум	MNT 6 тэрбум
Бондын хугацаа	24 сар		

0003 2

2021-02-03

	Бондын хүү	14%		Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.5 болон 23.1, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.5, Хувьцаа барьцааны гурван талт гэрээ
	Хүү төлөх хугацаа	Хагас жил тутам		
	Бондын эргэн төлөлт	Хугацааны эцэст		
	Бондын зарцуулалт	Компанийн эргэлтийн хөрөнгө, зээлийн үйл ажиллагаанд зарцуулах		
	Бондын барьцаа/эргэн төлөлт	Толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй Үнэт цаас гаргагчийн 8,000,000 ширхэг энгийн хувьцаа нь бондын барьцаа болно. Үнэт цаас гаргагчийн хүү, шимтгэлийн орлого болон харицагчдад олгосон зээлийн үндсэн төлбөр нь бондын эргэн төлөлт болно.		
	Бондын хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ТӨХХК		
	Бусад давуу талууд	МХБ-н хоёрдогч зах зээл дээр бусад этгээдэд худалдан борлуулах боломжтой Хүүгийн орлогын албан татвар 5%		
	**Дээрх нөхцөл нь Хөтөлбөрийн танилцуулга хийгдэх үеийн төлөвлөгөө бөгөөд үнэт цаас гаргах үед өөрчлөлт орох боломжтой*		Үнэн зөв	Андеррайтерийн мэдэгдэл
3.3	**3.3 Үнэт Цаасны Үнэ, Хүүгийн Түвшин Тогтоосон Үндэслэл**			
	Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад санал болгох Компанийн бондын өгөөж буюу хүүгийн түвшнийг зах зээлийн хүүгийн түвшин, компанийн нэр хүнд, санхүүгийн үзүүлэлттэй уялдуулан тогтоосон.		Андеррайтерийн шинжилгээ	
	2020 оны 3 сард Монголбанкны бодлогын хүү 11%-с 10%, 4 сард 9%, 9 сард 8%, 11 сард 6% болж буурсан мөн үүнтэй уялдан арилжааны банкуудын хадгаламжийн хүү буурсан тул Инвескор Бондын хүүг өмнө гарч байсан нөхцөлтэй бондуудтай харьцуулах боломжгүй байна. Харин 2020 оны 11 сарын байдлаар томоохон 5 арилжааны банкны 24 сарын хугацаатай хадгаламжийн жилийн дундаж хүү нь 10.5% байгаа бөгөөд Инвескор Бондын хувьд уг дундаж хүүний түвшингээс 3.5 нэгжээр илүү байна.			

График 3.3-1 Банкуудын 2 жилийн хугацаатай иргэдийн хадгаламжийн хүү (жилээр)



Эх сурвалж: Тухайн банкуудын вэб сайт

Хүүгийн орлогын албан татварыг тооцож үзвэл арилжааны банкуудын хадгаламжийн дундаж хүү цэвэрээр 9.1% бол Инвескор бондынх 13.3% буюу зөрүү нь 4.2 нэгж байна.

"Инвескор ББСБ" ХК-ийн хувьд хөрөнгө оруулагчдад санал болгох өгөөжийн хэмжээг зах зээл дээр өрсөлдөхүйц байлгах мөн төр болон хувийн хэвшлийн зүгээс хэрэгжүүлж буй зээлийн хүүг бууруулах санал, арга хэмжээнүүдийг судалж үзсэний үндсэн дээр уг хүүгийн хувийг тогтоосон болно.

Андеррайтерийн шинжилгээ

Үнэт цаасны зах зээл – бусад үнэт цаасны судалгаа

2020 оны 12 сарын байдлаар Монголын Хөрөнгийн Биржийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээл идэвхтэй санал болгосон үнэт цаас байхгүй байна. Харин хоёрдогч зах зах зээл дээр 2020 оны 6 сард "ЛэндМн ББСБ" ХК-ийн гаргасан "Лэнд Бонд" арилжаалагдаж байна.

Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://lend.mn/postdynamic.html?article=3125358442175551753

Хүснэгт 3.3-1 МХБ дээр нээлттэй арилжаалагдсан өрийн хэрэгслүүд (сүүлийн 5 жил)

Компанийн нэр	Гаргасан огноо	Хугацаа	Жилийн хүү	Бодлогын хүү	Зөрүү	Нийт дүн, тэрбум ₮
Эрчим Инженеринг	2015	1 жил	18.5%	13%	5.5%	0.5
Сүү ХК	2017.06.19	1 жил	17.5%	12%	5.5%	6.0
ЛэндМН ББСБ ХК	2020.05.29	1 жил	17%	9%	8%	5.0

Андеррайтерийн шинжилгээ

Инвескор ББСБ ХК	2021	2 жил	14%	6%	8%	20.0	

Монголын Хөрөнгийн Бирж дээр гарсан нээлттэй бондууд нь эдийн засаг, зах зээлийн өөр өөр нөхцөл байдалд гарсан тул бодит хүүгийн түвшнийг тухайн үеийн бодлогын хүүтэй харьцуулж тооцлоо. Эндээс харахад бодит хүүгийн хувь 8% буюу бусад бондуудаас харьцангуй өндөр, "ЛэндМН ББСБ" ХК-тэй адил түвшинд байна.

Хаалттай бондуудын хүү нь зах зээлийн зарчмаар нээлттэй бондуудаас бага зэрэг өндөр байдаг. Учир нь нээлттэй бонд нь доорх давуу талуудтай юм.

- ✓ Хүүгийн орлогын албан татварын хөнгөлөлт (нээлттэй бонд 5%, хаалттай бонд болон хадгаламж 10%);
- ✓ Хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжаалах буюу эрхээ шилжүүлэх боломж;
- ✓ Хууль, журмын дагуу зохицуулалттай;
- ✓ Хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зохицуулалттай;

"Инвескор ББСБ" ХК-ийн олон нийтэд санал болгож буй өрийн хэрэгсэл нь доорх ялгарах онцлог, давуу талуудтай байна.

- ✓ Төлөвлөгөөний дагуу хөтөлбөр хэлбэрээр, 3 транчид хуваарилагдах тул хөрөнгө оруулагчид өөрийн боломжтой үедээ оролцох боломжтой;
- ✓ Зах зээлийн хүүгийн хувь хэмжээ цаашид улам бүр буурах нөхцөл байдалд 2 жилийн турш тогтмол өгөөж хүртэх боломж;
- ✓ "Инвескор ББСБ" ХК-ийн онцгой амжилт, ирээдүйн өсөлт, хөгжлөөр эргэн төлөлт баталгаажсан;
- ✓ Хамгийн өндөр өсөлттэй, хөрвөх чадвар өндөртэй нээлттэй компанийн хувьцаа нь өрийн хэрэгслийн барьцаа болно;
- ✓ "Инвескор ББСБ" ХК болон Андеррайтерийн хувьд өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхтэй байлгах арга хэмжээнүүдийг МХБ болон СЗХ-тай хамтран хэрэгжүүлнэ;
- ✓ Хүүг хагас жил тутам авах боломжтой;

Андеррайтерийн шинжилгээ

3.4 Татан Төвлөрүүлэх Хөрөнгийн Зарцуулалт

"Инвескор ББСБ" ХК-ийн нээлттэй орийн хэрэгслийн хөтөлбөрийн хүрээнд татан төвлөрүүлэх хөрөнгийг компанийн үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Андеррайтерийн шинжилгээ

Дэлхийн тэргүүлэх эмийн үйлдвэрүүд Ковид-19 вирусын эсрэг вакциныг амжилттай бүтээж баглуулснаар улс орнуудад эдийн засгийн V болон U хэлбэртэй сэргэлтүүд гарах боломж бүрдээд байна.		
"Инвескор ББСБ" ХК нь 2021 оны Монгол улсын эдийн засгийн төсөөллийг оодрөгөөр харж байгаа бөгөөд бизнес эрхлэгч харилцагч нараа урт хугацаатай тогтвортой эх үүсвэрээр хангаж үйл ажиллагааг нь дэмжих зорилт тавьж ажиллана.		
Хүснэгт 3.4-1 Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт		Андеррайтерийн шинжилгээ

Зээлийн бүтээгдэхүүн	Эзлэх хувь	Дүн, тэрбум ₮
Бизнессийн зээл	55%	11.0
Хэрэглээний зээл	45%	9.0
Нийт	100%	20.0

Нийт 11 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Бизнесийн зээлийн багцад байршуулах бөгөөд үүний тулд доорх ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Бизнесийн зээлийн багцын гол өсөлтийг жижиг, дунд сегментийн зорилтот харилцагч нарт олгох зээлийн багцаар бүрдүүлнэ.
- SMB (Сэмбий) хөтөлбөрийн хүрээнд зорилтот буюу дэмжих салбарын бизнес эрхлэгч нарт хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгоно.
- Зээлийн батлан даалтын сан болон Тогтвортой санхүүгийн холбоотой хамтран ажиллаж барьцаа хөрөнгийн лутагдалтай, үйл ажиллагаа тогтворжсон харилцагч нарт бизнесийн зээл олгоно.
- Ногоон зээл, ногоон санхүүжилтийн санаачилгыг дэмжиж зээлийн багцыг бүрдүүлнэ.
- Инвескор Аллианс хөтолборт нэгдсэн ББСБ-уудад зээлийн шугам нээж орон нутгийн бизнес эрхлэгч нарыг дэмжинэ.

Нийт 9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хэрэглээний зээл бүтээгдэхүүнд байршуулахын тулд доорх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Киоск төхөөрөмжөөр дамжуулан лизингийн болон цалингийн зээлийг зорилтот харилцагч нарт түргэн шуурхай олгоно.

- Шинээр цахим салбар байгуулж хэрэглээний, лизингийн зээл олголтыг дэмжих ба холбогдох процессуудыг автоматжуулна.

	- Кредит карт бүтээгдэхүүнийг арилжааны банк болон "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК-тай хамтарч зах зээлд шинээр байршуулна.		
	- Итгэлцэл барьцаалсан зээлийн багцын борлуулалтыг нэмэгдүүлж мобайл аппликэйшнээр дамжуулж олгоно.	Андеррайтерийн шинжилгээ	
	- Орон сууц, автомашин барьцаалсан шуурхай зээлийн судалгааг хялбаршуулан хийж, шийдвэр гаргалтын хурдаа нэмэгдүүлнэ.		
	- Гар утасны дугаар барьцаалсан зээлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, үйлчилгээний нөхцөлийг шинэчилж гаргана.		
	- Хосолмол болон цахилгаан хөдөлгүүртэй, зөв талдаа хүрдтэй автомашины хэрэглээг дэмжиж автомашины импортлогч болон хэрэглэгч байгууллагуудтай хамтран ажиллана.		
3.5	**3.5 Үнэт Цаасны Эргэн Төлөлтийн Эх Үүсвэр**		
	Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг өөрийн зээлийн бүтээгдэхүүний хүү, шимтгэлийн орлого болон үндсэн толбороор эргүүлэн толно.	Үнэн зөв	ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/31-Т тоот Үнэт цаас нээлттэй гаргах тухай тогтоол



Андеррайтерийн шинжилгээ



Андеррайтерийн шинжилгээ



Андеррайтерийн шинжилгээ

Хүснэгт 3.5-1 Орлогын тайлангийн хураангуй төлөвлөгөө

Хүснэгт 3.5-2 Санхүүгийн байдлын төлөвлөгөө

Хүснэгт 3.5-3 Мөнгөн урсгалын төлөвлөгөө

Санхүүгийн тооцоолол

Ирэх 3 жилийн орлогын төлөвлөгөө, мөнгөн урсгалын төлөвлөгөөг үндэслэж үзэхэд "Инвескор ББСБ" ХК нь санал болгож буй өрийн хэрэгслийн хүү болон үндсэн төлбөрийг төлөх хангалттай нөөц бололцоотой байна.

Андеррайтерийн шинжилгээ

3.6	**3.6 Үнэт Цаасны Хөрөнгө Оруулалтын Өгөөж**			
	Санал болгож буй өрийн хэрэгслийн хугацаа нь 2 жил, хүүгийн хувь хэмжээ нь жилийн 14.0% байна. Тухайн хөрөнгө оруулагч 10 сая төгрөгийн буюу 100 ширхэг бонд худалдан авсан тохиолдолд 2 жилийн турш хүртэх өгөөжийн тооцооллыг доорх жишээнээс харна уу.			Андеррайтерийн шинжилгээ Санхүүгийн тооцоолол
	Хүснэгт 3.6-1 Үнэт цаасны хөрөнгө оруулалтын өгөөж			
	Анхны хөрөнгө оруулалт	10,000,000		Андеррайтерийн шинжилгээ Санхүүгийн тооцоолол

	Хүүгийн орлого	2,800,000		
	Хүүгийн орлогын татвар	140,000		
	Цэвэр ашиг	2,660,000		
	Дотоод өгөөжийн хувь* (1 жил)	13.77%		
	Хүүгийн орлогын албан татвар (5%) суутгасны дараах хувь, мөн хүүг хагас жил тутам төлөх нөхцөлийг оруулж тооцсон			Андеррайтерийн шинжилгээ Санхүүгийн тооцоолол

3.7 3.7 Үнэт Цаасны Эргэн Төлөлтийн Бодолт

Хүснэгт 3.7-1 Үнэт цаасны эргэн төлөлтийн хуваарь (мянган төгрөг)

Он сар	Бонд гаргалт	Транч 1 хүүний төлбөр	Транч 2 хүүний төлбөр	Транч 3 хүүний төлбөр	Бондын үндсэн төлбөр	Нийт төлбөр
2021-3 сар	8,000,000					
2021-5 сар	6,000,000					
2021-8 сар	6,000,000					
2021-9 сар		560,000				560,000
2021-11 сар			420,000			420,000
2022-2 сар				420,000		420,000
2022-3 сар		560,000				560,000
2022-5 сар			420,000			420,000
2022-8 сар				420,000		420,000

Андеррайтерийн шинжилгээ Санхүүгийн тооцоолол

000321

2022-9 сар		560,000				560,000
2022-11 сар			420,000			420,000
2023-2 сар				420,000		420,000
2023-3 сар		560,000			8,000,000	8,560,000
2023-5 сар			420,000		6,000,000	6,420,000
2023-8 сар				420,000	6,000,000	6,420,000
Нийт	**20,000,000**	**2,240,000**	**1,680,000**	**1,680,000**	**20,000,000**	**25,600,000**

Он сар	Бонд гаргалт	Транч 1 хүүний төлбөр	Транч 2 хүүний төлбөр	Транч 3 хүүний төлбөр	Бондын үндсэн төлбөр	Нийт толбор
2021-3 сар	8,000,000					
2021-5 сар	6,000,000					
2021-8 сар	6,000,000					
2021-9 сар		560,000				560,000
2021-11 сар			420,000			420,000
2022-2 сар				420,000		420,000
2022-3 сар		560,000				560,000
2022-5 сар			420,000			420,000
2022-8 сар				420,000		420,000
2022-9 сар		560,000				560,000
2022-11 сар			420,000			420,000

InvesCore
"ИНВЕСТОР КОРПИТАЛЦИЙ" ХК
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ
CAPITAL
InvesCore
"ИНВЕСТОР КОРПИТАЛЦИЙ" ХК
6060354 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ
CAPITAL
СЭХ
2021 .05. 27 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03
БҮРТГЭВ-02
000322

2023-2 сар				420,000		420,000
2023-3 сар		560,000			8,000,000	8,560,000
2023-5 сар			420,000		6,000,000	6,420,000
2023-8 сар				420,000	6,000,000	6,420,000
Нийт	**20,000,000**	**2,240,000**	**1,680,000**	**1,680,000**	**20,000,000**	**25,600,000**

**Бонд гаргах болон эргэн төлөлтийн хуваарь нь зөвхөн энэхүү танилцуулга хийгдэх үейн төсөөлөл бөгөөд өөрчлөгдөх боломжтой*

Андеррайтерийн шийдвэрлэх Санхүүгийн тооцоолол

3.8 **3.8 Үнэт Цаасны Эргэн Төлөлтийн Баталгаа**

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ... тоот шийдвэр болон "Инвескор ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/31-Т тоот тогтоолоор тус тус Үнэт цаасны эргэн төлөлтийн баталгаа болгон нийт 8,000,000 ширхэг ширхэг хувьцаа Андеррайтерт барьцаалахаар шийдвэрлэсэн байна.

Энэ дагуу "Инвескор ББСБ" ХК, "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь Андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай Хувьцаа барьцааны гурван талт гэрээ байгуулж, барьцаалагдсан хувьцааг Инвескор Бондын үндсэн болон хүүгийн эргэн төлөлт төлөгдөж дуусах хүртэлх хугацаагаар ҮЦТХТ-д тусгаарлуулахаар харилцан тохиролцсон байна. Уг гэрээнд заасны дагуу Барьцаалагч тал болох Андеррайтер нь Үнэт цаас эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэн Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны эргэн төлөлтийг Танилцуулгад заасан хугацаанд хийж гүйцэтгээгүй тохиолдолд барьцааны зүйл болох хувьцааг арилжиж, Үнэт цаасны үндсэн төлбөрийн эргэн төлөлт, хүү, барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн төлбөр болон барьцааны зүйлийн хадгалуулахад гарсан зардал, татвар, хураамж болон үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой гарсан хохирлын нийлбэрийг төлж барагдуулах ажиллагаа хэрэгжүүлэхээр заажээ. Барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдан борлуулах замаар Үнэт цаас эзэмшигчдийн төлбөрийг барагдуулах арга хэмжээ авна.

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны төлбөр төлж барагдуулах үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн тохиолдолд Барьцаалагч "Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн албан бичгийн дагуу 8,000,000 ширхэг хувьцааг тусгаарлалтаас чөлөөлүүлнэ.

Барьцаа хөрөнгийн үнэлгээ

	Уг Хувьцаа барьцааны гурван талт гэрээгээр Барьцаа хөрөнгийн үнэлгээг ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмын 6.7 дахь хэсэгт заасны дагуу Монголын Хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй сүүлийн 52 долоо хоногийн дундаж үнэлгээгээр тооцно. Хувьцааны барьцааны гурван талт гэрээ байгуулагдсан 2020 оны 12-р сарын 28 өдрийн байдлаар нэгж хувьцааны үнэлгээ 2,642.81 төгрөг бөгөөд нийт барьцаа хөрөнгийн үнэлгээ нь 21,142,480,000 төгрөгийн үнэлгээтэй болно.	
3.9	**3.9 Өрийн Хэрэгсэл Эзэмшигчийн Эрх, Үүрэг**	Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам, Арилжааны журам, ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмын холбогдох заалтууд
	Зохицуулагдах хууль тогтоомж	
	Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн Инвескор Бондыг эзэмшихтэй холбоотой харилцааг Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмын холбогдох зүйл заалтаар тус тус зохицуулна.	
	Үнэт цаас эзэмшигчийн өрийн хэрэгслээр гэрчлэгдэх эрх	
	✓ Үнэт цаас гаргагч, Өрийн хэрэгсэл болон холбогдох мэдээллийн талаар бие даасан хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийн санхүү, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргах эрхтэй.	
	✓ Үнэт цаасны үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй.	
	✓ Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд бүрэн төлөхийг шаардах эрхтэй.	
	✓ Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд нь төлөх боломжгүй болсон тохиолдолд барьцаа хөрөнгийг арилжиж, үүргийн гүйцэтгэл хангахыг шаардах эрхтэй.	
	✓ Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны мэдээллийн ил тод байдлын журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн мэдээллийг авах эрхтэй.	
	✓ Өрийн хэрэгслийн хөрдогч зах зээлийн мэдээлэлтэй танилцах эрхтэй.	

✓ Өрийн хэрэгслийг Монголын Хөрөнгийн Бирж дээрээс худалдан авах, хоёрдогч зах зээл дээр арилжаалах, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гуравдагч этгээдэд шилжүүлэх, захиран зарцуулах эрхтэй.	
✓ Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон. үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан эсхүл эд хөрөнгөгүй болсон тохиолдолд Өрийн хэрэгсэл эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг шаардах эрхтэй.	
✓ Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.	
Үнэт цаас эзэмшигчийн Өрийн хэрэгслээр гэрчлэгдэх үүрэг	
✓ Үнэт цаасны танилцуулгад заасны дагуу Үнэт цаас гаргагчийн Өрийн хэрэгслийг хугацаанаас нь омно эргүүлэн худалдан авах эрхээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөх, түүнд аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэгтэй.	
✓ Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн Өрийн хэрэгслийн төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хуувь ёсны үйл ажиллагаанаас олсон орлого богоод "Монгө угаах терроризмтой тэмцэх тухай хууль"-д заасны дагуу холбогдох шалгуурыг хангасан болохыг баталж, үнэт цаастай холбоотой эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолсны үндсэн дээр бие даасан шийдвэр гаргасан баталгаа гаргаж, Үнэт цаасны компаниас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.	
✓ Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Өрийн хэрэгслийн хүүгийн орлогоос татвар төлөх үүрэгтэй.	
3.10Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг	Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Монго угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, МХБ-ын Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам, Арилжааны журам,
Үнэт цаас гаргагч нь дараах эрх эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:	
Үнэт цаас гаргагчийн Өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой үйл ажиллагаа нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам, Арилжааны журам, УЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмаар тус тус зохицуулагдана.	

	✓ Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгө, санхүүгийн байдал болон үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.	ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмын холбогдох заалтууд	
	✓ Өрийн хэрэгслийг нэрлэсэн үнээр нь хугацааны эцэст хөрөнгө оруулагчаас бүхаан худалдаж авах, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах үүрэгтэй.		
	✓ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох журамд заасны дагуу өөрийн санхүүгийн болон бусад байдлын талаар үнэн зөв мэдээллийг тогтмол мэдээлэх үүрэгтэй.		
	✓ Үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад заасан зориулалтаар захиран зарцуулах үүрэгтэй.		
	✓ Өрийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд "Инвескор ББСБ" ХК, "Эс Ай Би Жэй Капитал" ХХК болон "Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн хооронд байгуулагдсаг Хувьцааны барьцааны гурван талт гэрээнд заасан зохих арга хэмжээг авч Үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.		
	✓ Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирол, алдангийг үл маргах журмаар толж барагдуулах үүрэгтэй.		
	✓ Үнэт цаас гаргагч нь Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрлах өөрийн дансанд шилжүүлэх үүрэгтэй.		
	✓ Үнэт цаас гаргагч нь Өрийн хэрэгслийг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдаж авах эрхтэй.		
3.11	**3.11 Үнэт Цаасны Арилжаа**		
	Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах		
	Үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах арилжаа нь Биржийн ТУЗ-ийн 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Биржийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлсан "Арилжааны журам"-д заасны дагуу явагдана. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Инвескор Бондыг Тапилцуулгын 3.2 дахь хэсэгт заасны дагуу үе шаттайгаар арилжаалахаар төлөвлөж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь арилжаа эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө үнэт цаасны захиалга болон арилжаатай холбоотой мэдээллийг олон нийтэд өөрийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.	Үнэн зөв	Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлсан Үнэт цаасны бүртгэлийн журам

			Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлсан Үнэт цаасны бүртгэлийн журам Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 02 сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлсан Арилжааны журам
	Зураг 3.11-1 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц		
		Үнэн зөв	Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын холбогдох заалтууд

000327

Зураг 3.11-2 Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга өгөх заавар



Үнэн зөв

Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын холбогдох заалтууд

Хүснэгт 3.11-2 Гүйлгээний заавар

Гүйлгээний заавар	
Дансны нэр	ҮЦК-ийн нэр
Дансны дугаар	ҮЦК-ийн номинал дансны дугаар /Брокероос авах/
Банкны нэр	/Брокероос авах/
Гүйлгээний утга	Нэр, Регистр, Инвескор Бонд
Хэрэв та Инвескор Капитал ҮЦК-д үнэт цаасны данстай бол доорх зааврааар шилжүүлнэ үү	
Дансны нэр	“Инвескор Капитал ҮЦК” ХХК
Дансны дугаар	495086732
Банкны нэр	Худалдаа Хөгжлийн Банк
Гүйлгээний утга	Нэр, Регистр, Инвескор Бонд

Андеррайтерийн мэдэгдэл

3.12Үнэт цаас гаргагчийн Холбогдох Этгээдийн Тухай

3.12	**Хүснэгт 3.12-1 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн мэдээлэл**		
	Холбогдох этгээд	Үнэн зөв	2019 оны 08 сарын 05-ны өдрийн А/04-Т ТУЗ-

	Нэр: А. Энэрэл Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга И-мэйл хаяг: enerel@invescore.mn Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар Утас: 77090077			ийн даргын "ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай" шийдвэр	

0.00329

4	**ДӨРӨВ. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД**		
4.1	**4.1 Үнэлгээ**		
	Үнэлгээний компанийн танилцуулга		
	ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ "Гэрэгэ Эстимэйт" ХХК Регистрийн дугаар: 5342961 Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу гудамж 24/1-5А, "Монре Импекс" ХХК-ийн байр Утас: 70005000 И-мэйл: gantulga@geregepartners.mn "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх эрх бүхий, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр ажилладаг үнэлгээний мэргэжлийн байгууллага юм. Тус компанийн үнэлгээний баг нь Монгол Улс болон олон улсын их дээд сургууль төгсөж, олон улсын нэр хүндтэй байгууллагуудад ажиллаж байсан академик болон мэргэжлийн туршлага хуримтлуулсан үнэлгээчин, актуарч, нягтлан бодогч, эдийн засагч болон санхүүгийн бусад мэргэжилтнүүдээс бүрддэг бөгөөд Монгол Улсын Сангийн Яамнаас олгодог Мэргэшсэн үнэлгээчний сертификаттай үнэлгээчид ажилладаг. Бизнесийн үнэлгээний болон хөрөнгийн үнэлгээний өргөн цар хүрээтэй ажлууд дээр "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь эдийн засаг, санхүү, бизнес, актуарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани болох "Гэрэгэ Партнерс" ХХК-ийн мэргэжилтнүүдтэй хамтарч баг болон ажилладаг.		"Гэрэгэ Эстимэйт" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ www.geregepartners.mn
	Тус компанийн үнэлгээчид нийт 15 гаруй бизнесийн үнэлгээний ажил хийж гүйцэтгэсэн ба компанийн харилцагчдад "М Си Эс Холдинг" ХХК, "Туушин Зочид Буудал" ХХК зэрэг Монгол Улсын томоохон компаниуд болон Биржид бүртгэлтэй "Тахько" ХК, Торонто Венчур Биржид бүртгэлтэй "Монголиа Гровт Групп" зэрэг компаниуд багтдаг. Мөн 2017 онд "ЛэндМн ББСБ" ХХК-ийн хувьцааг хөрөнгийн биржид хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгоход зориулан бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.		

СЭХ 2021 -05- 27 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-02-03 БҮРТГЭВ-02
InvesCore CAPITAL
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
6317835 ☎ 11127728 УЛААНБААТАР ХОТ
InvesCore
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
6060854 ☎ 11127728 УЛААНБААТАР ХОТ
000330

	Үнэлгээний компанитай байгуулсан гэрээ		
	"Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2020 оны 12 сарын 07-ны одор "Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан байна. Гэрээний хүрээнд "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг тус компани Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд нээлттэй бонд гаргах зориулалтаар Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын хүрээнд Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэхээр тохиролцжээ.	Үнэн зөв	"Гэрэгэ Эстимэйт" ХХК-тай 2020 оны 12 сарын 07-ны өдөр байгуулсан Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ
	Гэрээнд үнэлгээний компани нь үнэлгээний тайланд үнэлгээ хийсэн аргачлал, үнэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлсийн үндэслэлийг нарийн тусгаж, үйлчлүүлэгчийн хүсэлтээр гуравдагч этгээдэд үнэ төлбөргүйгээр өөрийн хэрэглээсэн аргачлал, үндэслэлийг батлан харуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа олж мэдсэн мэдээллийг гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд задруулахгүй байх, задруулсан тохиолдолд үйлчлүүлэгчид учирсан хохирлыг үл маргах журмаар нөхөн төлөх, ажил гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн баримт бичиг, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах, аливаа доголдолгүйгээр эргүүлэн өгөх, өөрийн гаргасан тайлангийн үнэн зөвийг Үнэт цаас гаргагчийн омнө бүрэн хариуцах үүрэг хүлээсэн байна.	Үнэн зөв	
	Үнэт цаас гаргагч нь ажил гүйцэтгэгчид бичиг, баримт мэдээллийг шаардлагатай хэмжээгээр хүлээлгэн өгөх, үнэлэгдэж буй хөрөнгийг баланс болон тоо бүртгэлд тусгасан байх, гэрээнд заасан журмаар үйлчилгээний төлбөр тооцоог хугацаанд нь төлж барагдуулахаар заасан. Ажил гүйцэтгэгч нь үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан байх үүрэг хүлээх ба гэрээт ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгээгүй, тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөөгүй, мөн гүйцэтгэсэн ажлын үр дүн нь доголдолтой бол Иргэний хуулийн 352 дугаар зүйлд заасны дагуу доголдлыг арилгах болох тийнхүү арилгахтай холбогдон гарсан зардлыг нөхөн толох, ажлыг холсийг бууруулахаар заажээ. Мөн ажил гүйцэтгэгч дүгнэлт гаргахдаа мэргэжлийн алдаа гаргасныг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан Мэргэжлийн зөвлөл тогтоосон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн төлсөн бүхий л төлбөр, учирсан хохирол болон Мэргэжлийн зөвлөлийн зардлыг нөхөн толох үүрэгтэй гэж заасан байна.	Үнэн зөв	
4.2	**4.2 Аудит**		
	Аудитын компанийн танилцуулга		
	BDO "БДО Аудит" ХХК Регистрийн дугаар: 2546442	Үнэн зөв	"БДО Аудит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ https://www.bdo.mn/mn-mn/contact-us

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, Юнэскогийн гудамж, Юнион Бюлдинг, В блок, 1502 тоот Утас: 77404040, 77404041 И-мэйл: info@bdo.mn "БДО Аудит" ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО-ийн дэлхий даяарх 90,000 гаруй ажилчид дэлхийн 167 орон дахь 1617 салбар оффисоороо дамжуулан зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Монгол Улс дахь оффис нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай "Итгэлт Аудит" ХХК-ийн суурин дээр 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод үүсгэн байгуулагдсан. Тус компани нь 2012 оны 8 сарын 08-ны өдөр Хорооны 259 тоот тоотоолын дагуу Үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх эрх авсан юм. "БДО Аудит" ХХК нь 4 партнер, 50 гаруй мэргэжилтнүүдтэй бөгөөд аудит ба баталгаажуулалт, үнэлгээ ба шинжилгээ, бизнесийн зовлох үйлчилгээ, дотоод гадаад аутсорсинг, татвар ба хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь Голомт Банк, Чингис Хаан Банк, Энэржи Ресурс, Эм Си Эс, Юнител, Витафит, Би Ди Сек, Багануур, Эрдэнэс Таван Толгой, Дархан Нэхий, Инвескор ББСБ, Магнай Трейд Групп, Монос Групп зэрэг дотоодын шилдэг аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.		Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://www.bdo.mn/mn-mn/about-us/bdo-history
Аудитын компанитай байгуулсан гэрээ		
"БДО Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2018 оны 12-р сарын 05-ны өдөр "Аудитын гэрээт ажлын захидал" нэртэй Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан бөгөөд "Инвескор ББСБ" ХК-ийн 2018, 2019, 2020, 2021 онуудын 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийлгэхээр тохиролцсон байна. Мөн уг талууд нь 2020 оны 12-р сарын 07-ны өдөр "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулан Үнэт цаас гаргагчийн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй гаргахаар төлөвлөж буй 20,000,000,000 хүртэлх үнийн дүнтэй Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах ажиллагаанд Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад холбогдох журамд заасны дагуу Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг хянах үйлчилгээг үзүүлэхээр тохиролцжээ.	Үнэн зөв	"БДО Аудит" ХХК-тай 2018 оны 12-р сарын 05-ны өдөр байгуулсан Аудитын гэрээт ажлын захидал "БДО Аудит" ХХК-тай 2020 оны 12-р сарын

			07-ны өдөр байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ
	Гэрээний дагуу "БДО Аудит" ХХК нь үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, хичээл зүтгэл, үр дүнтэй хугацаанд нь гүйцэтгэх, үйлчлүүлэгчийн гарган өгсөн санхүүгийн баримт мэдээллийг зөвхөн гэрээт ажлын зорилгоор анхаглах, чанд нууцлах үүрэг хүлээсэн байх ба Үйлчлүүлэгч буюу Үнэт цаас гаргагч нь Зээлийн шинжилгээ гаргагчид шаардлагатай санхүүгийн болон бусад баримт бичгүүдийг тохирсон цаг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн гаргаж өгөх, үйлчилгээний цар хүрээг хязгаарласан дарамт шахалт үзүүлэхгүй байх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангах, төлбөрийг хугацаанд нь төлөх үүрэг хүлээсэн байна.	Үнэн зөв	"БДО Аудит" ХХК-тай 2020 оны 12-р сарын 07-ны өдөр байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ
4.3	**4.3 Хууль**		
	Хуулийн фирмийн танилцуулга		
	MDSKhanLex "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН Регистрийн дугаар: 5495997 Хаяг: Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот Утас: 11330048 И-мэйл: info@mdsa.mn	Үнэн зөв	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ https://mdskhanlex.com/mn/home-2/
	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.	Олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэл https://mdskhanlex.com/mn/home-2/ https://mdskhanlex.com/mn/knowledge-2/capital-market/	
	"Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд богоод тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн үнэт цаасыг олон улсын түвшинд санал болгох, Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн		

	төсөл боловсруулах, Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах, "ЛэндМН ББСБ" ХХК "Инвескор ББСБ" ХХК болон "Түмэн шувуут" ХХК-ийн IPO, "Хөвсгөл алтандуулга" ХК, "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах, "ЛэндМн ББСБ" ХК-ийн бонд, Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл дээр хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.	
	Хуулийн фирмтэй байгуулсан гэрээ	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН-тэй 2020 оны 12 сарын 07-ны өдөр байгуулсан Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ	
	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН нь Үнэт цаас гаргагчтай 2020 оны 12 сарын 07-ны өдөр дугаар бүхий "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулжээ. Гэрээний дагуу хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу Үйлчлүүлэгчээс үнэт цаас гаргаж, Монголын хөрөнгийн биржээр нийтэд санал болгох (цаашид "Төсөл" гэх) хүрээнд Монгол Улсын хуулийн дагуу үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэхтэй холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна.	
	Гэрээний дагуу хуулийн фирм нь өөрийн үүрэгт ажлаа тохиролцсон хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх, үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хотлох, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах үүргийг тус тус хүлээсэн байна. Үнэт цаас гаргагч нь Хуулийн фирмд гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлчилгээний хөлсийг хугацаанд нь бүрэн төлөх, үнэн зөв бодит мэдээлэл, шаардлагатай баримт, материалыг гаргаж огох, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах үүргийг хүлээжээ.	
4.4	**4.4 Андеррайтер**		
	Андеррайтерийн танилцуулга		
	"Инвескор Капитал ҮЦК" ХХК Регистрийн дугаар: 6317839	Үнэн зөв	"Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, https://www.icapital.mn/#icapital-about_us

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар Утас: 77090077(2) И-мэйл: info@icapital.mn "Инвескор Капитал УЦК" ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм. Тус компани нь Хорооноос үнэт цаасны брокерын үйл ажиллагаа, үнэт цаасны диллерийн үйл ажиллагаа, үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүй, өмгөөллийн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олонтой бөгөөд хөрөнгийн болон үнэт цаасны зах зээл, үнэт цаас, санхүүжилт татах, хувьцаа анх удаа нийгэд нээлттэй арилжаалах /IPO/, M&A, хөрөнгө оруулалт болон бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн туршлагатай юм.		https://www.icapital.mn/#icapital-about_us "Инвескор Капитал УЦК" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ СЗХ-ны 3/113 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ https://www.icapital.mn/#icapital-about_us
Андеррайтертай байгуулсан гэрээ		
Үнэт цаас гаргагч нь "Инвескор Капитал УЦК" ХХК-тай 2020 оны 12 сарын 04-ний өдөр UWSA-201204/1 тоот "Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулж Инвескор Бондын Биржээр дамжуулан нээлттэй арилжаалах ажлыг зохион байгуулах, андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээг авахаар харилцан тохиролцжээ. Андеррайтер нь уг гэрээний дагуу үнэт цаас гаргах бэлтгэл хангах зөвлөх үйлчилгээ болон үнэт цаасыг Биржээр дамжуулан нийтэд санал болгох андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэхээр тохирсон байна. Гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан байх ба Гэрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасны дагуу хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр андеррайтерийн үйлчилгээг үзүүлэхээр заажээ.	Үнэн зөв	"Инвескор Капитал УЦК" ХХК-тай 2020 оны 12 сарын 04-ний өдөр байгуулсан Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ
Андеррайтер, зөвлөх үйлчилгээний хүрээнд андеррайтер нь үнэт цаас гаргах ажлын төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн тооцоо хийх, үнэт цаасны танилцуулга бэлтгэх, эрх бүхий этгээдэд үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах, үнэт цаасыг танилцуулах аяныг зохион байгуулах, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахаар заасан байна. Андеррайтер нь өөрийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах, Үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа	Үнэн зөв	

	харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн нууцлалыг хадгалах, задруулахгүй байх, задруулсан тохиолдолд хариуцлага хүлээх, үйлчилгээг ямарваа нэг байдлаар доголдолтой үзүүлсэн тохиолдолд тухайн доголдлыг өөрийн зардлаар арилгах зэрэг үүргийг тус тус хүлээсэн байна.		
	Үнэт цаас гаргагч нь Андеррайтерт ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг гаргаж өгөх, үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтныг томилон ажиллуулах, мэдээллийг нууцлах, гэрээний үүргээ зөрчсөний улмаас андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах, үнэт цаас гаргах үйл ажиллагааны маркетинг сурталчилгаа, танилцуулах аяны ажлыг андеррайтертай хамтран боловсруулсан маркетингийн төлөвлөгөөний явуулах бүх шаардлагатай нөхцөлийг хангах, стратегийн хөрөнгө оруулагчид танилцуулга хийх болон үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбоотойгоор танилцуулах аянд оролцох, танилцуулга хийх удирдах албан тушаалтан болон шаардлагатай мэргэжилтнүүдийг тодорхойлж, андеррайтертай хамтран ажиллуулах зэрэг үүргийг хүлээжээ.	Үнэн зөв	
	Түүнчлэн гэрээгээр дотоод мэдээлэл эзэмшигчийн асуудлыг зохицуулсан байх бөгөөд дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах, худалдах, шилжүүлэх, Үнэт цаас гаргагчийн хувьцаат биржээр болон гуравдагч этгээдээр дамжуулан худалдан авах, борлуулах, ашиг олох, мөн санхүүжилт татах, эрх бүхий этгээдүүд болон андеррайтерийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэхийг дотоод мэдээлэл эзэмшигчид хориглосон байна. Мөн Үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг андеррайтертай зовшилцолгүйгээр олон нийтэд мэдээлсэн, түүний улмаас Үнэт цаасны үнэлгээнд нөлөөлөх, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд учирсан хохирлыг хариуцахаар өөрөө зохицуулжээ.	Үнэн зөв	

~oOo~

СЭХ
2021 -05- 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 20
БҮРТГЭВ-02

АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

"Инвескор Капитал ҮЦК" ХХК (цаашид "Андеррайтер" гэх) нь андеррайтерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Инвескор ББСБ" ХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх)-тай 2020 оны 12 сарын 04-ний одор Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулан Үнэт цаас гаргагчийн шинээр гаргах гэж буй өрийн хэрэгсэл (цаашид "Инвескор Бонд" гэх)-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй арилжаалах үйл ажиллагаанд Андеррайтераар оролцож байна.

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий 200,000 (хоёр зуун мянган) ширхэг Компанийн өрийн хэрэгслийг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргах ба зах зээлээс татсан санхүүжилтийг Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Үнэт цаас гаргагч нь нийтэд нээлттэй хувьцаат компани тул бид нийтэд нээлттэй мэдээлэл болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөллийн талаар мэдээлэлд суурилан Андеррайтерийн мэргэжлийн дүгнэлтийг дараах чиглэлээр гаргаж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа
2. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө
3. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
4. Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэл
5. Дүгнэлт

I. ҮЗЭГ. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь 2016 онд "Инвескор ББСБ" ХХК нэртэйгээр байгуулагдаж, 2019 оны 5-р сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийт хувьцааны 15%-ийг нийтэд санал болгон амжилттай арилжаалж "Инвескор ББСБ" нээлттэй Хувьцаат Компани болсон байх ба Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ 101/554 дугаар тусгай зөвшөөрөл, 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйл ажиллагаа, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авсан бөгөөд эдгээр нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 10.1.1, 15, 15.3.1, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 9.1-д заасан шаардлагад нийцэж байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар эдгээр тусгай зөвшөөрлүүд нь хүчин төгөлдөр байгаа бөгөөд түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна /Хуулийн дүгнэлтийн 6-д/.

Үнэт цаас гаргагч нь дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг бөгөөд засаглалын баримт бичгүүд нь хууль тогтоомж болон СЗХ-оос батлагдсан "Компанийн засаглалын кодекс" нийцсэн тухай Хуулийн дүгнэлтийн 3 дугаар хэсэгт дурдсан байна.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь нийт 13 салбар, 1 охин компани, Киргиз Улсад 2 охин компани, нийт 150 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж буй Монгол улсын топ банк бус санхүүгийн байгууллага болж чадсан байх ба байгууллагдсан цагаасаа хойш нийт зээлийн багцын жилийн дундаж өсөлт 116.6%, цэвэр ашгийн жилийн дундаж өсөлт 131.2% зэрүүлж салбартаа хамгийн өндөр өсөлттэй байна. Энэхүү амжилтын үндэс нь 1) шаардлагатай хөрөнгө

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

оруулалтуудыг цаг тухайд нь бүрдүүлж компанийн өсөлтийн хурдыг сааруулаагүй 2) зээлийн процесс, судалгааны автоматжсан системийг хөгжүүлсэнээр зээл олголтын хурдыг нэмэгдүүлж, эрсдэлийн удирлдлагын тогтолцоог үр дүнтэй бүрдүүлсэн 3) харилцагчдын гэрээ, болон бусад бичиг баримтыг цахимжуулж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлсэнтэй шууд холбоотой байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 11.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 31.5%-р өссөн үзүүлэлт бөгөөд нийт хөрөнгийн өгөөж (ROA) 8.4% байгаа нь салбарын дундаж 7.5%-с харьцангуй ондор байна. Нийт эздийн өмчийн өгөөж (ROE) 21.7% байгаа нь салбарын дундаж 10.8%-с харьцангуй өндөр байна.

Үзүүлэлт /сая төгрөг/	2016	2017	2018	2019	2020
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	223	1,104	2,320	5,146	26,589
Хөрөнгө оруулалт	-	-	-	3,600	591
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	4,162	17,164	33,627	60,645	92,548
Нийт зээл	4,240	17,554	34,897	61,951	95,291
Эрсдэлийн сан	(78)	(390)	(1,270)	(1,305)	(2,742)
Хүүний авлага	132	695	1,241	1,663	3,861
Авлага	-	-	-	-	1,534
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	540	418	1,056	822
Бусад актив	5	40	811	2,310	492
Үндсэн ба биет бус хөрөнгө	29	100	606	7,483	9,503
НИЙТ ХӨРӨНГӨ	4,551	19,644	39,023	81,902	135,941
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,109	2,508	10,374	19,934	42,210
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	7,897	13,867	14,516	14,100
Бонд	-	-	-	-	7,879
Бусад өглөг	44	401	891	7,064	19,055
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,152	10,806	25,132	41,514	75,419
Хувьцаат капитал	2,000	6,097	6,097	16,282	16,282
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	15,378	15,378
Эрсдэлийн нөөц сан		109			21,037
Хуримтлагдсан ашиг /(алдагдал)	399	2,632	7,794	8,729	16,282
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	2,399	8,837	13,891	40,389	52,697
Өөрийн хөрөнгийн дундаж өгөөж (ROAE)	16.6%	29.7%	36.4%	21.5%	21.6%
Нийт хөрөнгийн дундаж өгөөж (ROAA)	8.8%	13.4%	13.0%	10.6%	8.4%

Үнэт цаас гаргагч нь дэвшилтэт мэдээлийн технологи, чадварлаг хүний нөөц, менежментийн ачаар ашигт ажиллагаагаа тогтмол өсгөж ирсэн ба Ковид-н эрсдэлтэй, хүнд нөхцөл байдалд ч мөн үүнийгээ амжилттай хадгалж чадсан байх ба Банк бус санхүүгийн зах зээлийн хөгжлийн дараагийн чиг хандлага болж буй барьцаагүй, онлайн зээлийн Покет апликейшнийг өөрийн 100% охин компани болох "Инвескор Хэтэвч " ХХК-иар хөгжүүлж 160 мянган хэрэглэгчтэй болсон бөгөөд зах зээлээ тэлэхэд чиглэгдсэн Инвескор Аллианс, SMB, Технологи шинэчлэлийн тосөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

ХОЁР. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө

Банк бус санхүүгийн зах зээл сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж, жилийн дундажаар 25-30% өсөлт үзүүлж ирсэн. Түүнчлэн финтекд суурилсан барьцаагүй, жижиг зээлийн нөлөөгөөр

СЭХ
2021 05 27
БУРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -05- 20
БУРТГЭВ-02

2020 оны байдлаар ББСБ салбарын нийт зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 87.7 хувиар өсч 788 мянгад хүрсэн байна. Гэсэн хэдий ч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр улсын эдийн засаг, зээлийн нөхцөлд томоохон өөрчлөлт гарч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч нар ч бизнесийн ухаалаг шийдлүүд хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгаа ч төрөөс хэрэгжүүлж байгаа цар тахлын эдийн засгийн нөлөөг бууруулах бодлогын арга хэмжээний үр дүнд эдийн засгийн идэвхижил сэргэх, ингэснээр иргэд, байгууллагын зээлийн эрэлт ирэх жилүүдэд сэргэх хүлээлттэй байна.

Зээлийн багц

Үнэт цаас гаргагчийн төсөөллөөр дэлхийн болон Монгол Улсын эдийн засаг богино хугацааны уналтын дараа хурдтай сэргэх бөгөөд эх үүсвэрийг зөв зээлийн багцуудад байршуулснаар 2021 онд зээлийн багцаа 64% өсгөж, 28.3 тэрбум төгрөгийн хүүгийн цэвэр орлого, 21.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах боломжтой гэж үзжээ. Үнэт цаас гаргагч нь 2021 онд зээл олголтын үйл ажиллагааг 2020 онтой ижил түвшинд, харин 2022, 2023 онд ихсэж 82.7%-д хүртэл өсгөхөөр төсөөлж байгаа нь өнгөрсөн 3 жилийн дундаж үзүүлэлт болох 84.8%-иас бага байгаа тул энэ нь харьцангуй бодит, биелэх боломжтой төсөөлөл гэж Үнэлгээний компани дүгнэсэн байна /Үнэлгээний тайлан 5 дугаар бүлэг/.

Санхүүгийн байдал

Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн бүтэц нь Итгэлцэл-56.0%, Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл 18.7%, Бонд болон бусад өглөг-10.4% эзэлдэг. Бодлогын хүү буурсантай холбоотойгоор арилжааны банкууд хадгаламжийн хүүгээ жилийн 10% хүртэл буулгаж байгаа тул үүнтэй уялдуулан төгрөгийн итгэлцлийн ЖДХ-г аажмаар бууруулж эхэлжээ.

Хөтөлбөрийн хүрээнд 2021 онд нийт өр төлбөрт итгэлцлийн эзлэх хувийг бууруулж илүү урт хугацаатай эх үүсвэрийн бүтэцтэй болохоор төлөвлөсөн ба зээлийн багцаа идэвхтэй нэмэгдүүлэх, үйл ажиллагааны орлогын жилийн дундаж өсөлт 44.0%, үйл ажиллагааны зардлын өсөлтийг 24.6% байхаар төсөөлсөн. Ингэснээр дунд хугацаанд нийт эздийн омчийн дундаж өгөөжийг 32-34% хүртэл осгохөөр төлөвлөсөн байна.

Түүнчлэн Бизнес төлөвлөгөөний дагуу чанаргүй зээлийн хэмжээг 3%-иас хэтрүүлэхгүй байх зорилттой ба энэ нь эрсдэлийн санг 2020 оны 2.9%-иас 2023 он гэхэд 1.7% хүртэл бууруулах юм. Цаашид компанийн цэвэр ашигийн маржиныг 41-44% хадгалж, 2021 оны санхүүгийн тайланд үндэслэн 2022 оноос ногдол ашиг хуваарилахаар төлөвлосон байна.

ГУРАВ. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь компанийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулах зорилгоор нийт 20,000,000,000 төрбум төгрөгийн өрийн хэрэгсэлийг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй арилжаалахаар шийдвэрлэсэн байх ба 2021 онд нийт 156.6 тэрбум төгрөгийн зээлийн багц бүрдүүлэхээр төлөвлөсөн нь 2020 оноос 58.1 тэрбум төгрөг (60%)-ийн өсөлт юм. Инвескор Бондыг нийтэд нээлттэй арилжих замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг 100% энэхүү өсөлтийг санхүүжүүлэхэд зарцуулах боговд дараах чиглэлийн зээлийн багцад байршуулахаар төлөвлөжээ. Үүнд:

Зээлийн бүтээгдэхүүн	Эзлэх хувь	Дүн, тэрбум ₮
Бизнесийн зээл	55%	11.0
Хэрэглээний зээл	45%	9.0
Нийт	**100%**	**20.0**

2020 оны эцсээр Бизнесийн зээлийн нийт багцад эзлэх хувь 43% байх хүлээлттэй байгаа бол 2021 онд 44% хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Түүнчлэн финтекд суурилсан Хэрэглээний шуурхай зээлийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх зорилготой байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ББСБ" ХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

Зээлийн үлдэгдэл, сая. ₮	12/31/2020		12/31/2021	
	Зээлийн үлдэгдэл, сая. ₮	Багцад эзлэх %	Зээлийн үлдэгдэл, сая. ₮	Багцад эзлэх %
Бизнесийн зээл	40,794	43%	68,090	44%
Автомашины зээл	29,772	31%	39,000	25%
Хэрэглээний зээл	24,725	26%	49,500	31%
Нийт	**95,291**	**100%**	**156,590**	**100%**

ДӨРӨВ. Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн талаар

Өгөөжийн түвшин

Цар тахлын эсрэг эдийн засгийн дэмжлэг арга хэмжээ болгон 2020 оны 11 сарын 24 өдөр Монголбанк бодлогын хүүг 6% болгон бууруулсан нь арилжааны банкуудын хадгаламжийн өгөөжийг мэдэгдэхүйц бууруулсан богоод Инвескор бондын жилийн хүү 12.0%-14.0% -тай байгаа нь хөрөнгө оруулагчид өрсөлдөхүйц өгөөжийг санал болгож байна. Түүнчлэн пээлттэй зах зээлд арилжих бондын хүүгийн орлогоос 5% татвар ногдуулах зохицуулалттай ба татварын дараах жилийн өгөөж нь 11.4%-13.77% байгаа нь банкны хадгаламжтай харьцуулахад үнэт цаасны хөрөнгө оруулалтын өгөөжийг мөн нэмэгдүүлж байна.



Хөрөнгө оруулалтын эрсдэл

Хөрөнгө оруулагч нь эрсдэл, өгөөжийн түвшнийг харьцуулж хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргах нь зүйтэй. Хөрөнгө оруулалтын аливаа бүтээгдэхүүнүүд зохих эрсдэлийг агуулдаг. Андеррайтер нь үнэт цаастай холбоотой, хөрөнгө оруулалтын өгөөж, эргэн төлөлтөд учирч болох эрсдэлүүдийг тодорхойлж, хөрөнгө оруулагчдад мэдээллэж байгаа бөгөөд бүх боломжит эрсдэлүүдийг агуулаагүй байж болзошгүй юм.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл

Зээл олголт, зээлийн багцын удирдлагын үйл ажиллагаа нь банк бус санхүүгийн байгууллагын үндсэн эрсдэл байдаг. Энэ процессийн засаглал, хүний нөөц, шийдвэр гаргалтын зохистой байдал нь Компанийн санхүүгийн тогтвортой байдал, ашигт ажиллагаанд шууд нөлөөлдөг. Инвескор ББСБ ХК нь салбартаа нэр хүнд бүхий мэрэгшсэн боловсон хүчнээр багаа бүрдүүлж, засаглалын олон улсын шилдэг жишигийг нэвтрүүлж чадсан байгаа нь түүний зээлийн чанарын үзүүлэлт, ашигт ажиллагааны үзүүлэлтээс харагдаж байна. Түүнчлэн технологийн шийдлээр зээл олголтод хүний оролцоог зохих түвшинд хязгаарласан байна.

Төлбөрийн чадварын эрсдэл

Үнэт цаас гаргагч нь 2020 оны байдлаар гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага болон итгэлцлийн үйлчилгээгээр нийт 75.4 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 56.0% буюу 42.2 тэрбум төгрөгийг богино хугацаатай итгэлцлийн үйлчилгээгээр бүрдүүлсэн.

Санхүүгийн байдлын төсөөлөл:

Үзүүлэлт /сая төгрөг/	2020A		2021F		2022F		2023F	
Итгэлцлийн үйлчилгээний оглог	42,210	56%	48,694	38%	62,834	38%	110,254	51%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	14,100	19%	33,705	26%	46,264	28%	54,519	25%
Бонд	7,879	10%	25,563	20%	24,016	15%	5,385	2%
Бусад өглөг	19,055	25%	21,239	16%	32,230	19%	47,187	22%
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	75,419		129,201		165,343		217,345	
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	52,697		75,187		103,782		144,205	
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	135,941		204,388		269,126		361,550	
Өрийн харьцаа	55%		63%		61%		60%	

Компани нь санхүүгийн хөшүүргийн салбарын дундаж үзүүлэлт 29% (2020 оны 3-р улирал)-ээс өндөр ашигладаг нь тус компанийн хурдацтай өсөлтийн нэг шалтгаан байна.

Өрийн үйлчилгээний харьцааны төсөөлөл:

Үзүүлэлт /сая төгрөг/	2020	2021	2022	2023
Үйл ажиллагааны цэвэр орлого	29,598	40,709	57,249	77,343
Бонд бусад өр төлбөрын эргэн төлөлт	7,202	15,767	22,327	43,593
Өрийн үйлчилгээний харьцаа (DSCR)	3.53x	2.58x	2.56x	1.77x

Хэдийгээр компанийн эх үүсвэрт өр төлбөрийн эзлэх хэмжээ өндөр боловч харьцангуй өндөр ашигт ажиллагаатай байгаа нь компанийн тухайн хугацаанд гүйцэтгэх ёстой төлбөрийг төлөх чадамжийг харуулдаг Өрийн Үйлчилгээний Харьцаа (ӨҮХ) хангалттай өндөр түвшинд хадгалж байна. Зөвхөн 2023 он буюу энэхүү хөтөлбөрийн бондын эргэн төлөлт хийгдэх хугацаанд ӨҮХ хамгийн бага 1.77x хүрэх төсөөлөлтэй байна. Энэ нь дийлэнх банк, санхүүгийн байгууллагуудаас тавигддаг 1.3x байх шаардлагаас хангалттай ондор байна.

Түүнчлэн бондын хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн баталгаа болгон толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй нийт 31,734,884,462 төгрөгийн үнэлгээ[1] бүхий 12,000,000 ширхэг хувьцааг барьцаалж байгаа нь эргэн төлөгдөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулж байна. Уг хувьцаа нь МХБ-ийн ТОП-20 индекс, хувьцааны бүртгэлийн II ангилалд багтдаг бөгөөд 2020 оны эхний хагас жилийн

[1] Дээрх хувьцааны үнэлгээг 2020 оны сүүлийн 52 долоо хоногийн дундаж үнэлгээгээр буюу 2,644.57 төгрөгөөр тооцсон байна.

байдлаар арилжааны идэвхийн хувьд 7-р байранд эрэмбэлэгдэж, хоёрдогч арилжаа эхэлсэн 2019 оны 6-р сараар хойш 73.8% өсөлт үзүүлсэн байна.

Макро эдийн засгийн эрсдэл

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2020 онд -5.7%-иар агших хүлээлттэй бөгөөд цар тахлын хөл хорионы нөлөөгөөр бизнес эрхлэгч, иргэдийн орлого буурах, үүнийг даган хэрэглээ буурч байна. Түүнчлэн төлбөрийн чадвар муудахаас үүдэн зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүсэх байдал салбарын хэмжээнд ажиглагдаж байна. Банк, банк бус санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийн үзүүлэлт сүүлийн 2 улирал дараллан муудсан байгаагаас харж болно.

Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлогуудын үр дүнд хадгаламжийн хүү буурч мөнгөний нийлүүлэлт өсч байгаа ч ойрын хугацааны төлөв байдлыг сайжруулахад дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй байна. Гэсэн хэдий ч голлох экспортын бүтээгдэхүүний орлого нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь цаашид уул уурхай дагасан бизнесүүд, төсвийн орлогыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Иймд, хэдийгээр цар тахлын хөл хорионы нөхцөл байдал хэсэгчлэн болон зохих хэмжээнд үргэлжлэх төлөвтэй байгаа ч бизнес эрхлэгч, иргэдийн орлогыг дэмжих арга хэмжээнүүд ч мөн үргэлжлэх боломжтой байна. Компанийн Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа энэ нөхцөл байдлыг харгалзан үзэж гарч болох эрсдэлүүдийг тооцсон байна.

ТАВ. Дүгнэлт

Үнэт цаас гаргагч нь Өмгөөллийн "Эм Ди Эс энд Хааплекс" ХХН-тэй "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулан Монгол Улсын хуулийн дагуу үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журамд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэхтэй холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ авсан ба тус дүгнэлтээр "Инвескор ББСБ" ХК-ийн Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн байна гэж дүгнэгджээ. Түүнчлэн Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай, ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүн нь Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа болохыг мөн Хуулийн дүгнэлтийн 2 дугаар хэсэгт тусгасан байна.

Үнэт цаас гаргагч нь засаглалын оновчтой бүтцийг хэрэгжүүлж, туршлагатай, мэргэшсэн удирдлагын багаар компанийн тогтвортой хөгжлийг хангаж, санхүүгийн харьцаанууд, хөрөнгө оруулагчдын өгөөжийг зохистой түвшинд хадгалж ирсэн байх ба Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн нэг болох чанаргүй зээлийн хэмжээ нь салбартаа хамгийн бага түвшинд буюу 2020 оны жилийн эцсийн байдлаар 3.0% (ББСБ-ын салбарын үзүүлэлт 10.3%) байгаа нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны эрүүл, найдвартай байдлыг илтгэж байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн хэрэгжүүлж буй эрсдэлийн удирдлагын цогц бодлоготой нягт холбоотой бөгөөд Үнэт цаас гаргагч нь 2020 онд эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бататган сайжруулж, хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн байна.

Түүнчлэн "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан Үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээний дагуу Инвескор Бондын Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд гаргахад шаардагдах хөрөнгийн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэсэн ба уг үнэлгээний ажил нь Инвескор Бондын эргэн төлөлтийн чадавхийг тооцоолох болон түүс бондын эргэн төлөлтийн баталгаа хөрөнгийн үнэлгээ хийх зорилготой юм. Үнэлгээний тайлангаар 1/Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд туссан хөрөнгө болон өр төлбөрүүд нь зах зээлийн бодит үнэ цэнээр тусгагдсан; 2/ 2023 он хүртэлх санхүүгийн төсөөлөлд туссан хөрөнгө болон өр төлбөрийн үзүүлэлтүүд нь үнэлгээний өдрийн байдлаар харьцангуй бодит,

биелэх боломжтой; 3/ Инвескор Бондын хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэх санхүүгийн чадавхи сайн гэж дүгнэсэн байна /Үнэлгээний тайлан Дүгнэлт хэсэг/.

Үпэт цаас гаргагч нь үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн баталгаа болгон тус компанийн хувьцааг барьцаалуулахаар Хувьцаа эзэмшигч болон Андеррайтертай гурван талт гэрээ байгуулсан нь хөрөнгө оруулагч нарыг хөрөнгө оруулалтын эрсдэлээс хамгаалж байна. Бондын хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн баталгаа болгон толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй нийт 31,734,884,462 төгрөгийн үнэлгээ бүхий 12,000,000 ширхэг хувьцааг барьцаалж байгаа нь эргэн төлөгдөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулж байна. Нэгж хувьцааны үнэлгээг 2020 оны сүүлийн 52 долоо хоногийн дундаж үнэлгээгээр буюу 2,644.57 төгрөгөөр тооцсон байна.

Уг хувьцаа нь МХБ-ийн ТОП-20 индекс, хувьцааны бүртгэлийн II ангилалд багтдаг бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар арилжааны идэвхийн хувьд 1-р байрапд эрэмбэлэгдэж, хөрдөгч арилжаа эхэлсэн 2019 оны 6-р сараар хойш 73.8% өсөлт үзүүлсэн байна.

Эдийн засгийн тодорхойгүй өнөөдрийн нөхцөл байдалд хөрөнгө оруулагчид харьцангуй тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой бөгөөд хүлээлттэй байна. Нөгөө талаас макро эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдал нь жижиг хөрөнгө оруулагчид идэвхгүй байх магадлалтай боловч институционал хөрөнгө оруулагчид мөнгөн хөрөнгийн менежмент хэлбэрээр хоёрдогч зах зээлийг дэмжих боломжтой юм.

Андеррайтер нь судалгаа шинжилгээ болон хөндлөнгийн зөвлөх байгууллагуудын дүгнэлт болон холбогдох бусад баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагч "Инвескор ББСБ" ХК-ийн гаргаж буй өрийн хэрэгсэл нь Монголын хөрөнгийн биржээр нээлттэй арилжаалагдах шалгуурыг хангасан бөгөөд мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон нийтэд нээлттэй хүрээнд санал болгох боломжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

Энэхүү дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн итгэл үнэмшилд тулгуурлан хийгдсэн ирээдүйн төсөөлөл, таамаглал, биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа, үнэт цаасны танилцуулга, холбогдох эрсдэл, үпэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

АНДЕРРАЙТЕР
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК-ийг төлөөлж:

Г.УЯНГАХИШИГ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Огноо: 2021 оны 5 сарын 18-ний өдөр

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2021 -02- 03
БҮРТГЭВ-92

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалын хавсралт

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000186924

2016.03.30
/ Бүртгэсэн он сар өдөр /

9010002004
/ Хувийн хэргийн дугаар /

6060854
/ Регистрийн дугаар /

Инвескор ББСБ
/ Хуулийн этгээдийн нэр, хэлбэр /

Хувьцаат компани

Дүрэм
/ Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр
/ шийдвэрийн нэр /

01
/ дугаар /

2016.03.29
/ он, сар, өдөр /

6611	Зээлийн үйл ажиллагаа
/ код /	/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /
6430	Факторингийн үйлчилгээ
6622	Итгэлцлийн үйлчилгээ
6630	Бөгино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
8299	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээлэл өгөх
8619	Төлбөрийн баттлагаа гаргах
/ код /	/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй
/ хугацаа /

1
/ гишүүдийн тоо /

13,839,901.7
/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, сөүл, 10/1, Твин Тауэр-1 байрны зүүн жигүүр 13 давхар, Утас1: 99099593, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 6 сар 11 өдөр

0003

СЭХ
2021 .05. 27
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03
БҮРТГЭВ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Далайжамц овогтой Баясаалан-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2016.03.30	Б.Амартүвшин
2	Дахин өөрчлөлт оруулав.	2019.06.11	Э.Эрдэнэбилэг
1	'Орхон аймаг' Орхон, Баян-Өндөр, 3-р баг, Уурхайчин, 3 хороолол, , 22, 74 тоот байрлах салбар нэгжийг бүртгэв.	2019.07.16	Д.Чулуунтуяа
3	Дүрмийн нэмэл-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2019.10.01	Ж.Нямдорж
4	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо олимп Шангри-Ла тов, Шангри-Ла оффис барилгын 7 давхар, 709 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв.	2020-01-21	М.Монголжин
5	Улаанбаатар Сүхбаатар 2-р хороо сөүл Твин тауэр1, 13 давхар, 402 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв.	2020-01-21	М.Монголжин
6	Улаанбаатар Хан-Уул 3-р хороо үйлдвэр чингисийн өргөн чөлөө Автоланд байр-д байрлах салбар нэгжийг бүртгэв.	2020-01-21	М.Монголжин
7	Улаанбаатар Баянзүрх 19-р хороо да хүрээ гудамж Акума авто засварын 2 давхар-д байрлах салбар нэгжийг бүртгэв.	2020-01-21	М.Монголжин
8	Улаанбаатар Баянзүрх 14-р хороо "Баялаг ундраа" худалдааны төвийн 3-р давхарт-д байрлах салбар нэгжийг бүртгэв.	2020-03-10	М.Монголжин
9	Улаанбаатар Сүхбаатар, 1-р хороо, Санктпетербург, 2-р давхар, 207 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв.	2020-03-10	М.Монголжин
10	Шинэчилсэн дүрэм бүртгэв.	2020.05.28	Г.Хулан
11	Эцсийн емчлөгч 1 оргэн бүртгэв.	2020.05.28	Г.Хулан

2020 .12. 23

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дугаар Шийдвэрийн Хавсралт

ИНВЕСКОР БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ
/Шинэчилсэн найруулга/

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. "Инвескор ББСБ" (Банк бус санхүүгийн байгууллага) ХК (цаашид **"Компани"** гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор нээлттэй буюу хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд юм.

1.2. Энэхүү Дүрмийн зорилт нь Компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор өөрчлөн зохион байгуулах, Компанийн удирдлага, зохион байгуулалт тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн зарчим, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох, Дүрмийн 9.1 дэх хэсэгт заасан төлөөлөн удирдах зөвлөл (цаашид **"ТУЗ"** гэх)-ийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох болон Компанийг татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.3. Компанийн Дүрэм нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн акттай харшлах, зөрчилдөх тохиолдолд Компани нь холбогдох хууль тогтоомжийн актад нийцүүлэн энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэгтэй байна. Энэ тохиолдолд Компани дээрх нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдэгдлийг бүх хувьцаа эзэмшигчдэд хуанлийн 14 хоногийн дотор бичгээр хүргүүлнэ.

2. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

2.1. Компанийн оноосон нэрийг **"ИНВЕСКОР ББСБ" ХК**, англиар **INVESCORE NBFI /Non Banking Financial Institution/ Joint Stock Company** гэнэ. Компани нь хувьцаат компани буюу "ХК" хэлбэртэй байна.

2.2. Компани хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд "ХК" гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

2.3. Компанийн ерөнхий захиргаа, удирдлага оршин байрлаж байгаа хаяг нь Компанийн оршин байгаа хаяг байна.

3. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1. Компани нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зохих тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр дараах үндсэн аж ахуйн үйл ажиллагаануудыг эрхлэн явуулна. Үүнд:

3.1.1. Зээлийн үйл ажиллагаа;

3.1.2. Факторингийн үйлчилгээ үзүүлэх;

3.1.3. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт оруулах;

3.1.4. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.1.5. Итгэлцлийн үйлчилгээ;

СЭХ
2021 -05- 27
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГ
MONGOLIAN STOCK
2021 -02- 03
БҮРТГЭЛ-02

3.1.6. Төлбөрийн баталгаа гаргах.

3.2. Компани нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомжийн акт, Дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.

3.3. Компани нь ТУЗ болон холбогдох хууль тогтоомжийн актад заасан бусад үндэслэлээр Компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа хугацаагүй эрхлэн явуулна. Тусгай зөвшөөрөлтэйгөөр явуулах үйл ажиллагааны хугацаа нь хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаагаар тодорхойлогдоно.

3.4. Дүрмийн 3.1 дэх хэсэгт заагаагүй бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг ТУЗ шийдвэрлэх бөгөөд холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч бүртгүүлснээр үйл ажиллагааг эрхлэн явуулна.

4. КОМПАНИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

4.1. Компанийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрийг Компани үүсгэн байгуулагдсан өдөр гэж тооцно.

4.2. Компани үүсгэн байгуулагдсан өдрөөс эхлэн Хувьцаа Эзэмшигчээс тусгайлан өмчилсөн өөрийн эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх олж, үүрэг хүлээх, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцах, шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, банкинд өөрийн нэр бүхий данстай, бие даасан тайлан баланстай, Дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадвартай байна.

4.3. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд Компани нь хүлээсэн үүргээ өөрийн өмчлөлд байгаа бүх эд хөрөнгөөрөө хариуцах ба Хувьцаа Эзэмшигчдийн өр болон хүлээх үүргийг хариуцахгүй.

4.4. Хувьцаа Эзэмшигч нь Компанид оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээх бөгөөд Компанийн хүлээх эрх, үүрэг, өр, төлбөр шаардах эрхийг хариуцахгүй.

4.5. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрыг Компанийн тухай хуулийн дагуу байгуулах эрхтэй байна. Хараат болон охин компани нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэх бөгөөд тэдгээр нь эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу бие дааж үйл ажиллагаагаа явуулна. Салбар болон төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд Компанийн баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

4.6. Компани нь өөрийн тамга, цорын ганц тэмдэг (лого), бичгийн хэвлэмэл хуудастай байна. Гүйцэтгэх Захирал нь Компанийн тамга ашиглах аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Аливаа албан бичгэн дээр дарагдах Компанийн тамга нь эрх бүхий этгээд, Гүйцэтгэх Захирал эсхүл тэдгээрийн эрх олгосон этгээдийн гарын үсгээр баталгаажигдаж гэрчлэгдэнэ.

4.7. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан зөвшөөрлийг үндэслэн, салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар, нэгжүүд нь тусдаа улсын гэрчилгээ, тамга, тэмдэг, үйл ажиллагааны журамтай байна.

"ИНВЕСКОР БСБ" ХК
InvesCore
6060864 ДД11192
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021.03.27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

5. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

5.2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 82,000,000 (наян хоёр сая) ширхэг байна.

5.3. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 71,727,918 (далан нэгэн сая долоон зуун хорин долоон мянга есөн зуун арван найман) ширхэг байна.

5.4. Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.

5.5. Компани нь давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо. нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.6. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.

5.7. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно. Шаардлагатай тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгөнд шинээр хөрөнгө оруулалт оруулж болно.

5.8. Компани тодорхой нөхцөлөөр хаалттай захилгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.

6. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

6.1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд Компанийн хувьцаа эзэмшигч байна.

6.2. Компаниас хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг хуваарилахаар зарлан мэдэгдсэний дагуу ногдол ашиг авах эрхтэй байна.

6.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшлийн саналын эрхтэй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй байна.

6.4. Дүрмийн 5.7 дах хэсэгт заасан асуудал болон хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.5. Хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байна. Энэ давуу эрхийг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг ТУЗ хүлээнэ.

6.6. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх

"ИНВЕСКОР БББ" ХК
InvesCore CAPITAL
0317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
0060 1119286063
УЛААНБААТАР ХОТ

000348

СЗХ
2021.05.27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГ
MONGOLIAN STOCK
2021-02-03
БҮРТГЭВ-02

саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш хуанлийн 60 хоногийн дотор ТУЗ эсхүл Гүйцэтгэх захиралд гаргаж болно. Санал хүргүүлсэн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66.3 дах хэсэгт заасан нөхцөлийг хангасан саналыг хүргүүлнэ.

6.7. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арван хувиас дээш хувийг эзэмшигч нь Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг жилд нэг удаа тодорхой үндэслэл бүхий шаардлага гарган хийлгэх эрхтэй. Ийнхүү шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч шаардлагын дагуу шалгалт хийсэн аудиторын зардлыг хариуцна.

6.8. Компанийн энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жинлэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй байна.

6.9. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арав буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар ТУЗ-д санал шаардлага гаргах эрхтэй. Ийнхүү санал, шаардлага гаргаж буй хувьцаа эзэмшигч нь санал, шаардлагаа бичгээр гаргах буюу Компанийн тухай хуулийн 61.3 дах хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

6.10. Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

6.11. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй байна.

6.12. Компанийн ТУЗ-ийн гишүүн эсхүл эрх бүхий албан тушаалтан болсон хувьцаа эзэмшигч, дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн хувьцааны арваас дээш хувийг эзэмшдэг бөгөөд түүний буруутай үйл ажиллагааны улмаас Компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хувийн эд хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.

6.13. Энэхүү Дүрэмд тусгагдаагүй хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой бусад харилцааг Монгол Улсын холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн актад заасны дагуу зохицуулна.

7. КОМПАНИ ҮНЭТ ЦААС ГАРГАХ, ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

7.1. Компани нь гаргасан энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас /*опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас*/ гаргаж болно.

7.2. Компани зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

7.3. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

7.4. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060054 ☎ 1112[illegible]
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 05 27
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2021 -02- 03

7.5. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарласан хувьцааны тооноос илүү байж болохгүй.

7.6. Хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

7.7. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа хувьцааны төлбөр нь мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэртэй байж болно.

7.8. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны хорин таван хувиас хэтрэхгүй байна.

7.9. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэрийг Компанийн тухай хуулийн 53.2 дах хэсэгт зааснаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрт худалдаж авах үнэт цаасны төрөл тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

8. КОМПАНИЙН УДИРДЛАГА

8.1. Компанийн эрх бүхий дээд байгууллага нь Хувьцаа Эзэмшигчдийн хурал байна.

8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

8.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна.

8.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах этгээд нь тухайн хурлыг хуралдуулах санал гаргасан этгээд байх бөгөөд түүнийг тухайн хурал хуралдуулах шийдвэрт тусгана.

8.5. Хувьцаа Эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй байна. Үүнд:

8.5.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;

8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;

8.5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

8.5.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх, ТУЗ-ийн өөрчлөн зохион байгуулах төслийг батлах, шийдвэр гаргах;

8.5.5. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;

8.5.6. Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх;

8.5.7. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, эрх хэмжээг тогтоох;

8.5.8. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх шийдвэр гаргах;

8.5.9. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;

8.5.10. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

8.5.11. ТУЗ-өөс хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277120
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 5060063
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 05. 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03
БҮРТГЭВ-02

8.5.12. Компанийн гаргасан хувьцааг буцаан худалдан авахыг зөвшөөрөх;

8.5.13. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн оруулсан бусад асуудлууд;

8.5.14. Хууль тогтоомжийн актад заасан бусад.

8.6. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход саналын эрхийн тоог тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж тодорхойлно.

8.7. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах Дүрмийн 8.5.1-8.5.6 дах заалтуудад заасан асуудлыг саналын эрхтэй хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар, Дүрэм болон холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналын эрхтэй хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8.8. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах тухай нийтэд зарлах, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдээ хүргэх журам"-ын дагуу зохицуулна.

8.9. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын товыг тогтоосноос хойш ТУЗ, Гүйцэтгэх захирал, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэн даруй хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.

8.10. Компанийн саналын эрхтэй хувьцааны дийлэнх олонхийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хэрэв Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг хойшлуулж дахин хуралдах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэн ТУЗ-ийн Дарга гарын үсэг зурна. Тухайн хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй.

8.11. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхи оролцсоноор Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.

8.12. Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурлын бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй ба ажлын 20 өдрийн дотор дахин зарлан хуралдуулна. Хойшлогдсон хурал хуралдахаас хамгийн багадаа ажлын 5 өдрийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээллэнэ.

8.13. Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурал ажлын 20 өдрийн дотор хуралдаж чадаагүй тохиолдолд шинээр хурал товлон зарлаж хурал хүчин төгөлдөр болох ирцийг Дүрмийн 8.10 дах хэсэгт зааснаар тогтооно.

8.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасны дагуу явуулна.

8.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон дараах асуудлыг шийдвэрлэх ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно.

8.15.1. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг нэмэхээс бусад Дүрмийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэсэн найруулгыг батлах;

8.15.2. Компанийг өөрчлөн байгуулах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх.

ИНВЕСКОР КАПИТАЛ ТЦК ХХК
InVesCore
CAPITAL
6117839 ☎ 1119277129
УЛААНБААТАР
InVesCore
FINANCIAL INSTITUTION
6060854 ☎ 1119266063
УЛААНБААТАР ХОТ

000351

9.11.1 Компанийн тухай хуулийн 96.4 дэх хэсэгт заасан тайланг бэлтгэж, хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

9.12. ТУЗ болон түүний дэргэдэх дэд хороод нь батлагдсан үйл ажиллагааныхаа журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна.

9.13. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8, 79.1 дэх хэсэгт заасан шалгуур, шаардлагыг хангасан байна.

9.14. ТУЗ-ийн аль нэг гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон эсхүл нас барсан тохиолдолд түүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль явуулах хүртэл ТУЗ-өөс түр томилно.

9.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Дүрэмд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх тухайн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.

9.16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрх, бүрэн бүрэлдэхүүнийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

9.17. ТУЗ түүний хурлын бүрэн эрх, хуралтай холбоотой асуудлыг Компанийн тухай хууль болон "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу зохицуулна.

10. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО

10.1. ТУЗ нь байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороо, Эрсдэлийн удирдлагын хороодтой байна.

10.2. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасны дагуу байгуулж болно.

10.3. ТУЗ нь хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81.2 дах хэсэгт заасны дагуу томилно.

10.4. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, Компанийн тухай хууль болон энэхүү Дүрэмд заасан асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.

10.5. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх хэмжээ болон үйл ажиллагааны журмыг ТУЗ батална.

11. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

11.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн сонгосон Гүйцэтгэх Захирал (цаашид "**Гүйцэтгэх Захирал**" гэх) хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

11.2. Гүйцэтгэх Захирал нь Компанийг төлөөлж энэхүү Дүрэмд заасан өдөр тутмын үйл ажиллагааг тусгайлсан итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлнэ.

11.3. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.

11.4. Гүйцэтгэх Захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхээ зохистой үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ба энэхүү Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээтэй зөрчилдөх хэлбэрээр ажиллахыг хориглоно. Гүйцэтгэх Захирал нь өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэхдээ үнэнч шударга байж Компанийн эрх, ашиг сонирхлын төргүүнд тавьж ажиллана.

11.5. Гүйцэтгэх Захирал нь дор дурьдсан эрх хэмжээтэй байна. Үүнд:

11.5.1. Компанийн стратегийн бодлого, дунд хугацааны болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг Компанийн зөрилго, зорилтод нийцүүлэн боловсруулж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

11.5.2. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн систем зэргийг батлагдсан хүрээнд удирдан, зохион байгуулах, тэдгээртэй холбоотой шийдвэр гаргах;

11.5.3. Компанийн үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн хүрээнд эрхлэн явуулах, захиран зарцуулах;

11.5.4. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатайгаас бусад жилийн бизнес төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахад тодорхойлох боломжгүй байсан аж ахуйн болон хөрөнгө оруулалтын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөг хүртэлх зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрх холбоотой мөн тухайн жилийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд нэг нэг буюу хоорондоо шууд хамааралтай хэд хэдэн гэрээ, хэлцлийг байгуулах гэрээ, гарын үсэг зурах, уг эрхээ өөр этгээдэд итгэмжлэлээр олгох;

11.5.5. Зээлийн хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх;

11.5.6. Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой заавар, журам, дүрэм батлан мөрдүүлэх;

11.5.7. Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс шаардсан тайлан, мэдээлэл, баримт бичгийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх;

11.5.8. Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн шүүхийн маргаан, ер барагдуулах үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх болон захиргааны журмаар шийдвэрлүүлэх аливаа ажиллагаанд Компанийг төлөөлөн оролцож, асуудлыг шийдвэрлэх, энэ талаар өмгөөлөгч болон бусад тусгайлан эрх авсан холбогдох этгээдүүдтэй гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх этгээдэд итгэмжлэл олгох, эрх ашгийг хамгаалах холбогдох арга хэмжээг авах;

11.5.9. Компанийн үндсэн болон гэрээт ажиллагсдыг ажилд авах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ болон бусад төрлийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, урамшуулах, Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтанд хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авах, холбогдох гэрээний дагуу хариуцлага тооцох;

11.5.10. Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарахаас бусад Компанийн эрх бүхий албан тушаалтан, салбар, төлөөлөгчийн газрын гүйцэтгэх удирдлагыг бие даан томилох, чөлөөлөх, бүрэн эрх хэмжээг тогтоох, ажлын байрны тодорхойлолтыг батлах, шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлөх, тэдгээрийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх.

11.6. Гүйцэтгэх Захирал нь дор дурьдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

11.6.1. Компанийн дүрэм, Хувьцаа Эзэмшигчийн хурал, ТУЗ-өөс батлагдсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, Компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах;

СЗХ
2021 ОНЫ 27 ДУГ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-02-03

11.6.2. Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Банк бус санхүүгийн байгууллагад холбогдох хууль, тогтоомж, журам болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны шаардлагад бүрэн нийцүүлж ажиллах;

11.6.3. Хувьцаа Эзэмшигч болон ТУЗ-ийн шийдвэр, тогтоол, Компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

11.6.4. Санхүүгийн тайлан бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв гаргуулах;

11.6.5. Хөлсөөр ажиллах гэрээгээр тогтоосон үүргийг биелүүлэх.

11.7. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр Компанийн нэгдлийн оролцогчид хамаарахгүй этгээдийн гүйцэтгэх удирдлагаар ажиллахыг хориглоно.

11.8. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас, Компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.

11.9. Гүйцэтгэх захирал нь бүрэн эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

12. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

12.1. ТУЗ нь Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

12.2. Компанийн ТУЗ-өөс хэрэгжүүлэх хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

12.2.1. Гүйцэтгэх Захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт;

12.2.2. Компанийн ТУЗ-ийн баталсан Компанийн стратеги, дунд болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийн биелэлт;

12.2.3. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны төлөвлөгөөний биелэлт, бүрдүүлэлт;

12.2.4. Компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар тогтоосон Гүйцэтгэх Захирлын эрх хэмжээний хэрэгжилт;

12.2.5. Компанийн Хувьцаа Эзэмшигч болон ТУЗ-ийн гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилт.

12.3. Дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн хурлаас батална.

12.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.

12.5. Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн шийдвэр, Компанийн энгийн хувьцааны арван хувиас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдий ч хийж болно. Аль нэг хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг Компани хариуцан төлнө. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигч хуулийн этгээд, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

12.6. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг холбогдох дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Компанийн дотоод хяналт хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК"
InvesCore CAPITAL
6317839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР ЕБСЕ" ХК
InvesCore
6060354 ☎1119280063
УЛААНБААТАР ХОТ

000356

СЗХ
2021 05 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -02- 03

13. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

13.1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс) эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр (сүүлийн жилийн хувьд Компанийн үйл ажиллагааг зогсоосон өдөр) дуусна.

13.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар болон бусад албан татвар, гаалийн хураамж, газрын төлбөр болон бусад төлбөр хураамжийг төлнө.

13.3. Компани нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу санхүү, нягтлан бодох бүртгэлээ хөтөлж холбогдох тайлан, балансыг татвар, санхүүгийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлнэ.

13.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх Захирал хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

13.5. Компани нь Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн зөв магадлал, хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

13.6. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.

13.6.1. Ногдол ашиг хуваарилсны дараа Компани төлбөрийн чадвартай байх;

13.6.2. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

13.6.3. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ Хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх Захирал хэрэгжүүлнэ.

13.6.4. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон нийгэмд хандсан арга хэмжээ зохион байгуулах, сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг Хувьцаа Эзэмшигч шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх Захирал боловсруулан ТУЗ-д танилцуулж, батлуулж мөрдөнө.

13.7. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ нь энэ тухай шалтгааныг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

13.8. ТУЗ нь Ногдол ашиг хуваарилах болон түүнтэй холбоотой бусад харилцааг Компанийн Ногдол ашгийн бодлогод заасны дагуу зохицуулна.

14. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

14.1. Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх Захирал, Ерөнхий нягтлан бодогч, Газрын захирлууд болон Зээлийн хорооны гишүүд нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

ИНВЕСКОР ББСБ ХК
InvesCore
6117839 ☎ 11192771
УЛААНБААТАР ХОТ

000357

ИНВЕСКОР ББСБ ХК
InvesCore
6060854 ☎ 11192766003
УЛААНБААТАР ХОТ

14.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ажилтантай байгуулсан гэрээ, холбогдох бусад журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

14.3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь томилогдсоноос хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад өгөх ба уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүр уг мэдээллийг Компанид мэдэгдэнэ. Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт гаргах зааврыг ТУЗ батална.

15. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

15.1. Компанийн тухай хуульд зааснаар Компанийг хуваах, тусгаарлах, болон өөр хуулийн этгээдэд нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулж болно.

15.2. Компанийг Хувьцаа Эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгаж болно.

15.3. Хувьцаа Эзэмшигчдийн хурал нь татан буулгах комиссыг томилно.

15.4. Татан буулгах комисс томилсноор тухайн Компанийн бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.

15.5. Татан буулгах комисс нь татан буулгах ажлыг бүрэн гүйцэтгэсний дараа тайлан гаргана.

15.6. Татан буулгах комиссоос зээлдүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгө нь Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгогдоно.

15.7. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасны дагуу ажиллан, Компанийг улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэлээс хасалт хийлгэснээр татан буугдах ажиллагаа дуусгавар болгоно.

15.8. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцан арилгана.

16. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

16.1. Энэхүү Дүрэм, Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн Хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэж чадаагүй, эсхүл тухайн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй холбоотой аливаа маргааныг гагцхүү шүүхээр шийдвэрлүүлнэ.

17. БУСАД ЗҮЙЛ

17.1. Компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс батлагдсан холбогдох заавар, журмыг мөрдөн ажиллана.

17.2. Энэхүү Дүрэм нь бүртгэх байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

ИНВЕСКОР ББСБ ХК

СЭХ 2021.09.27
МОНГОЛЫН ХӨРӨНГӨНИЙ БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-02-03
ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК ХХК InvesCore CAPITAL 6317830 1119277120 УЛААНБААТАР ХОТ
2020.12.28
"ИНВЕСКОР ББСБ" ХК InvesCore 6317830 1119277120 УЛААНБААТАР ХОТ
000358